

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 7380 дугаарт бүртгэв.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 9 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар А/249

Улаанбаатар
хот

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааг зохицуулах Иргэний нисэхийн дүрэм болох “ИНД-108 Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Иргэний нисэхийн дүрмийг мөрдөж, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн шаардлагатай тохиолдолд боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр), энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газар (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Багц дүрэм батлах тухай” 187 дугаар тушаалын 8 дугаар хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-8 “Агаарын навигацийн аюулгүй ажиллагаа, үр өгөөж, зохицуулалтыг хангах, агаарын хөлөг болон зорчигч, эд зүйлсийн аюулгүй байдлыг хангах, учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх”-ийн “ИНД-108 Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр”-ийг бүхэлд нь хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2025 оны 9 дүгээр сарын
30-ны өдрийн А/249 дүгээр тушаалын хавсралт*

ИНД-108 Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр

А Бүлэг - Ерөнхий зүйл

108.1. Зорилго

(а) Энэ дүрмээр ИНД-119 Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт (цаашид “ИНД-119” гэх) болон ИНД-129 Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт (цаашид “ИНД-129” гэх)-д шаардсан агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн зохицуулалтын шаардлагыг тогтооно.

108.3. Нэр томьёо ба товчлол

(а) Энэ дүрэмд хэрэглэсэн нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбарт тусгасан.

В Бүлэг - Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн шаардлага

108.51. Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр

(а) Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь дараах шаардлагыг тогтооно:

(1) агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, эсхүл гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ дүрмийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлыг бусад байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэхээр бол тухайн гэрээт, эсхүл бусад байгууллага нь тухайн агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн шаардлагыг хангаж байгааг бататгах гэрээний нөхцөл;

(2) энэ дүрмийн 108.59-д заасан журмын дагуу ажилтнуудын сургалт хариуцсан этгээдийн дэлгэрэнгүй мэдээлэл;

(3) дараах дэлгэрэнгүй мэдээлэл:

(i) 108.53-д заасан орон нутгийн аюулгүйн хамгаалалтын шаардлага;

(ii) 108.55-д заасан олон улсын аюулгүйн хамгаалалтын шаардлага;

(iii) 108.57-д заасан агаарын хөлгийн нислэгт олгох зөвшөөрөл;

(iv) 108.59-д заасан ажилтнуудын сургалт;

(v) 108.61-д заасан зөрчлийг мэдээлэх болон тайлан гаргах.

108.53. Аюулгүйн хамгаалалтын шаардлага - Орон нутаг

(а) Орон нутгийн агаарын тээврийн зорчигч үйлчилгээний тогтмол нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын

хөтөлбөр нь Монгол Улсад гүйцэтгэж байгаа нислэгийн зорчигч, багийн гишүүд, газрын үйлчилгээний ажилтан, агаарын хөлөг болон байгууламжийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах аюулгүйн хамгаалалтын зохицуулалтыг багтаасан байна.

(б) Энэ зүйлийн (а)-д шаардсан аюулгүйн хамгаалалтын зохицуулалт нь:

(1) агаарын хөлгийн бүхээгт галт зэвсэг тээвэрлэхэд ИНД-91 Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм (цаашид “ИНД-91” гэх)-ийн 91.9-ийн шаардлагыг хангах;

(2) агаарын хөлгийг булаах, тэсрэх бөмбөгөөр заналхийлэх, эсхүл бусад хөндлөнгийн хууль бус үйлдлийн заналхийлэл бий болсон үед агаарын тээвэрлэгчийн зорчигч, багийн гишүүд болон газрын үйлчилгээний ажилтанд учрах аюулыг багасгах;

(3) тухайн агаарын хөлгийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс сэргийлэх зорилгоор агаарын тээвэрлэгчийн хяналтгүй орхисон агаарын хөлөгт нэвтрэх үйлдэлд байнга хяналт тавих;

(4) Монгол Улсад аюулгүйн хамгаалалттай аэродромын хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс болон бусад аэродромын үйл ажиллагааны бүсэд агаарын тээвэрлэгчийн байгууламжаар дамжин нэвтрэх, эсхүл агаарын тээвэрлэгчийн зорчигч, ажилтан, тээш, ачаа, багц ачаа, эсхүл агаарын хөлгийн хангалтад ашигладаг бусад хаалгаар дамжин нэвтрэх үйл ажиллагаанд хяналт тавих;

(5) тухайн агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөр тээвэрлэхээр төлөвлөж байгаа тээш, ачаа, илгээмж, шуудан, агаарын хөлгийн хангалт, нөөц болон агаарын тээвэрлэгчийн хангамжийн эд зүйлсэд зохих аюулгүйн хамгаалалтын хяналт тавих;

(6) хэрэв тухайн агаарын хөлгийн бүхээгт хуулийн дагуу саатуулагдсан, эсхүл хууль хяналтын байгууллагын хяналтад зорчих шаардлагатай нэг, эсхүл хэд хэдэн этгээдийг тээвэрлэх бол тэднийг харгалзагчтай байхыг шаардсан эсэхээс үл хамааран, нислэгийг аюулгүй гүйцэтгэх нөхцөлийг хангаж, агаарын хөлгийн даргад мэдэгдэх;

(7) хэрэв зорчигч тухайн агаарын хөлөгт суугаагүй бол агаарын тээвэрлэгч болон агаарын хөлгийн дарга эрсдэлийг үнэлж, агаарын хөлөгт байгаа зорчигчийн тээшийг тээвэрлэх эсэхийг шийдэх;

(8) Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч (цаашид “Дарга” гэх) хөндлөнгийн хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодисыг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт авч орохоос сэргийлэх зорилгоор бүх зорчигч, багийн гишүүд болон тэдгээрийн гар тээшинд аюулгүйн үзлэг

хийхийг шаарддаг бол тэдгээрийг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн бүхээгт орохын өмнө 108.63-ын дагуу аюулгүйн үзлэг, шалгалт хийх;

(9) Дарга хөндлөнгийн хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодис агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт ачигдахаас сэргийлэх зорилгоор гар тээшнээс бусад бүх тээшинд аюулгүйн үзлэг хийхийг шаарддаг бол тэдгээрийг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт ачихын өмнө 108.63-ын дагуу аюулгүйн үзлэг, шалгалт хийх;

(10) хэрэв Дарга агаарын хөлөгт байгаа этгээд, эсхүл агаарын хөлөг, эсхүл аэродромд учрах аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн түвшин нэмэгдсэнийг илрүүлсэн, эсхүл сэжиглэж байгаа бөгөөд энэ нь орон нутгийн нислэгийн үйл ажиллагаанд хамгаалалтын нэмэлт арга хэмжээг шаардаж байгаа бол тухайн агаарын тээвэрлэгчийн үйлчилгээний аюулгүйн хамгаалалтыг сайжруулах хамгаалалтын түр арга хэмжээг авах;

(11) нислэгийн үед агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс сэргийлэх.

(с) Энэ зүйлийн (b)(6)-г хангах зорилгоор агаарын тээврийн зорчигч үйлчилгээний тогтмол нислэгээр хуулийн дагуу саатуулагдсан этгээдийг тээвэрлэхтэй холбоотой дараах арга хэмжээг багтаасан журамтай байна:

(1) тухайн этгээд нь харгалзагчтай байх;

(2) харгалзагч нь тухайн этгээд зэвсэг болгон ашиглаж болох эд зүйл авч яваагүй болохыг бататгах;

(3) харгалзагч нь тухайн этгээдийн үйлдлийг хязгаарлахад тохирох хэрэгслээр тоноглогдсон байх;

(4) тухайн этгээдийн суудлын байрлал, аюулгүйн хамгаалалтын зохицуулалтын талаар агаарын хөлгийн дарга болон бүхээгийн ахлах ажилтанд мэдэгдэх;

(5) тухайн этгээд болон түүний харгалзагчид согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх;

(6) тухайн этгээдийн хэрэглээнд металл хэрэгсэл ашиглахгүй байх;

(7) тухайн этгээдийг ослын гарцын зэргэлдээх суудал, эсхүл эгнээнд суулгахгүй байх;

(8) тухайн этгээдийг, нислэг аюулгүй үйлдэх нөхцөлийг бүрдүүлсэн суудалд суулгах;

(9) 29, эсхүл түүнээс цөөн зорчигчийн суудлын багтаамжтайгаар гэрчилгээжсэн агаарын хөлөгт нэгээс дээшгүй саатуулагдсан этгээдийг тээвэрлэх ба зорчигчийн суудлын багтаамжийн нэмэлт 25 суудал бүрд

нэгээс дээшгүй саатуулагдсан этгээдийг нэмж тээвэрлэх;

(10) агаарын хөлгийн бүхээгт 2 болон түүнээс дээш тооны зэвсэгтэй ажилтан явах тохиолдолд агаарын тээвэрлэгч нь тэдэнд суудлын байрлалыг нь мэдэгдэх.

108.55. Аюулгүйн хамгаалалтын шаардлага - Олон улс

(а) Олон улсын агаарын тээврийн зорчигч үйлчилгээний тогтмол нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь Монгол Улсад, эсхүл Монгол Улсаас гүйцэтгэж байгаа нислэгийн зорчигч, багийн гишүүд, газрын үйлчилгээний ажилтан, агаарын хөлөг болон байгууламжийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах аюулгүйн хамгаалалтын зохицуулалттай байна.

(b) Энэ зүйлийн (а)-д шаардсан аюулгүйн хамгаалалтын зохицуулалт нь:

(1) агаарын хөлгийн бүхээгт галт зэвсэг тээвэрлэхэд ИНД-91-ийн 91.9-ийн шаардлагыг хангах;

(2) агаарын хөлгийг булаах, тэсрэх бөмбөгийн заналхийлэл, эсхүл хөндлөнгийн хууль бус үйлдлийн бусад заналхийлэл бий болсон үед агаарын тээвэрлэгчийн зорчигч, багийн гишүүд болон газрын үйлчилгээний ажилтанд учрах аюулыг багасгах;

(3) агаарын тээвэрлэгчийн хяналтгүй орхисон агаарын хөлгийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс сэргийлэх зорилгоор тухайн агаарын хөлөгт нэвтрэх үйл ажиллагаанд байнгын хяналт тавих;

(4) Монгол Улсын доторх аюулгүйн хамгаалалттай аэродромын хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс болон бусад аэродромын үйл ажиллагааны бүсэд агаарын тээвэрлэгчийн байгууламжаар дамжин нэвтрэх, эсхүл агаарын тээвэрлэгчийн зорчигч, ажилтан, тээш, ачаа, багц ачаа, эсхүл агаарын хөлгийн хангалтад ашигладаг бусад хаалгаар дамжин нэвтрэх үйл ажиллагаанд хяналт тавих;

(5) хэрэв Дарга агаарын хөлөгт байгаа этгээд, эсхүл агаарын хөлөг, эсхүл аэродромд учрах аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн түвшин нэмэгдсэнийг илрүүлсэн, эсхүл сэжиглэж байгаа бөгөөд энэ нь аюулгүйн хамгаалалтын нэмэлт арга хэмжээ авахыг шаардаж байгаа бол Монгол Улсад, эсхүл Монгол Улсаас нислэг үйлдэж байгаа агаарын тээвэрлэгчийн үйлчилгээний аюулгүйн хамгаалалтыг сайжруулах түр арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

(6) энэ зүйлийн (с)-г харгалзан, агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөр тээвэрлэхээр төлөвлөж байгаа тээш, ачаа, илгээмж болон шууданд зохих аюулгүйн хамгаалалтын хяналт тавих;

(7) хэрэв тухайн агаарын хөлгийн бүхээгт хуулийн дагуу саатуулагдсан, эсхүл хууль хяналтын байгууллагын хяналтын дор

зорчих шаардлагатай нэг, эсхүл хэд хэдэн этгээдийг тээвэрлэх бол тэднийг харгалзагчтай байхыг шаардсан эсэхээс үл хамааран, нислэгийг аюулгүй гүйцэтгэх нөхцөлийг хангаж, агаарын хөлгийн даргад мэдэгдэх;

(8) агаарын хөлгийн бүхээгт зорчигч зөвшөөрөлгүй эд зүйл авч орохоос сэргийлж дамжин өнгөрөх, эсхүл шилжин суух зорчигч болон зорчигчийн гар тээшинд хяналт тавих;

(9) дараахаас бусад тохиолдолд, дамжин өнгөрөх нислэгээс буусан зорчигчийн үлдээсэн эд зүйлийг агаарын хөлгөөс гаргах, эсхүл нислэг эхлэхийн өмнө бусад арга хэмжээг зохих хэлбэрээр авах:

(i) тухайн нислэг эхэлсэн улсын зорчигчийн аюулгүйн үзлэг, шалгалтын ажиллагаа нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц бол; эсхүл

(ii) тухайн нислэг нь хуваарьт бус буулт хийж байгаа бол.

(10) агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөр тээвэрлэхээр аэродромын дотор шилжүүлэх тээш, ачаа, шуудан, агаарын хөлгийн хангалт, нөөц болон агаарын тээвэрлэгчийн хангамжийн эд зүйлсэд аюулгүйн хамгаалалтын хяналт тавих;

(11) ачаа, эсхүл шуудангаас бусад, гэхдээ агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөр тээвэрлэхээр төлөвлөж байгаа илгээх барааны баглаа боодол бүрд (дагалдаагүй, эсхүл арилжааны буухиа хүргэлтийн үйлчилгээ ашиглаж байгаагаас үл хамааран) аюулгүйн үзлэг, шалгалт хийх;

(12) хөндлөнгийн хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай эд зүйл, эсхүл бодисыг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт авч орохоос сэргийлэх зорилгоор бүх зорчигч, багийн гишүүд болон тэдгээрийн гар тээшинд агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн бүхээгт орохын өмнө 108.63-ын дагуу аюулгүйн үзлэг, шалгалт хийх;

(13) агаарын хөлөгт суугаагүй зорчигчийн тээшийг энэ зүйлийн (17)-д шаардсаны дагуу тээвэрлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тээвэрлэхээс сэргийлэх;

(14) тухайн чиглэлийн агаарын хөлөгт, хөндлөнгийн хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, бусад аюултай эд зүйл, эсхүл бодисыг нууж болох сэжигтэй эд зүйл, эсхүл хэвийн бус байдлыг илрүүлэх журмын дагуу нислэгийн өмнөх үзлэг хийх;

(15) хэрэв нисэх буудлын бүртгэлийн цэгээс өөр газраас эхлэлтэй тээшийг зорчигчийн нислэгээр тээвэрлэх бол бүртгэсэн цэгээс агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн бүхээгт байрлуулах хүртэл тээшинд аюулгүйн хамгаалалтын хяналт тавих;

(16) энэ зүйлийн (h)-д зааснаас бусад тохиолдолд, хөндлөнгийн хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл

бусад аюултай эд зүйл, эсхүл бодисыг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт ачихаас сэргийлэх зорилгоор гар тээшнээс бусад тээшин дэх бүх эд зүйлийг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт ачихын өмнө 108.63-ын дагуу аюулгүйн үзлэг, шалгалт хийх;

(17) зөвхөн тухайн агаарын тээвэрлэгчийн зөвшөөрсөн тээшийг тээвэрлэх;

(18) нислэгийн үед агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс сэргийлэх.

(с) Дараахаас бусад тохиолдолд, агаарын тээвэрлэгч нь зорчигч тээвэрлэж байгаа агаарын хөлөгт ачаа, эсхүл шуудан ачихыг зөвшөөрдөггүй байх үүрэгтэй:

(1) ачаа, эсхүл шууданг ИНД-109 Зохицуулалттай агаарын ачааны байгууллагын гэрчилгээжүүлэлт (цаашид “ИНД-109” гэх)-ийн дагуу гэрчилгээжсэн зохицуулалттай агаарын ачааны байгууллагаас хүлээн авсан ба тухайн ачаа, эсхүл шуудангаар илгээх бараанд:

(i) зохицуулалттай агаарын ачааны байгууллагаас олгосон аюулгүйн хамгаалалтын мэдэгдэл дагалдсан;

(ii) илгээх бараанд гэмтэл учруулаагүй болохыг бататгах шалгалтыг агаарын тээвэрлэгч хийсэн, эсхүл

(2) хэрэв агаарын тээвэрлэгч нь бусад этгээдээс ачаа, эсхүл шуудан хүлээн авахыг зөвшөөрч байгаа бол тухайн ачаа, эсхүл шууданд энэ зүйлийн (d)-д заасны дагуу зохих аюулгүйн хамгаалалтын хяналт тавьсан, эсхүл

(3) энэ зүйлийн (с)(1) болон (2)-т заасныг үл харгалзан, хэрэв Даргаас ачаа, эсхүл шууданд аюулгүйн үзлэг хийх чиглэл өгсөн бол тухайн ачаа, эсхүл шууданд өгөгдсөн чиглэлийн дагуу аюулгүйн үзлэг, шалгалт хийж, аюулгүй хэлбэрээр хадгалсан.

(d) Хэрэв агаарын тээвэрлэгч нь бусад этгээдээс ачаа, эсхүл шуудан хүлээн авахыг зөвшөөрдөг бол тухайн агаарын тээвэрлэгч энэ зүйлийн (с)(2)-т шаардсан аюулгүйн хамгаалалтын хяналт нь ИНД-109-ийн шаардлагыг хангаж байгааг бататгах зорилгоор, ИНД-109-ийн дараах шаардлагатай дүйцэх байгууламж болон журамтай байна:

(1) 109.53-д заасан байгууламжид тавигдах шаардлага;

(2) 109.55-д заасан ачаа болон шуудангийн аюулгүйн хамгаалалтын хяналтын журам;

(3) 109.57-д заасан аюулгүйн үзлэг, шалгалт хийх журам;

(4) 109.59-д заасан зөвшөөрөл олгох журам;

(5) 109.61-д заасан бүртгэлтэй харилцагчийг бүртгэх журам;

(6) 109.63-д заасан ажилтны сургалт;

(7) 109.65-д заасан ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчил;

(8) 109.67-д заасан бүртгэл хөтлөх журам.

(е) Энэ зүйлийн (d)-д шаардсан байгууламж болон журмын дэлгэрэнгүй мэдээлэл нь ИНД-119, эсхүл ИНД-129-д шаардсан агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт багтсан байна.

(ф) Энэ зүйлийн (b)(7)-г хангах зорилгоор агаарын тээврийн зорчигч үйлчилгээний тогтмол нислэгээр хуулийн дагуу саатуулагдсан этгээдийг тээвэрлэхтэй холбоотой дараах шаардлагыг бататгах журамтай байна:

(1) тухайн этгээд нь харгалзагчтай байх;

(2) харгалзагч нь тухайн этгээд зэвсэг болгон ашиглаж болох эд зүйл авч яваагүй болохыг бататгах;

(3) харгалзагч нь тухайн этгээдийн үйлдлийг хязгаарлахад тохирох хэрэгслээр тоноглогдсон байх;

(4) тухайн этгээдийн суудлын байрлал, аюулгүйн хамгаалалтын зохицуулалтын талаар хөлгийн дарга болон бүхээгийн ахлах ажилтанд мэдэгдэх;

(5) тухайн этгээд болон түүний харгалзагчид согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх;

(6) тухайн этгээдийн хэрэглээнд металл хэрэгсэл ашиглахгүй байх;

(7) тухайн этгээдийг ослын гарцын зэргэлдээх суудал, эсхүл эгнээнд суулгахгүй байх;

(8) тухайн этгээдийг нислэг аюулгүй үйлдэх нөхцөлийг бүрдүүлсэн суудалд суулгах;

(9) 29, эсхүл түүнээс цөөн зорчигчийн суудлын багтаамжтайгаар гэрчилгээжсэн агаарын хөлөгт нэгээс дээшгүй саатуулагдсан этгээдийг тээвэрлэх ба зорчигчийн суудлын багтаамжийн нэмэлт 25 суудал бүрд нэгээс дээшгүй саатуулагдсан этгээдийг нэмж тээвэрлэх;

(10) агаарын хөлгийн бүхээгт хоёр болон түүнээс дээш тооны зэвсэгтэй ажилтан явах тохиолдолд агаарын тээвэрлэгч нь тэдэнд суудлын байрлалыг нь мэдэгдэх.

(g) Олон улсын нислэг үйлддэг агаарын тээвэрлэгчийн нэрийн өмнөөс зорчигч, эсхүл тээшний бүртгэл, эсхүл олон улсын агаарын тээврийн зорчигч үйлчилгээний тогтмол нислэгт дамжуулан тээвэрлэлтийг орон нутгийн нислэг үйлддэг агаарын тээвэрлэгч гүйцэтгэдэг бол тухайн олон улсын нислэг үйлддэг агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг мөрдөж байгааг бататгана.

(h) Дарга тухайн тээшинд аюулгүйн үзлэг, шалгалт хийхийг шаардсанаас бусад тохиолдолд, энэ зүйлийн (b)(16) нь олон улсын дамжин өнгөрөх болон шилжин ачигдах тээшинд хамаарахгүй.

(i) Энэ зүйлийн (c)(1) болон (2)-ын шаардлага нь дараах ачаа, эсхүл шууданд хамаарахгүй:

(1) илгээж байгаа дипломат байгууллагын албан ёсны гарын үсэгтэй албан тоот дагалдсан, түүний шинж чанарыг таних гадна тэмдэглэгээтэй, дипломат хайрцагт тээвэрлэж байгаа дипломат шуудан; эсхүл

(2) олон улсын дамжин өнгөрөх болон шилжин ачигдах ачаа, эсхүл шуудан.

108.57. Нислэгт олгох аюулгүйн хамгаалалтын зөвшөөрөл

(а) Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа агаарын хөлөгт Монгол Улсын аэродромоос нисэн гарах зөвшөөрөл өгөхийн өмнө тухайн нислэгт холбогдох аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг хангасан болохыг бататгасан байна.

108.58. [Хүчингүй болгосон]

108.59. Ажилтны сургалт

(а) Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт дараах зохицуулалтыг тусгасан байна:

(1) аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээсэн ажилтнууд нь үүргээ чадварлагаар гүйцэтгэхэд хангалттай сургалтад хамрагдсан байх;

(2) тухайн агаарын хөлгийн техник үйлчилгээ болон бусад үйлчилгээнд оролцож байгаа ажилтнууд нь агаарын тээвэрлэгч болон нисэхийн аюулгүйн хамгаалалтын талаар үндсэн мэдлэгтэй байх;

(3) сургалтыг агаарын тээвэрлэгчээс зөвшөөрөгдсөн этгээд зохион байгуулсан байх;

(4) сургалтад хамрагдсан байх этгээд нь сургалтын хөтөлбөрийн дагуу давтан сургалтад 3 жилээс хэтрэхгүй давтамжтай хамрагдах.

(b) Энэ зүйлийн (а)-д заасан зохицуулалт нь дараах мэдээллийг агуулсан байна:

(1) анхан шатны сургалт болон давтан сургалтын холбогдох үе шат;

(2) тухайн зохион байгуулсан сургалтад тохирох мэдлэгийн шалгалт, эсхүл ур чадварын үнэлгээ;

(3) холбогдох аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг тус бүрээр сургалтын хөтөлбөрийн задаргаа.

108.60. Бүртгэл хөтлөх

(а) Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь 108.59-ийн дагуу сургалтад хамрагдах этгээдийн бүртгэлийг хөтлөхөд шаардлагатай тухайн бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах дараах дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан зохицуулалттай байна:

(1) гүйцэтгэж байгаа сургалтын үе шат бүрийн;

(2) тухайн зохион байгуулсан сургалтад тохирох мэдлэгийн шалгалт, эсхүл ур чадварын үнэлгээний.

108.61. Зөрчлийг мэдээлэх

(а) Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь тухайн агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгтэй холбоотой аюулгүйн хамгаалалтын зөрчлийн талаар ИНД-12 Осол, зөрчлийн мэдээлэл дүрмийн дагуу Даргад мэдэгдэх, хэрэв хамааралтай бол тайлан гаргах зохицуулалттай байна.

108.63. Аюулгүйн үзлэг, шалгалт

(а) Энэ дүрмийн 108.53 болон 108.55-д заасан зорчигч, багийн гишүүд, тээш, ачаа болон шууданд хийх аюулгүйн үзлэг, шалгалтыг дараах байгууллага гүйцэтгэнэ:

(1) Монгол Улсаас, эсхүл Монгол Улсад агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа тохиолдолд ИНД-140 Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт дүрмийн дагуу олгосон нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч;

(2) бусад улсын аэродромоос Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа тохиолдолд нисэн гарах улсын холбогдох эрх бүхий байгууллагаас аюулгүйн үзлэг, шалгалт хийхээр зөвшөөрөгдсөн байгууллага.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 7381 дүгээрт бүртгэв.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар А/253

Улаанбаатар
хот

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын хөлгөөр аюултай барааг тээвэрлэх болон зохицуулалттай агаарын ачааны байгууллагыг гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг зохицуулах Иргэний нисэхийн дүрэм ИНД-92 “Аюултай бараа тээвэрлэх”-ийг нэгдүгээр хавсралтаар, ИНД-109 “Зохицуулалттай агаарын ачааны байгууллагын гэрчилгээжүүлэлт”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Иргэний нисэхийн дүрмийг мөрдөж, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр), энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газар (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Багц дүрэм батлах тухай” 187 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-6 “Агаарын хөлгийг зорчигч, тээш, ачаа тээвэрлэх болон бусад зориулалтаар ашиглах”-ын “ИНД-92 Аюултай бараа тээвэрлэх” дүрмийг, 8 дугаар хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-8 “Агаарын навигацийн аюулгүй ажиллагаа, үр өгөөж, зохицуулалтыг хангах, агаарын хөлөг болон зорчигч, эд зүйлсийн аюулгүй байдлыг хангах, учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх”-ийн ИНД-109 “Зохицуулалттай агаарын ачааны байгууллагын гэрчилгээжүүлэлт” дүрмийг тус тус бүхэлд нь хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний
өдрийн А/253 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

ИНД–92 Аюултай бараа тээвэрлэх

А Бүлэг - Ерөнхий зүйл

92.1. Зорилго

(а) Энэ дүрмээр аюултай барааг агаараар тээвэрлэх зохицуулалтын шаардлагыг тогтооно.

92.2. Хамрах хүрээ

(а) Энэ дүрэм нь дараах эд зүйл, эсхүл бодист хамаарахгүй:

(1) Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын баримт бичиг “Аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх техникийн зааварчилгаа” (ICAO Doc 9284, цаашид “Техникийн зааварчилгаа” гэх)-ны 1 дүгээр Бүлгийн дагуу хасагдсан; эсхүл

(2) нислэгт тэнцэх чадварын, эсхүл Иргэний нисэхийн дүрэм (цаашид “ИНД” гэх)-ийн нислэгийн үйл ажиллагааны шаардлагын дагуу агаарын хөлөгт байхыг шаардсан; эсхүл

(3) нислэгийн үйл ажиллагааны тусгай шаардлагыг хангах зорилгоор Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч (цаашид “Дарга” гэх)-ийн зөвшөөрсөн.

(б) Энэ зүйлийн (а)(2), (3)-т хамаарах, агаарын хөлгийн эд ангийн нөхөн орлуулах зориулалттай эд зүйл, эсхүл бодисыг агаарын тээвэрлэгч Техникийн зааварчилгааны Бүлэг 1-ийн Хэсэг 2.2-ын дагуу илгээхээс бусад тохиолдолд энэ дүрмийн дагуу тээвэрлэх үүрэгтэй.

92.3. Нэр томьёо ба товчлол

(а) Энэ дүрэмд хэрэглэсэн нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбарт тусгасан.

92.5. Нөөц

92.7. Тээвэрлэлтийн ерөнхий шаардлага

(а) Аюултай барааны ангилал, баримт бичиг, гэрчилгээ, тодорхойлолт, баглаа боодол, тэмдэглэгээ болон аюулын шошгыг Техникийн зааварчилгааны дагуу бүрдүүлсэн ба тэдгээр нь Техникийн зааварчилгаанд заасан илгээх нөхцөлийг хангаж байгаагаас бусад тохиолдолд аливаа тгээд аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгох, эсхүл хүлээн авахыг хориглоно.

(б) Аливаа этгээд нь аюултай барааг Техникийн зааварчилгаа, эсхүл энэ дүрмийн шаардлагын дагуу хүлээн авсан, тээвэрлэлтэд бэлтгэсэн болон тээвэрлэснээс бусад тохиолдолд тухайн барааг агаараар тээвэрлэхгүй.

(с) Аюултай барааг агаараар тээвэрлэх, тээвэрлүүлэх үйл ажиллагаа эрхлэгч болон томилогдсон шуудангийн байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) аюултай бараа тээвэрлэлттэй холбоотой чиг үүргээ гүйцэтгэхэд ашиглах үйл ажиллагааны журам, зааврыг боловсруулж Даргаар батлуулсан байх;

(2) аюултай бараа тээвэрлэлтийн үйл ажиллагаанд шууд оролцох аливаа этгээд нь Даргын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдсан байх.

92.9. Хориглосон аюултай бараа

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, хэрэв аюултай барааг Техникийн зааварчилгааны дагуу аль ч нөхцөлд агаараар тээвэрлэхийг хориглосон бол аливаа этгээд нь тухайн аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгох, эсхүл хүлээн авахыг хориглоно.

(b) Хэрэв Дарга тухайн эд зүйл, эсхүл бодисыг Техникийн зааварчилгаанд заасан аюулгүй байдлын ижил түвшинд хангаж байна гэж үзвэл аливаа этгээд Техникийн зааварчилгааны аюултай барааны жагсаалтын 10, 11 эсхүл 12, 13 дугаар баганад хориотой гэж тодорхойлсон эд зүйл, эсхүл бодисыг агаараар тээвэрлэхийг санал болгох, эсхүл хүлээн авч болно.

(с) Монгол Улсаас эхлэлтэй нислэгээр тээвэрлэгдэх аюултай барааг Техникийн зааварчилгааны шаардлагаас чөлөөлөхгүй.

92.11. Үл хамаарал

(а) [Хүчингүй болгосон]

(b) Дараах тохиолдолд аливаа этгээд нь энэ дүрмийг мөрдөхгүйгээр Ангилал 1 аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгох, эсхүл хүлээн авч болно, хэрэв:

(1) Зөвшөөрөгдсөн гүйцэтгэгч тээвэрлэлт хийхийг зөвшөөрсөн бол;

(2) аюултай барааг:

(i) Зөвшөөрөгдсөн гүйцэтгэгчийн хяналтад тээвэрлэх бол; эсхүл

(ii) Зөвшөөрөгдсөн гүйцэтгэгчийн нөгсөн зааврын дагуу тээвэрлэх ба Зөвшөөрөгдсөн гүйцэтгэгч нь аюултай барааны тээвэрлэлтийн бүх цаг хугацаанд холбогдох дэмжлэг үзүүлэх боломжтой бол;

(3) тухайн барааг тээвэрлэх аюулгүй байдлын болон онцгой нөхцөлийн журмыг тогтоосон бол;

(4) тухайн бараа нь:

(i) агаараар тээвэрлэхэд тохиромжтой нөхцөлд байгаа бол;

(ii) аюулгүй тээвэрлэлтэд зориулан хадгалж, хамгаалсан бол;

(5) агаарын хөлгөөр тухайн нислэгийн зорилгоор зайлшгүй байх

шаардлагатай зорчигчоос өөр зорчигч тээвэрлээгүй бол;

(6) тухайн нислэг нь хот, сум, эсхүл суурингийн шигүү суурьшлын бүсээс зайтай үйлдэгдэх бол.

(с) Дараах тохиолдолд аливаа этгээд нь энэ дүрмийг мөрдөхгүйгээр зорчигчийн амралт зугаалгад ашигладаг аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгох, эсхүл хүлээн авч болно, хэрэв:

(1) аюултай барааг дараах битүүмжлэлгүй агаарын хөлгөөр тээвэрлэх бол:

(i) Гэрчилгээжсэн максимум хөөрөлтийн жин (цаашид “MSTOW” гэх) нь 5700 кг, эсхүл түүнээс доош жинтэй;

(ii) Ил харааны нислэгийн дүрэм (цаашид “VFR” гэх)-ээр орон нутгийн үйлдэх нислэгт;

(2) тухайн аюултай бараа нь Техникийн зааварчилгааны аюултай барааны жагсаалтын зорчигч тээвэрлэж байгаа агаарын хөлөгт тээвэрлэхийг хориглосон жагсаалтад ороогүй;

(3) тухайн аюултай барааг тээвэрлэх аюулгүй байдлын болон онцгой нөхцөлийн журмыг тогтоосон;

(4) тухайн аюултай барааг нэг бүрчлэн таньж тодорхойлсон;

(5) тухайн барааны аюултай шинж чанарыг хөлгийн даргад мэдэгдсэн;

(6) тухайн аюултай бараа нь:

(i) агаараар тээвэрлэхэд тохиромжтой нөхцөлд байгаа бол;

(ii) хэрэв тэдгээр нь хоорондоо аюултайгаар харилцан үйлчлэх магадлалтай бол тусгаарласан байх;

(iii) зөв байрлуулж, хамгаалсан ба хэрэв шаардлагатай бол нислэгт гоожих, эсхүл гэмтэхээс сэргийлж савласан бол;

(7) агаарын хөлөгт зөвхөн тухайн аюултай бараатай хамааралтай зорчигч тээвэрлэж байгаа бол.

92.13. Нисэх багийн гишүүд, эсхүл зорчигчид тавих шаардлага

(а) Техникийн зааварчилгаанд зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа этгээд аюултай барааг биедээ авч явах, эсхүл агаарын хөлөгт аюултай барааг бүртгэгдсэн тээш, эсхүл гар тээшинд тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.

92.15. Барааг тээвэрлэлтэд санал болгох

(а) Эд зүйл, эсхүл бодисыг агаараар тээвэрлэхийг санал болгож байгаа этгээд нь:

(1) хэрэв тухайн эд зүйл, эсхүл бодис нь аюултай бараа биш бол гарын үсэг зурсан дараах баримт бичгийг үйл ажиллагаа эрхлэгчид гаргаж өгнө:

(i) тухайн эд зүйл, эсхүл бодисыг нарийвчлан тодорхойлсон; эсхүл

(ii) тухайн эд зүйл, эсхүл бодис нь аюултай бараа биш гэдгийг мэдэгдсэн;

(2) хэрэв тухайн эд зүйл, эсхүл бодис нь аюултай бараа бол С Бүлгийг дагаж мөрдөнө.

(b) Энэ зүйлийн (a)(1) нь:

(1) шуудангийн эд зүйл, эсхүл

(2) бүртгэгдсэн тээш, эсхүл гар тээшинд хамаарахгүй.

92.17. Аюултай барааг саатуулах

(a) ИНД-12 Осол, зөрчлийн мэдээлэл (цаашид “ИНД-12” гэх)-ийн дагуу мэдээлсэн осол, зөрчилтэй холбоотой агаараар тээвэрлэхийг санал болгосон, эсхүл хүлээн авсан аюултай бараа нь Даргын саатуулсан бараанд тооцогдоно.

(b) Дарга:

(1) энэ зүйлийн (a)-д заасан аль ч барааг задалж, үзлэг, шалгалт хийж болно;

(2) сорилт, дүн шинжилгээ хийх болон нотлох баримт болгох зорилгоор агууламжийн дээжийг авч хадгалж болно.

В Бүлэг - Баглаа боодлын иж бүрдэл хийх, савлах, тэмдэглэх болон шошго зүүх

92.51. Баглаа боодлын иж бүрдэлд тавих шаардлага

(a) Дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд аливаа этгээд нь баглаа боодлын иж бүрдэлд энэ дүрмийн шаардлага хангасан талаар тэмдэглэгээ хийх, шошго зүүх, баталгаажуулах, эсхүл тээвэрлэлтэд санал болгохгүй:

(1) Техникийн зааварчилгааны дагуу үйлдвэрлэсэн, хийсэн, тэмдэглэсэн, хадгалсан, нөхцөлийг сайжруулсан болон засварласны аль тохирохоор;

(2) Техникийн зааварчилгааны дагуу тест хийсэн;

(3) Монгол Улсад үйлдвэрлэсэн баглаа боодлын иж бүрдлийн хувьд:

(i) итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллага тест хийсэн;

(ii) Ангилал 7 аюултай бараанаас бусад нь Даргаар зөвшөөрөгдсөн;

(iii) Ангилал 7 аюултай бараа нь Үндэсний цацраг идэвхт материалын лабораториор зөвшөөрөгдсөн.

(4) Монгол Улсад үйлдвэрлээгүй баглаа боодлын иж бүрдлийн хувьд Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын Хэлэлцэн тохиролцогч Улсад үйлдвэрлэсэн ба тест хийсэн байх.

(b) Энэ зүйлийн (a)(3) болон (4) нь Техникийн зааварчилгаанд тест хийсэн байхыг шаардаагүй баглаа боодолд хамаарахгүй.

92.53. Баглаа боодлын иж бүрдлийн зөвшөөрөл

(а) Энэ дүрмийн 92.51(а)(3)(ii)-ын дагуу зөвшөөрөл авах, эсхүл сунгуулах хүсэлтийг, Техникийн зааварчилгааны дагуу баглаа боодлын иж бүрдлийн үзүүлэлтийн тестийн тайлангийн хамт Даргад хүргүүлнэ.

(b) Энэ зүйлийн (а)-д заасан зөвшөөрлийг дараах тохиолдолд олгож болно, хэрэв:

(1) тухайн баглаа боодлын иж бүрдлийн үзүүлэлтийн тестийн тайлан амжилттай үр дүн харуулж байгаа бол;

(2) хүсэлт гаргагч нь дүрэмд заасан хураамжийг төлсөн.

(с) Энэ зүйлийн (b)-ийн дагуу олгосон зөвшөөрөл нь:

(1) 5 хүртэлх жилийн хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно;

(2) хугацаа дуусах, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй хэвээр байна;

(3) тухайн баглаа боодлын иж бүрдэлд Техникийн зааварчилгааны дагуу байрлуулах тэмдэглэгээг зааж өгнө.

92.55. Савлагаанд тавих шаардлага

(а) Аюултай барааг агаараар тээвэрлэхээр савлаж байгаа этгээд нь:

(1) тухайн барааг Техникийн зааварчилгааны дагуу савлана;

(2) Техникийн зааварчилгаанд өөрөөр зааснаас бусад тохиолдолд тухайн баглаа боодлын иж бүрдэл нь дараах шаардлагыг хангасан байна:

(i) холбогдох тестэд заасны дагуу хэрэглэдэг байх;

(ii) тухайн баглаа боодлын загварын маягтай бүх талаар нийцдэг байх ба дотоод баглаа боодлын хэмжээ, төрөл, савлах аргачлал нь холбогдох тестийн шаардлагыг хангасан байх.

(b) Хэрэв хоосон сав баглаа боодол нь өмнөх агуулж байсан эд зүйл, эсхүл бодисын шинж чанараас шалтгаалан аюул үүсгэж болзошгүй бол, тэдгээрийг сайтар таглаж, үүсгэж болзошгүй аюулын ангилалд нийцүүлэн зохих арга хэмжээ авсан байна.

92.57. Тэмдэглэгээнд тавих шаардлага

(а) Агаараар тээвэрлэх аюултай барааг агуулсан баглаа боодол, эсхүл гадуур боодолд тэмдэглэгээ хийж байгаа этгээд нь тухайн баглаа боодол, эсхүл гадуур боодолд тэмдэглэгээг дараах хэлбэрээр хийнэ:

(1) Техникийн зааварчилгааны дагуу;

(2) дараах байдлаар:

(i) аюултай барааны оноосон нэр (хэрэв тохиромжтой бол техникийн нэрийг нэмэлтээр);

(ii) UN үсгээр эхэлсэн харгалзах UN дугаар;

(iii) аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгосон этгээдийн болон хүлээн авагчийн нэр, хаяг;

(iv) Техникийн зааварчилгаанд заасан бусад тэмдэглэгээ.

(b) Энэ зүйлийн (a)-д заагдсан тэмдэглэгээ нь олон улсын нислэгт англи хэл дээр бичигдсэн байна.

92.59. Шошгонд тавих шаардлага

(a) Агаараар тээвэрлэх аюултай барааг агуулсан баглаа боодол, эсхүл гадуур боодолд шошго тавьж байгаа этгээд нь дараах үүрэгтэй:

(1) баглаа боодол, гадуур боодолд Техникийн зааварчилгааны дагуу шошго тавих;

(2) аюултай гэсэн шошго бүр нь Техникийн зааварчилгааны дагуу тухайн аюулын жинхэнэ шинж чанарыг харуулж байгааг бататгах.

С Бүлэг - Аюултай барааг тээвэрлэлтэд санал болгох

92.101. Зорилго

(a) Энэ Бүлэг нь аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгох зохицуулалтын шаардлагыг тогтооно.

(b) Аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгож байгаа этгээдийн өмнөөс энэ Бүлэгт шаардсан үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа этгээд нь тухайн үйл ажиллагааг энэ Бүлгийн дагуу гүйцэтгэнэ.

92.103. Аюултай барааг тээвэрлэлтэд санал болгох

(a) Аюултай бараа агуулсан баглаа боодол, эсхүл гадуур боодлыг агаараар тээвэрлэхийг санал болгож байгаа этгээд нь дараах шаардлагыг бататгана:

(1) тухайн аюултай барааг Техникийн зааварчилгааны дагуу агаараар тээвэрлэхийг хориглоогүй байх;

(2) тухайн аюултай барааг энэ Бүлгийн дагуу баталгаажуулсан байх;

(3) тухайн аюултай барааг В Бүлэгт заасан хэлбэрээр баглаж боосон, савласан, тэмдэглэсэн болон шошго зүүсэн байх;

(4) хэрэв Техникийн зааварчилгаанд шаардсан бол тухайн аюултай бараанд 92.105-ын дагуу бүрдүүлсэн, гарын үсэг зурсан аюултай барааны тээврийн баримт бичиг дагалдуулсан байх;

(5) тухайн бараа нь Техникийн зааварчилгааны бусад шаардлагыг хангасан байх.

92.105. Аюултай барааны тээврийн баримт бичиг

(a) Аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгож байгаа этгээд нь Техникийн зааварчилгааны дагуу тухайн аюултай барааны дараах мэдээллийг багтаасан тээврийн баримт бичгийг 2 хувь үйлдэж, гарын үсэг зурж баталгаажуулан үйл ажиллагаа эрхлэгчид хүргүүлнэ:

(1) дараах дарааллаар тухайн аюултай барааг зөв дүрсэлсэн:

(i) оноосон нэр;

(ii) ангилал, эсхүл бүлэг (ангилал 1-ийн хувьд нийцлийн группийг багтаасан бүлэг (division));

(iii) UN үсгээр эхэлсэн харгалзах UN дугаар;

(iv) тохирох савлах групп;

(2) аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгож байгаа этгээд гарын үсэг зурсан дараах мэдэгдлийг агуулсан:

[Би, энэхүү илгээх барааны агууламжийг оноосон нэрээр бүрэн гүйцэд, нягт нямбай тодорхойлсон ба олон улсын болон үндэсний холбогдох хууль дүрэмд заасан тээвэрлэлтийн тохирох нөхцөлийн дагуу ангилсан, баглаж боосон, савласан, тэмдэглэсэн, шошго, зурагт хуудас хэрэглэсэн болохыг мэдэгдэж байна.]

(3) Техникийн зааварчилгаанд заасан нэмэлт шаардлагыг хангасан.

(b) Шаардлагатай тохиолдолд энэ зүйлийн (a)(2)-т шаардсан мэдэгдэл нь холбогдох зурагт хуудсанд заасан ишлэлийг дурдахгүй байж болно.

(c) Аюултай барааны тээврийн баримт бичиг нь олон улсын нислэгт англи хэл дээр бичигдсэн байна.

D Бүлэг - Үйл ажиллагаа эрхлэгч

92.151. Зорилго

(a) Энэ Бүлэг нь дараах үйл ажиллагааны шаардлагыг тогтооно:

(1) үйл ажиллагаа эрхлэгч аюултай барааг хүлээн авах, тээвэрлэлтэд бэлтгэх, хадгалах, ачаалах болон үзлэг, шалгалт хийх;

(2) үйл ажиллагаа эрхлэгч тухайн аюултай барааны талаар мэдээллээр хангах.

(b) Үйл ажиллагаа эрхлэгчийн өмнөөс энэ Бүлэгт шаардсан үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа этгээд нь тухайн үйл ажиллагааг энэ Бүлгийн дагуу гүйцэтгэнэ.

(c) Энэ Бүлгийг тухайн үйл ажиллагаа эрхлэгчийг тодорхой эд зүйл, эсхүл бодисыг заавал тээвэрлэхийг шаардсан, эсхүл тээвэрлэх тусгай шаардлага хэрэгжүүлэхээс үйл ажиллагаа эрхлэгчийг чөлөөлсөн гэж тайлбарлаж болохгүй.

92.153. Аюултай бараа хүлээн авах

(a) Үйл ажиллагаа эрхлэгч нь дараахаас бусад тохиолдолд баглаа боодол, гадуур боодол, эсхүл Техникийн зааварчилгаанд зөвшөөрсөн бол аюултай бараа агуулсан ачилтын нэгж төхөөрөмжийг агаараар тээвэрлэхээр хүлээн авахгүй:

(1) Техникийн зааварчилгаанд тухайн баримт бичгийг шаардлагагүй гэж зааснаас бусад тохиолдолд 92.105-д заасан аюултай барааны тээврийн баримт бичгийн 2 хувийг дагалдуулсан;

(2) баглаа боодол, гадуур боодол, эсхүл ачилтын нэгж төхөөрөмжид:

(i) 92.163-ын дагуу үзлэг хийсэн;

(ii) 92.57 болон 92.59-ийн дагуу тэмдэглэж, шошго зүүсэн.

92.155. Хүлээн авах шалгалт

(а) Аюултай барааг агаараар тээвэрлэхээр хүлээн авч байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь:

(1) дараах шаардлагыг бататгах хүлээн авах шалгах хуудсыг ашиглана:

(i) 92.153-ын шаардлага хангасан байх;

(ii) аюултай барааны тээврийн баримт бичиг нь 92.105-ын шаардлага хангасан байх.

(2) хүлээн авах шалгалтын үр дүнгийн бүртгэлийг хөтөлнө;

(3) энэ зүйлийн (2)-т шаардсан бүртгэлийг хамгийн багадаа 6 сарын хугацаанд хадгална.

92.157. Агаарын хөлөгт ачаалах хязгаарлалт

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд үйл ажиллагаа эрхлэгч нь аюултай барааг зорчигчтой агаарын хөлгийн бүхээгт, эсхүл агаарын хөлгийн нислэгийн бүхээгт тээвэрлэхгүй.

(b) Үйл ажиллагаа эрхлэгч нь:

(1) хэрэв Техникийн зааварчилгааны дагуу хийхийг зөвшөөрсөн бол зорчигч, эсхүл нисэх багийн гишүүнийг бүртгэгдсэн тээш, эсхүл гар тээшинд, эсхүл биедээ аюултай бараа авч орохыг зөвшөөрч болно;

(2) хэрэв Техникийн зааварчилгаанд тусгайлсан баглаа боодлоор хийхийг зөвшөөрсөн бол цацраг идэвхт материалыг зорчигчтой агаарын хөлгийн бүхээгт, эсхүл агаарын хөлгийн нислэгийн бүхээгт тээвэрлэхийг зөвшөөрч болно;

(3) хэрэв орон нутгийн нислэг үйлдэх бол тухайн агаарын хөлөг В ангиллын ачааны бүхээгээр тоноглогдоогүй үед дараах аюултай барааг зорчигчийн бүхээгийн ачааны хэсэгт тээвэрлэж болно:

(i) Ангилал 1, Бүлэг 1.4 Групп S-д хамаарах тэсрэмтгий бодис;

(ii) Ангилал 2, Бүлэг 2.2, шатамхай бус, хоргүй хий;

(iii) Ангилал 3, шатамхай шингэн (савлах Групп III);

(iv) Ангилал 4, Бүлэг 4.1 - шатамхай хатуу бодис (савлах Групп III);

(v) Ангилал 5, Бүлэг 5.1 - исэлдэгч бодис (савлах Групп III);

(vi) Ангилал 6, Бүлэг 6.1 - хортой бодис (савлах Групп III);

(vii) Ангилал 7, минимум тусгаарлах зайг ханган ачсан цацраг идэвхт материал;

(viii) Ангилал 8, савлах Групп III бодис;

(ix) Ангилал 9, бусад бараа.

(с) Үйл ажиллагаа эрхлэгч хэрэв тухайн бүхээг нь В ангиллын ачаа, эсхүл тээшний бүхээгт тавих бүх гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хангаж байгаа бол зорчигч тээвэрлэж байгаа агаарын хөлгийн ачааны

үндсэн бүхээгт аюултай барааг тээвэрлэж болно.

(d) Аюултай барааг агаараар тээвэрлэхээр хүлээн авч байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь “Зөвхөн ачааны агаарын хөлөг” гэсэн шошготой аюултай барааны баглаа боодлыг ачааны агаарын хөлөгт ачих үүрэгтэй.

92.159. Хоорондоо үл зохицох аюултай бараа

(a) Аюултай барааг агаараар тээвэрлэхээр хүлээн авч байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь хоорондоо харилцан үйлчилснээр аюултай нөхцөл байдал үүсгэж болох аюултай бараа агуулсан баглаа боодлыг гоожсон тохиолдолд хоорондоо урвалд орж болох байрлалд, эсхүл хамт зэрэгцүүлэн байрлуулахгүй.

92.161. Ялгах, тусгаарлах болон хамгаалах

(a) Аюултай барааг агаараар тээвэрлэхээр хүлээн авч байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь:

(1) хортой болон халдварт бодис агуулсан баглаа боодлыг Техникийн зааварчилгааны дагуу байрлуулна;

(2) цацраг идэвхт материалыг Техникийн зааварчилгааны дагуу хүн, амьтан болон боловсруулаагүй гэрэл зураг, киноны хальснаас тусад нь байрлуулна;

(3) агаарын хөлөгт ачсан аюултай барааг гэмтэхээс хамгаална;

(4) аюултай барааг агаарын хөлөгт, тухайн баглаа боодлын байрлалыг өөрчилж болох нислэгийн хөдөлгөөнөөс сэргийлэх хэлбэрээр бэхэлнэ.

92.163. Ачаалах үеийн үзлэг, шалгалт

(a) Үйл ажиллагаа эрхлэгч нь:

(1) дараахаас бусад тохиолдолд агаарын хөлөгт, эсхүл ачилтын нэгж төхөөрөмжид аюултай бараа агуулсан баглаа боодол, эсхүл гадуур боодлыг ачихгүй:

(i) ачилтын өмнөх үзлэг, шалгалт хийгдсэн байх;

(ii) гоожсон, эсхүл гэмтсэн нотолгоо байхгүй;

(2) ачилтын нэгж төхөөрөмж дараах шаардлагыг хангах хүртэл агаарын хөлөгт тухайн төхөөрөмжийг ачихгүй:

(i) ачилтын өмнөх үзлэг, шалгалт хийсэн байх;

(ii) түүнд агуулагдсан аюултай бараа гоожсон, эсхүл гэмтсэн нотолгоо байхгүй байх.

92.165. Буулгах үеийн үзлэг, шалгалт

(a) Аюултай бараа агуулсан баглаа боодол, эсхүл гадуур боодол тээвэрлэж байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь агаарын хөлгөөс, эсхүл ачилтын нэгж төхөөрөмжөөс баглаа боодол, эсхүл гадуур боодлыг буулгахдаа гоожсон, эсхүл гэмтсэн шинж тэмдэг байгаа эсэхэд үзлэг, шалгалт хийсэн байна.

92.167. Гэмтэл, эсхүл бохирдлыг арилгах

(а) Агаарын хөлгөөс ачаа буулгах үед гэмтсэн, эсхүл гоожсон нотолгоо олж тогтоосон бол үйл ажиллагаа эрхлэгч нь:

(1) аюултай бараа, эсхүл ачилтын нэгж төхөөрөмж байрлаж байсан агаарын хөлгийн тухайн хэсгийн гэмтэл, эсхүл бохирдлыг шалгах үзлэг хийнэ;

(2) аюултай бохирдлыг арилгана.

92.169. Халдварт бодис

(а) Агаарын хөлөгт ачсан халдварт бодис агуулсан баглаа боодол гэмтсэн, эсхүл гоожсон байдалтай байгаа бол үйл ажиллагаа эрхлэгч нь:

(1) тухайн баглаа боодлыг хөдөлгөхөөс зайлсхийнэ, эсхүл аль болох бага хөдөлгөнө;

(2) дэргэдэх баглаа боодлын бохирдлыг шалгах үзлэг, шалгалт хийж, бохирдсон байж болох багцыг тусад нь тавина;

(3) холбогдох эрүүл мэндийн, эсхүл мал эмнэлгийн эрх бүхий байгууллагад мэдэгдэх ба хүмүүст аюул учруулсан байж болох дамжин өнгөрсөн бусад оронд мэдээлэл хүргүүлнэ;

(4) илгээгч, эсхүл хүлээн авагчид мэдээлнэ.

92.171. Цацраг идэвхт материал

(а) Агаараар аюултай бараа тээвэрлэж байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь агаарын хөлөг цацраг идэвхт материалаар бохирдсон тохиолдолд:

(1) тухайн агаарын хөлгийг үйлчилгээнээс яаралтай гаргаж зогсооно;

(2) хүрч болох гадаргуугийн цацрагийн түвшин болон бохирдлын үлдэгдэл нь Техникийн зааварчилгаанд заасан хэмжээнээс хэтрэхгүй болж багасах хүртэл тухайн агаарын хөлгийг үйлчилгээнд гаргахгүй.

92.173. Агаарын хөлгийн даргыг мэдээллээр хангах

(а) Аюултай бараа тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн агаарын хөлөг нисэн гарахаас өмнө Техникийн зааварчилгааны дагуу аюултай бараатай холбоотой мэдээллийг агаарын хөлгийн даргад бичгээр хүргүүлнэ.

(b) Үйл ажиллагаа эрхлэгч нь энэ зүйлийн (а)-д заасан мэдээлэл дараах шаардлагыг хангаж байгааг бататгана:

(1) тухайн нислэгийн үед агаарын хөлгийн дарга ашиглахад бэлэн байх;

(2) зориулагдсан маягтаар танилцуулсан байх.

(c) Энэ дүрмийн 92.105-ын дагуу аюултай барааны тээврийн баримт бичиг үйлдсэн байхыг шаарддаг аюултай бараа тээвэрлэж байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн агаарын хөлөг нисэн гарахаас

өмнө агаарын хөлгийн даргыг тээвэрлэж байгаа аюултай бараатай холбоотой осол, зөрчлийн үед ашиглах онцгой нөхцөлийн хариу арга хэмжээний мэдээллээр хангана.

(d) Үйл ажиллагаа эрхлэгч нь энэ зүйлийн (с)-д заасан мэдээллийг тухайн нислэгийн үед агаарын хөлгийн дарга ашиглахад бэлэн байлгана.

(е) Үйл ажиллагаа эрхлэгч нь энэ зүйлийн (с)-д заасан мэдээллийг дараах баримт бичгийн дагуу хүргүүлсэн болохыг бататгана:

(1) Олон улсын иргэний нисэхийн байгууллагын баримт бичиг Doc 9481 “Агаарын хөлөгт аюултай бараатай холбоотой онцгой нөхцөл үүссэн үед авах арга хэмжээний зааварчилгаа”; эсхүл

(2) тээвэрлэж байгаа аюултай бараатай холбоотой төстэй мэдээллээр хангадаг бусад баримт бичиг.

92.175. Ажилтныг мэдээллээр хангах

(а) Үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн ажилтан болон хамааралтай бол тэдний үйлчилгээний агентыг аюултай бараа тээвэрлэхтэй холбоотой үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай дараах мэдээллээр хангана:

(1) аюултай бараатай холбоотой үүссэн онцгой нөхцөлийн үед авах арга хэмжээний зааварчилгаа;

(2) Техникийн зааварчилгаанд заасан бусад мэдээлэл.

92.176. Бусад этгээдийг мэдээллээр хангах

(а) Үйл ажиллагаа эрхлэгч, ачаа илгээгч болон бусад байгууллага нь аюултай барааг агаараар тээвэрлэх үйл ажиллагаанд оролцдог ажилтнууддаа аюултай бараатай харьцаж ажиллах, онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээний талаарх мэдээллийг өгсөн байна.

(b) Нислэгийн үед онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд агаарын хөлгийн дарга Техникийн зааварчилгаанд заасны дагуу агаарын хөлгийн бүхээгт байгаа аюултай барааны талаар нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагаар дамжуулан нисэх буудалд мэдээлнэ.

92.177. Ачаа хүлээн авах байрлал дахь мэдээлэл

(а) Үйл ажиллагаа эрхлэгч нь аюултай барааны тээвэрлэлтийн талаар олон нийтэд зориулсан анхааруулга мэдээллийг ачаа хүлээн авах байршил бүрд байрлуулна.

(b) Энэ зүйлийн (а)-д заасан анхааруулга нь:

(1) хүрэлцэхүйц тоотой байна;

(2) ил харагдахуйц хэлбэрээр байрласан байна.

92.179. Зорчигчийг мэдээллээр хангах

(а) Үйл ажиллагаа эрхлэгч нь агаарын хөлөгт авч орохыг хориглосон барааны төрлийг зорчигчид мэдээлэх үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан мэдээллийг дараах байдлаар хүргэсэн байх ёстой:

(1) хүрэлцэхүйц тоо хэмжээтэй ба дараах байршилд, ил харагдахуйц байрлуулсан анхааруулга:

(i) зорчигчийн тийз олгох болон тээш бүртгэх байрлал бүрд;

(ii) агаарын хөлөгт зорчигч орох талбай бүрд;

(2) зорчигчийн тийзэд, хэрэв тийз нь цахим хэлбэртэй бол суудал захиалгын баталгаажуулалтын хэсэг байхаар.

92.180. Аюултай бараатай холбогдсон осол зөрчлийн талаар мэдээлэх

(a) Үйл ажиллагаа эрхлэгч нь аюултай бараатай холбоотой гарсан осол, зөрчлийн талаар Даргад болон тухайн хэрэг явдал болсон улсын эрх бүхий байгууллагад Техникийн зааварчилгаанд заасны дагуу мэдээлнэ.

(b) Үйл ажиллагаа эрхлэгч нь ачаанд аливаа мэдээлээгүй, эсхүл буруу мэдүүлсэн аюултай бараа илэрсэн тохиолдолд энэ тухай Даргад болон тухайн хэрэг явдал болсон улсын эрх бүхий байгууллагад, мөн нисэх багийн гишүүд, зорчигчийн гар тээш, тээшинд агаарын хөлгийн бүхээгт авч орохыг хориглосон аюултай бараа илэрсэн тохиолдолд энэ талаар тухайн хэрэг явдал болсон улсын эрх бүхий байгууллагад тус тус мэдээлнэ.

92.181. Үйл ажиллагаа эрхлэгч аюултай барааг саатуулах

(a) Үйл ажиллагаа эрхлэгч нь 92.17-ийн дагуу Дарга саатуулсан байх ёстой гэж үзсэн аюултай барааг хураан авсан бол:

(1) тухайн барааг Дарга өөрийн мэдэлд авах хүртэл аюулгүй хадгалах бүх боломжит урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна;

(2) тухайн барааг Дарга үзлэг, шалгалт, тест, шинжилгээ хийх, эсхүл нотлох баримтын зорилгоор цаашид хадгалах шаардлагагүй гэж үзсэн бол саатуулсан барааг чөлөөлж болно.

Е Бүлэг - Сургалт

92.201.Хамрах хүрээ

(a) Энэ Бүлэг нь дараах этгээдийн аюултай барааны сургалтад тавих зохицуулалтын шаардлагыг тогтооно:

(1) аюултай барааг тогтмол илгээгч болон түүний үйлчилгээний агентын;

(2) үйл ажиллагаа эрхлэгчийн;

(3) аюултай барааг агаараар тээвэрлэхээр хүлээн авах үйлчилгээний агентын;

(4) үйл ажиллагаа эрхлэгчээс бусад, зорчигч, эсхүл ачааг агаараар тээвэрлэх, эсхүл бэлтгэх ажиллагаанд оролцдог байгууллага болон этгээдийн;

(5) зорчигч болон түүний тээшинд аюулгүйн үзлэг хийдэг байгууллагын.

(6) томилогдсон шуудангийн байгууллага.

92.203. Аюултай барааны сургалтын хөтөлбөр

(а) ИНД-119 Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт (цаашид “ИНД-119” гэх)-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн, эсхүл гэрчилгээ эзэмшигчийн үйлчилгээний агентийн агаараар тээвэрлэхээр төлөвлөж байгаа аюултай бараатай холбоотой үүрэг гүйцэтгэхээр томилогдсон ажилтан нь дараах байгууллагын зохион байгуулсан, Хавсралт А-ийн дагуу 92.205-д заасан давтан сургалтыг багтаасан аюултай барааны сургалтын хөтөлбөрт амжилттай хамрагдсан болохыг бататгах үүрэгтэй:

(1) ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч (хэрэв гэрчилгээ нь аюултай барааны сургалт зохион байгуулахыг зөвшөөрдөг бол); эсхүл

(2) ИНД-141 Нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээжүүлэлт (цаашид “ИНД-141” гэх)-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч (хэрэв гэрчилгээ нь аюултай барааны сургалт зохион байгуулахыг зөвшөөрдөг бол).

(б) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч, эсхүл тухайн гэрчилгээ эзэмшигчийн үйлчилгээний агентаас бусад этгээд нь агаараар тээвэрлэхээр төлөвлөж байгаа аюултай бараатай холбоотой үүрэг гүйцэтгэхээр томилогдсон ажилтан дараах байгууллагаас зохион байгуулсан, хэрэв хамааралтай бол Хавсралт А-ийн дагуу 92.205-д заасан давтан сургалтыг багтаасан аюултай барааны сургалтын хөтөлбөрт амжилттай хамрагдсан болохыг бататгах үүрэгтэй:

(1) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ (хэрэв гэрчилгээ нь аюултай барааны сургалт зохион байгуулахыг зөвшөөрдөг бол); эсхүл

(2) Олон улсын агаарын тээврийн холбоо (цаашид “IATA” гэх);

(3) IATA-аар зөвшөөрөгдсөн сургалтын төв.

(с) Гадаад улсад үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийг, хэрэв агаарын хөлөгт ачих болон буулгах үйл ажиллагааг тухайн улсын дараах ажилтан гүйцэтгэж байгаа бол энэ зүйлийн (а)-г дагаж мөрдөхийг шаардахгүй:

(1) 92.203-ын дагуу сургалтын шаардлагыг хангасан этгээд хяналт тавьж байгаа; эсхүл

(2) тухайн улсын шаарддаг аюултай барааны сургалтын хөтөлбөрт амжилттай хамрагдсан; эсхүл

(3) дараах байгууллагын зохион байгуулсан аюултай барааны сургалтын хөтөлбөрт амжилттай хамрагдсан:

- (i) IATA-ийн гишүүн өөр агаарын тээвэрлэгч; эсхүл
- (ii) IATA; эсхүл
- (iii) IATA-аар зөвшөөрөгдсөн сургалтын төв.

(d) Монгол Улсад үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл үйлчилгээний агентыг, хэрэв аюултай бараатай холбоотой ажил үүрэг гүйцэтгэх ажилтан нь агаарын хөлгийн бүртгэгч улсын шаарддаг аюултай барааны сургалтын хөтөлбөрт амжилттай хамрагдсан бол энэ зүйлийн (а)-г дагаж мөрдөхийг шаардахгүй.

92.205. Давтан сургалт

(а) Энэ дүрмийн 92.203-т шаардсан аюултай барааны сургалтын хөтөлбөрт амжилттай хамрагдсан этгээд нь:

(1) тухайн хөтөлбөрт хамрагдсанаас хойш 2 жилийн дотор, аюултай барааны давтан сургалтын хөтөлбөрт хамрагдана;

(2) 2 жилээс хэтрэхгүй хугацааны давтамжтайгаар аюултай барааны давтан сургалтын хөтөлбөрт дахин хамрагдана.

92.207. Ажилтны бүртгэл

(а) Энэ дүрэм хамаарах этгээд нь аюултай бараатай холбоотой ажил үүрэг гүйцэтгэхээр томилогдсон ажилтан бүрийн хувийн хэргийг тэдний ажиллаж байгаа бүх хугацааны турш хадгална.

(б) Энэ зүйлийн (а)-ийн дагуу хадгалах шаардлагатай хувийн хэрэгт ажилтан бүрийн дараах мэдээллийг багтаасан байна:

(1) хамрагдсан анхан шатны сургалтын хөтөлбөр болон сүүлчийн давтан сургалт;

(2) сургалтад хамрагдсан огноо;

(3) сургалтыг зохион байгуулсан этгээд болон байгууллагын нэр;

(4) сургалтын үр дүн болон олж авсан ур чадвар.

Хавсралт А - Аюултай барааны сургалтын хөтөлбөр

А.1. Ажилтны хамрагдсан аюултай барааны сургалтын хөтөлбөр нь тухайн этгээдэд оногдох аюултай бараатай холбоотой ажил үүрэгт тохирсон, Техникийн зааварчилгааны Хэсэг 1, Бүлэг 4 (Аюултай барааны сургалт)-д нийцсэн байх ба дараах сургалтыг багтаана:

(1) ерөнхий танилцах сургалт - ерөнхий заалттай танилцуулах зорилготой;

(2) үйл ажиллагааны тусгай сургалт - тухайн этгээдийн хариуцах ажиллагаанд холбогдох шаардлагыг нарийвчлан олгох сургалт;

(3) аюулгүй байдлын сургалт - аюултай бараанаас үүдэлтэй аюул, аюулгүй ажиллах болон онцгой нөхцөлийн үед авах арга хэмжээний журмыг багтаасан.

(4) [хүчингүй болгосон]

*Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн
А/253 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

ИНД-109 Зохицуулалттай агаарын ачааны байгууллагын гэрчилгээжүүлэлт

А Бүлэг - Ерөнхий зүйл

109.1. Зорилго

(а) Энэ дүрмээр зорчигч тээвэрлэж байгаа агаарын хөлгөөр тээвэрлэхэдаюулгүйнхамгаалалтынмэдүүлэгдагалдуулахыгшаардсан ачаа, эсхүл шуудангийн үйлчилгээ үзүүлэх Зохицуулалттай агаарын ачааны байгууллагын (цаашид “ЗААБ” гэх) гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны шаардлагыг тогтооно.

109.2. Хамрах хүрээ

(а) Энэ дүрэмд, агаараар тээвэрлэхээр төлөвлөж байгаа ачаа, эсхүл шуудантай холбоотой шаардлага нь зөвхөн олон улсын агаарын тээврийн зорчигч үйлчилгээний тогтмол нислэгт ашиглаж байгаа агаарын хөлгөөр тээвэрлэх ачаа, эсхүл шууданд хамаарна.

109.3. Нэр томьёо ба товчлол

(а) Энэ дүрэмд хэрэглэсэн нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбарт тусгасан.

109.5. Гэрчилгээний шаардлага

(а) Энэ дүрмийн дагуу олгосон ЗААБ-ын гэрчилгээгээр олгогдох эрхийн хүрээ, нөхцөлөөс гадуур, аливаа этгээд нь ачаа, эсхүл шууданг олон улсын агаарын тээврийн зорчигч үйлчилгээний тогтмол нислэгт ашиглаж байгаа агаарын хөлгөөр тээвэрлэх бол ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг агаарын тээвэрлэгчид агаараар тээвэрлүүлэхээр хүлээлгэн өгдөг ЗААБ-ын эрхийг хэрэгжүүлэхгүй.

109.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах

(а) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24109/01 маягыг бөглөж, дараах баримт бичгийн хамт Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч (цаашид “Дарга” гэх)-д хүргүүлнэ:

- (1) 109.71-д шаардсан Ерөнхий заавар;
- (2) төлбөрийн баримт.

109.9. Гэрчилгээ олгох

(а) Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл хүсэлт гаргагчид ЗААБ-ын гэрчилгээ олгоно, хэрэв:

- (1) энэ дүрмийн В бүлгийн шаардлагыг хангасан байх;
- (2) хүсэлт гаргагч болон 109.51(а)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтнууд нь тохирох зөв хүн байх;

(3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдал, эсхүл аюулгүйн хамгаалалтын ашиг сонирхолд харшлахгүй байх.

109.11. Гэрчилгээ эзэмшигчийн эрх

(а) ЗААБ-ын гэрчилгээ нь түүнийг эзэмшигчид олон улсын агаарын тээврийн зорчигч үйлчилгээний тогтмол нислэгт ашиглаж байгаа агаарын хөлгөөр тээвэрлэх ачаа, эсхүл шуудангаар илгээх бараанд ЗААБ-ын аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг гаргах эрх олгоно.

109.13. Гэрчилгээний хугацаа

(а) ЗААБ-ын гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгаж болно.

(b) ЗААБ-ын гэрчилгээ нь түүний хугацаа дуусах, эсхүл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй хэвээр байна.

(c) ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүйд тооцсон тохиолдолд гэрчилгээг Даргад хураалгана.

(d) Гэрчилгээг түдгэлзүүлэх шийдвэр гарсан тохиолдолд ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлнэ.

109.15. Гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах

(а) Гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах хүсэлт гаргах ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө САА 24109/01 маягтыг бөглөж, төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй.

В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага

109.51. Ажилтанд тавигдах шаардлага

(а) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:

(1) Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон удирдах ажилтан:

(i) энэ дүрэмд заагдсан үйл ажиллагааны шаардлага, стандартыг хангах зорилгоор байгууллагын зүгээс авч хэрэгжүүлэх бүх үйл ажиллагааг тухайн байгууллагын хэмжээнд санхүүжүүлэх, хэрэгжүүлэх бүрэн эрхтэй;

(ii) энэ дүрэмд заасан шаардлага, стандартыг хангаж байгааг хүсэлт гаргагчийн өмнөөс бүрэн хариуцах;

(2) хүсэлт гаргагч байгууллага нь Ерөнхий зааврыг даган мөрдөж байгааг бататгах Гүйцэтгэх захирлын өмнө үүрэг хариуцлага хүлээсэн удирдах ажилтнууд;

(3) Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан, ачаа болон шуудангийн аюулгүйн хамгаалалтын хяналтын журмыг хэрэгжүүлэх хангалттай тооны ажилтан.

(b) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, тухайн байгууллагын Ерөнхий зааварт заасны дагуу ачаа, эсхүл шуудангийн

аюулгүйн хамгаалалтын хяналттай холбоотой ажил үүрэг гүйцэтгэх эрх бүхий үнэмлэх олгогдсон ажилтны ур чадварын үнэлгээ хийх, түүнийг хадгалах журамтай байна.

109.53. Байгууламжид тавигдах шаардлага

(а) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн байгууллагын үзүүлэх үйлчилгээтэй холбоотой дараах ажиллагаанд тохирсон байгууламжтай байна:

(1) бүртгэлгүй харилцагчаас ачаа, эсхүл шууданг хүлээн авах болон аюулгүйн хамгаалалтын хяналтад хамруулах;

(2) бүртгэлтэй харилцагчаас ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг хүлээн авах, тухайн илгээх бараа болон холбогдох баримт бичгийг шалгах;

(3) илгээх бараанд гэмтэл учруулах, хөндөгдөхөөс хамгаалах зорилгоор шаардлагатай аюулгүйн хамгаалалтын хяналт хэрэгжүүлсэн ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг нэвтрэх хяналттай бүсэд хадгалах;

(4) агаарын ачаа зуучийн байгууллагын нэвтрэх хяналттай агуулахын бүсээс ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг гэмтээж, хөндөгдөөгүйг бататгасан арга хэлбэрээр агаарын тээвэрлэгчид хүргэх.

109.55. Ачаа болон шуудангийн аюулгүйн хамгаалалтын хяналтын журам

(а) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах аюулгүйн хамгаалалтын хяналтын журамтай байна:

(1) бүртгэлгүй харилцагчаас агаараар тээвэрлүүлэхээр хүлээн авсан ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа бүрд хөндлөнгийн хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодис нэвтрүүлэхээс сэргийлэх зорилгоор аюулгүйн хамгаалалтын хяналт хэрэгжүүлдэг байх;

(2) бүртгэлтэй харилцагчаас агаараар тээвэрлүүлэхээр хүлээн авсан ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа бүрийг:

(i) агууламжийн мэдэгдэл дагалддаг байх;

(ii) илгээх бараанд гэмтэл учруулж, хөндөгдөөгүй болохыг бататгах зорилгоор шалгадаг байх;

(3) энэ хэсгийн (2)-ын дагуу шаардсан ачаа, эсхүл шуудангаар илгээх барааны агууламжийн мэдэгдлийг дараах зорилгоор шалгадаг байх:

(i) ачаа, эсхүл шуудангаар илгээх бараанд хөндлөнгийн хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодис байхгүй болохыг бататгах;

(ii) тухайн агууламжийн мэдэгдэл нь бүртгэлтэй харилцагчаас гаралтай болохыг бататгах;

(4) ЗААБ-ын хүлээн авсан болон энэ хэсгийн (1), эсхүл (2) болон (3)-ын дагуу түүнд хамааралтай аюулгүйн хамгаалалтын хяналт хийгдсэн, ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа бүрийг тээвэрлэх агаарын тээвэрлэгчид хүргүүлж агаарын хөлөгт ачих хүртэл нэвтрэх хяналттай бүсэд хадгалдаг байх;

(5) агаарын хөлгөөр тээвэрлүүлэхээр агаарын тээвэрлэгчид хүргүүлсэн ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа бүрийг:

(i) Хавсралт А.1-д заасан шаардлагыг хангасан аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг дагалдуулсан бөгөөд 109.59-ийн дагуу аюулгүйн хамгаалалтын мэдүүлэгт эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байх;

(ii) илгээх барааг ЗААБ-ын нэвтрэх хяналттай бүсээс гаргах үеэс агаарын тээвэрлэгч тухайн илгээх барааг хүлээн авах хүртэл гэмтэл учруулах, хөндөгдөх үйлдлээс хамгаалагдсан байх.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан аюулгүйн хамгаалалтын хяналтын журмыг хэрэгжүүлэх этгээд нь зохих ёсоор сургалтад хамрагдсан бөгөөд 109.59-ийн дагуу олгосон зохих зөвшөөрөл эзэмшсэн байна.

109.57. Аюулгүйн үзлэг, шалгалтын журам

(a) Энэ дүрмийн 109.55-д шаардсан аюулгүйн хамгаалалтын хяналтын журмын хэсэг болох ачаа, эсхүл шуудангийн аюулгүйн үзлэг, шалгалт хийхээр төлөвлөж байгаа ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Хавсралт В-ийн дагуу аюулгүйн үзлэг, шалгалт хийх журамтай байна.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь дараах шаардлагыг багтаасан байна:

(1) аюулгүйн үзлэг, шалгалтад хэрэглэх аргыг таньж тогтоох ба тохирсон байх;

(2) аюулгүйн үзлэг, шалгалт гүйцэтгэж байгаа этгээдийн заавал дагаж мөрдөх ажиллагаа бүрийг дэлгэрэнгүй заадаг байх;

(3) тодорхой аюулгүйн үзлэг, шалгалтын аргын хувьд, тухайн этгээд нь 109.59-ийн дагуу зохих ёсоор зөвшөөрөгдсөн байхыг шаарддаг байх;

(4) аюулгүйн үзлэг, шалгалт гүйцэтгэж байгаа этгээдийг хамруулсан, аюулгүйн үзлэг, шалгалтын аргад үечлэлтэйгээр сорилт хийх журам болон хөтөлбөрийг багтаасан байх;

(5) техникийн төхөөрөмж ашигладаг аюулгүйн үзлэгийн аргын хувьд тухайн төхөөрөмжийн засвар үйлчилгээний хөтөлбөрийг багтаах, хэрэв хамааралтай бол аюулгүйн үзлэгийн төхөөрөмжийн тохиролд үечлэлтэйгээр сорилт хийх журмыг багтаасан байх;

(6) аюулгүйн үзлэгийн аргын алдаанаас үүсэх үр дагаварт үнэлгээ хийх үйл явц болон өмнө нь аюулгүйн үзлэг, шалгалт хийгдсэн ачаанд тухайн алдааны үзүүлж болох нөлөөллийн талаар авах арга хэмжээг багтаасан байх.

109.59. Зөвшөөрөл олгох журам

(а) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн байгууллагын санал болгосон ажиллагаанд хамаарах, дараах аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг гүйцэтгэх этгээд бүрд зөвшөөрөл олгох журамтай байна:

(1) 109.57-д шаардсан журмын дагуу ачаа, эсхүл шууданд аюулгүйн үзлэг хийх;

(2) 109.55(а)(1)-д шаардсан аюулгүйн хамгаалалтын хяналтын журмыг бүртгэлгүй харилцагчаас хүлээн авсан ачаа, эсхүл шууданд хэрэгжүүлэх;

(3) 109.55(а)(2) болон (а)(3)-т шаардсан аюулгүйн хамгаалалтын хяналтын журмын дагуу, бүртгэлтэй харилцагчаас хүлээн авсан ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа болон агууламжийн мэдэгдлийг шалгах;

(4) 109.55(а)(4)-т заасан, хүсэлт гаргагчийн нэвтрэх хяналттай бүсэд хадгалагдаж байгаа ачаа, эсхүл шуудангаар илгээх бараатай харьцах;

(5) 109.55(а)(5)(i)-д заасан аюулгүйн хамгаалалтын мэдүүлгийг ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа бүрд гаргах;

(6) агаарын тээвэрлэгчид 109.55(а)(5)(ii)-т шаардсан аюулгүйн хамгаалалтын хяналтын журмын дагуу “гэмтээж хөндөгдсөн нь илрэх” хэлбэрээр тээвэрлээгүй боловч аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг дагалдсан ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг хүргэх;

(7) 109.61(а)-д заасан бүртгэлтэй харилцагчийн журмыг хэрэгжүүлэх болон бүртгэлтэй харилцагчийн дэлгэрэнгүй мэдээллийг 109.61(с)-д шаардсан бүртгэлд оруулах.

(b) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь 109.109(2)-т зааснаас бусад нэвтрэх хяналттай бүсэд орох этгээдэд зөвшөөрөл олгох журамтай байна.

(с) Энэ зүйлийн (а) болон (b)-д шаардсан журам нь дараах шаардлагыг багтаасан байна:

(1) дараахаас бусад тохиолдолд аливаа этгээдэд зөвшөөрөл олгохгүй:

(i) тухайн этгээд анкет шалгалтад хамрагдсан талаар Даргаас олгогдсон эерэг тодорхойлолттой байх;

(ii) энэ зүйлийн (а)-ийн дагуу олгох зөвшөөрлийн хувьд тухайн этгээд нь 109.63-т шаардсан ЗААБ-ын сургалтын хөтөлбөрийн дагуу зохих ёсоор сургалтад хамрагдсан байх;

(iii) энэ зүйлийн (а)-ийн дагуу олгох зөвшөөрлийн хувьд тухайн этгээд нь 109.63-т шаардсан ЗААБ-ын сургалтын хөтөлбөрийн дагуу төлөвлөж байгаа зөвшөөрлийн хүрээнд аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг гүйцэтгэх зорилгоор ур чадварын үнэлгээ хийлгэсэн байх;

(iv) энэ зүйлийн (b)-ийн дагуу олгох зөвшөөрлийн хувьд тухайн этгээд нь агаарын ачааны аюулгүйн хамгаалалтын шаардлагын талаар мэдлэгтэй байх;

(2) зөвшөөрөл нь бичгээр байх ба дараах мэдээллийг агуулсан байх:

(i) зөвшөөрөл олгогдсон этгээдийн нэр;

(ii) тухайн этгээдэд гүйцэтгэхийг зөвшөөрсөн аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг, эсхүл бусад үүрэг;

(iii) зөвшөөрлийн дуусах хугацаа;

(3) зөвшөөрлийг 3 жилээс дээш хугацаагаар олгохгүй;

(4) энэ хэсгийн (1), (2) болон (3)-т заасан шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, аливаа этгээдэд дахин зөвшөөрөл олгохгүй.

109.61. Бүртгэлтэй харилцагчийг бүртгэх журам

(а) Бүртгэлтэй харилцагчаас агаараар тээвэрлүүлэх ачаа, эсхүл шуудан хүлээн авахаар төлөвлөж байгаа ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах журамтай байна:

(1) бүртгэлтэй харилцагч нь бүртгэлтэй харилцагчийн агаараар тээвэрлэх ачаа, эсхүл шуудантай холбоотой аюулгүйн хамгаалалтын асуудлын талаар мэдлэгтэй байх;

(2) бүртгэлтэй харилцагч нь дараах шаардлагыг бататгах тогтолцоо болон журамтай байх:

(i) хүсэлт гаргагчийн байгууллагад агаараар тээвэрлүүлэхээр хүргүүлж байгаа харилцагчийн ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа нь зөвхөн ачаа, эсхүл шуудангийн зориулалттай эд зүйлс байх;

(ii) хүсэлт гаргагчийн байгууллагад хүргүүлсэн ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа бүрд бүртгэлтэй харилцагчаас гаралтай болохыг таньж тогтоох агууламжийн мэдэгдэл дагалдсан байх;

(iii) хүсэлт гаргагчийн байгууллагад хүргүүлсэн ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг гэмтээж, хөндөгдсөн эсэхийг таньж тогтооход хялбар хэлбэрээр хамгаалсан байх;

(iv) бүртгэлтэй харилцагч тухайн ачаа, эсхүл шууданг хүсэлт гаргагчийн байгууллагад илгээх үед гэмтэл учраагүй, хөндөгдөөгүй байх.

(b) Энэ зүйлийн (а)-ийн дагуу шаардсан журамд хүсэлт гаргагчийн байгууллага нь энэ зүйлийн (а)-ийн шаардлагыг тасралтгүй хангаж байгааг бататгах арга хэлбэрийг багтаасан байна.

(с) Энэ зүйлийн (а)-д шаардсан журмын дагуу бүртгэлтэй харилцагчаас агаараар тээвэрлэхээр ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа хүлээн авахаар төлөвлөж байгаа ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах мэдээлэл бүхий бүртгэлтэй харилцагчийн жагсаалт болон бүртгэлтэй харилцагч тус бүрийн бүртгэл хөтөлнө:

(1) харилцагчийн албан ёсны нэр (хэрэв хамааралтай бол бизнесийн нэр);

(2) холбоо барих удирдах ажилтны эсхүл Гүйцэтгэх захирлын нэр болон дэлгэрэнгүй мэдээлэл;

(3) харилцагчийн одоогийн хаяг, цахим шуудангийн хаяг болон холбоо барих утасны дугаар.

109.63. Ажилтны сургалт

(а) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах зорилгоор сургалтын хөтөлбөрийг боловсруулна:

(1) хүсэлт гаргагчийн байгууллагын агаараар тээвэрлэхээр хүлээн авсан ачаа, эсхүл шуудангаар илгээх бараатай харьцах этгээдийг, илгээх барааны хадгалалт болон тээвэрлэлтийн аюулгүйн хамгаалалтын хяналтын журмын тохирох сургалтад хамрагддаг болохыг бататгах;

(2) хүсэлт гаргагчийн байгууллагын агаараар тээвэрлэхээр хүлээн авсан ачаа, эсхүл шуудантай холбоотой аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг гүйцэтгэдэг этгээдийг зохих сургалтад хамруулдаг бөгөөд аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг гүйцэтгэх ур чадварт үнэлгээ хийдэг болохыг бататгасан.

(b) Энэ зүйлийн (а)-д шаардсан сургалтын хөтөлбөр нь:

(1) дараах үе шатуудыг:

(i) анхан шатны сургалтын;

(ii) давтан сургалтын;

(iii) ур чадварын үнэлгээний;

(2) аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг болон сургалтын үе шат бүрд холбоотой хичээлийн сэдвийг агуулсан байна.

(с) Энэ зүйлийн (а)-д шаардсан сургалтын хөтөлбөр нь, сургалтад хамрагдах шаардлагатай этгээдийг 3 жилээс дээшгүй хугацаанд тухайн сургалтын хөтөлбөрийн давтан сургалтын үе шатанд хамрагддаг болохыг бататгана.

(d) Аюулгүйн үзлэгийг багтаасан, аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг гүйцэтгэдэг этгээдэд зориулсан сургалтын хөтөлбөр нь Хавсралт С-д заасан стандартыг багтаасан байна.

109.65. Ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчил

(а) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журамтай байна:

(1) тухайн байгууллагын ажиллагаатай холбоотой ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийг ИНД-12 Осол, зөрчлийн мэдээлэл (цаашид “ИНД-12” гэх)-ийн дагуу мэдээлэх, шинжлэн шалгах ба тайлагнах;

(2) ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийн шалтгааныг арилгах, залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх болон зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх.

109.67. Бүртгэл хөтлөх

(а) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах үйл явцыг багтаасан, үнэн зөв бүртгэлээр хангахад шаардлагатай дараах бүртгэлийн журамтай байна:

(1) мэдүүлгийн нэг хуулбарыг агуулсан, агаараар тээвэрлүүлэхээр агаарын тээвэрлэгчид аюулгүйн хамгаалалтын мэдүүлгийн эрхийн хүрээнд хүргүүлсэн ачаа, эсхүл шуудангийн илгээх бараа бүрийн бүртгэл;

(2) хамрагдсан сургалтын үе шат бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, 109.63-т шаардсан сургалтад хамрагдсан байх шаардлагатай этгээдийн бүртгэл;

(3) 109.59(с)(1)(i)-д шаардсан анкет шалгалтын тодорхойлолтыг багтаасан, 109.59-ийн дагуу бичгээр зөвшөөрөл олгогдсон этгээдийн (хүн тус бүрийн) сургалт болон ур чадварын үнэлгээ, зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийн бүртгэл;

(4) 109.61(b)-д шаардсан байнгын хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, 109.61(с)-д заасан жагсаалтад орсон бүртгэлтэй харилцагчийн бүртгэл;

(5) 109.65-ын дагуу гүйцэтгэсэн ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийг шинжлэн шалгахтай холбоотой шинжлэн шалгах ажиллагааны бүртгэл;

(6) 109.69-ийн дагуу гүйцэтгэсэн дотоод чанар баталгаажуулалтын дүгнэлтийн бүртгэл.

(b) Энэ зүйлийн (а)-ийн дагуу шаардсан бүртгэл нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) үнэн зөв, гаргацтай, байнгын шинж чанартай байх;

(2) нисэхийн аюулгүйн хамгаалалтын ашиг сонирхлын үүднээс:

(i) энэ зүйлийн (а)(2) болон (3)-т шаардсан бүртгэлийн хувьд, ажилтан ажлаас халагдсан, эсхүл ЗААБ-тай холбоотой байсан хугацаанаас хойш 2 жилийн хугацаанд хадгалах;

(ii) агууламжийн мэдэгдэл, эсхүл аюулгүйн хамгаалалтын мэдүүлгийн хувьд Дарга, аюулгүйн хамгаалалтын зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны зорилгоор урт хугацаа шаардсанаас бусад

тохиолдолд, 31 хоногоос доошгүй хугацаанд хадгалах.

109.69. Дотоод чанар баталгаажуулалт

(а) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ дүрмээр шаардсан журам нь дүрмийн шаардлага хангасан ба тухайн байгууллага түүнийг хэрэгжүүлж байгааг бататгах зорилгоор дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлнэ.

(b) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь дараах журамтай байна:

(1) 109.65-ын дагуу шинжлэн шалгасан ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийн шалтгааныг арилгах, давтагдахаас сэргийлэх, залруулах арга хэмжээний журмыг агуулсан аюулгүйн хамгаалалтын бодлого болон аюулгүйн хамгаалалтын бодлогын журам;

(2) дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо дахь хүндрэлтэй асуудал, эсхүл хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг тогтоох зорилгоор аюулгүйн хамгаалалтын хяналтын зөрчлийн давтамж, ажилтан болон харилцагчийн санал хүсэлтийг багтаасан чанарын үзүүлэлтийг хянах журам;

(3) дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоонд илрүүлсэн хүндрэлтэй асуудлыг засаж залруулах арга хэмжээний журам;

(4) дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоонд илрүүлсэн хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг арилгасан болохыг бататгах урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам;

(5) хүсэлт гаргагчийн байгууллагын үйл ажиллагаа нь Ерөнхий заавартаа агуулагдсан журамд нийцэж байгааг болон аюулгүйн хамгаалалтын бодлогод тодорхойлсон зорилгод хүрэхийг бататгах дотоод аудитын хөтөлбөр;

(6) дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны байнгын тохирол болон үр дүн нь энэ дүрмийн шаардлагад нийцэж байгааг бататгах, хэрэв хамааралтай бол статистикийн дүн шинжилгээг хэрэглэх шаардлагыг багтаасан удирдлагын дүгнэлтийн журам.

(с) Дотоод чанар баталгаажуулалтын үүрэг хариуцлага хүлээсэн удирдах ажилтан нь агаараар тээвэрлэх ачаа, эсхүл шуудангийн аюулгүйн хамгаалалтад нөлөөлөх асуудлаар Гүйцэтгэх захиралтай шууд харьцах эрхтэй.

109.71. Байгууллагын Ерөнхий заавар

(а) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журам болон тогтолцооны дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан Ерөнхий зааврыг Даргаар хүлээн зөвшөөрүүлэхээр хүргүүлэх үүрэгтэй:

(1) дараах шаардлагыг бататган, хүсэлт гаргагч байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:

(i) Ерөнхий заавар нь байгууллагын зохион байгуулалтын

бүтцийг тодорхойлох ба энэ дүрмийн байнгын хэрэгжилтийг хангах хэлбэр болон аргыг харуулсан байх;

(ii) байгууллагын ажилтнууд Ерөнхий заавар, холбогдох бусад бүх журам, заавар, үйл ажиллагааны болон аюулгүйн хамгаалалтын хяналтын журмыг байгууллагын ажилтан байнга дагаж мөрддөг байх;

(2) 109.51(а)(1) болон (2)-т заасан удирдах ажилтнуудын албан тушаал болон нэр;

(3) хариуцсан чиг үүргийн хүрээнд тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харилцах асуудал;

(4) энэ хэсгийн (6)-д заасан байрлал тус бүрд хамааралтай, энэ хэсгийн (2)-т заасан удирдах ажилтны хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын зохион байгуулалтын бүтцийн зураг;

(5) энэ хэсгийн (6)-д заасан байрлал бүрд хамаарах тухайн байгууллагын ажилтнуудын бүтцийн хураангуй мэдээлэл;

(6) ачаа болон шуудантай холбоотой аюулгүйн хамгаалалтын хяналт гүйцэтгэх тухайн байгууллагын ажилтны байршил бүрийн үйл ажиллагааны хамрах хүрээний хураангуй мэдээлэл;

(7) 109.53-ын шаардлага хангасан, энэ хэсгийн (6)-д заасан байршил бүрийн байгууламжийн хураангуй мэдээлэл;

(8) 109.69-д заасан дотоод чанар баталгаажуулалтын талаарх дэлгэрэнгүй журам;

(9) 109.51(b)-д заасан ажилтны ур чадвар хадгалалтад үнэлгээ хийх журам;

(10) 109.55(а)(1)-д заасан бүртгэлгүй харилцагчаас хүлээн авсан ачаа, эсхүл шууданг аюулгүйн хамгаалалтын хяналтад хамруулах;

(11) 109.55(а)(2) болон (3)-т заасан бүртгэлтэй харилцагчаас ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг хүлээн авах журам;

(12) 109.55(а)(4)-т заасан ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг нэвтрэх хяналттай бүсэд хадгалах журам;

(13) 109.55(а)(5)(i)-д заасан агаарын тээвэрлэгчид хүргүүлэх ачаа, эсхүл шуудангаар илгээх барааны аюулгүйн хамгаалалтын мэдүүлгийн бүрдүүлэлтийн журам;

(14) 109.55(а)(5)(ii)-т заасан илгээх барааг агаарын тээвэрлэгчид хүргэх үед ачаа, эсхүл шуудангаар илгээх бараанд гэмтэл учруулах, хөндөгдөх үйлдлээс хамгаалах журам;

(15) 109.57-д заасан ачаа, эсхүл шууданд аюулгүйн үзлэг хийх журам;

(16) 109.59-д заасан ажилтанд зөвшөөрөл олгох журам;

(17) 109.61-д заасан бүртгэлтэй харилцагчид тавих шаардлага;

(18) 109.63 -т заасан сургалтын хөтөлбөр;

(19) 109.65(1)-д заасан ачааны аюулгүйн хамгаалалтын

зөрчлийг мэдээлэх, шинжлэн шалгах болон тайлагнах журам;

(20) 109.65(2)-т заасан ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийн шалтгааныг арилгах залруулах арга хэмжээ авах болон давтагдахаас сэргийлэх журам;

(21) 109.67-д бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах журам;

(22) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам;

(23) Ерөнхий заавар нь энэ дүрмийн холбогдох шаардлагыг хангаж байгааг бататгах журам;

(24) Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсны дараа нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргад нэн даруй хүргүүлэхийг бататгах журам.

(b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар Даргаар хүлээн зөвшөөрөгдсөн байна.

С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага

109.101. Байнгын хэрэгжилт

(a) ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигч нь:

(1) энэ дүрмийн дагуу гэрчилгээжүүлэлтэд тавих В Бүлгийн шаардлагыг хэрэгжүүлэн, стандартыг байнга дагаж мөрдөнө;

(2) гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан журам бүрийг дагаж мөрдөнө;

(3) Ерөнхий зааварт заасан удирдах ажилтны байрлал бүрд тухайн зааврын хамгийн багадаа нэг бүрэн, хүчинтэй хувийг байлгана;

(4) Ерөнхий зааврын холбогдох бүлэг бүрийг өөрийн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажилтанд хэрэглэх боломжтой байлгана;

(5) гэрчилгээ эзэмшигчийн бүртгэлтэй харилцагчийн хүчинтэй мэдээллийг агуулсан бүртгэлийг хөтөлнө;

(6) 109.103-г харгалзан, хэрэв Дарга бичгээр хүссэн бол гэрчилгээ эзэмшигчийн бүртгэлтэй харилцагчийн бүртгэлээс тухайн харилцагчийн нэрийг түдгэлзүүлнэ, эсхүл хасна;

(7) үйлчилгээний хаяг, цахим шуудангийн хаяг болон утасны дугаарын өөрчлөлтийн талаар тухайн өөрчлөлтийг хийснээс хойш 28 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэнэ;

(8) тухайн этгээд нь 109.59-д шаардсан журмын дагуу олгосон зөвшөөрөл эзэмшсэн байхаас бусад тохиолдолд, гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээний эрхийн хүрээнд аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг гүйцэтгэхгүй болохыг бататгана.

109.103. Бүртгэлтэй харилцагчийн нэрийг түдгэлзүүлэх, хасах

(a) Энэ зүйлийн (c)-г харгалзан хэрэв Дарга дараах нөхцөл үүссэн гэж үзвэл бүртгэлтэй харилцагчийн нэрийг ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигчийн бүртгэлтэй харилцагчийн бүртгэлээс түдгэлзүүлэх, эсхүл

хасах хүсэлтийг бичгээр гаргаж болно:

(1) бүртгэлтэй харилцагч нь дараах шаардлагыг дагаж мөрдөөгүй бол:

(i) 109.55(а)(2), эсхүл (3)-т шаардсан, ачаа болон аюулгүйн хамгаалалтын хяналтын журамтай холбоотой шаардлага; эсхүл

(ii) 109.61-д шаардсан, бүртгэлтэй харилцагчийн бүртгэл болон журамтай холбоотой шаардлага;

(2) бүртгэлтэй харилцагчийн нэрийг түдгэлзүүлэх, эсхүл хасах нь нисэхийн аюулгүйн хамгаалалтын ашиг сонирхолд нийцэж байгаа бол.

(b) Гэрчилгээ эзэмшигчийн бүртгэлтэй харилцагчийн бүртгэлээс тухайн харилцагчийн нэрийг Даргын тогтоосон хугацаагаар, эсхүл Дарга тухайн харилцагч шаардлагыг хангасан болохыг хүлээн зөвшөөрөх хүртэл түдгэлзүүлж, эсхүл хасаж болно.

(c) Энэ зүйлийн (d)-г харгалзан, энэ зүйлийн (a)-ийн дагуу бүртгэлтэй харилцагчийн нэрийг хасах, эсхүл түдгэлзүүлэх хүсэлт гаргахын өмнө, хэрэв бүртгэлтэй харилцагчид хохирол учруулж болох, эсхүл болзошгүй мэдээлэлд анхаарал хандуулахыг санал болгож байгаа бол Дарга тухайн мэдээллийг бүртгэлтэй харилцагчид ил болгох ба мэдээллийг ил болгосноос хойш 30 хоногийн дотор хариулт, эсхүл няцаалт өгөх боломжийг бүртгэлтэй харилцагчид олгох үүрэгтэй.

(d) Дарга дараах тохиолдолд, мэдээллийг ил болгохгүй:

(1) аливаа этгээдийн аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй бол;

(2) хэрэв ил болгох нь нисэхийн аюулгүйн хамгаалалтын ашиг сонирхолд нийцэхгүй бол.

109.105. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:

(1) Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлтийг тухайн гэрчилгээ эзэмшигчийн байгууллага болон агаарын ачааны аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний тодорхойлолт хүчинтэй хэвээр хадгалагдаж байхаар хийдэг болохыг бататгах;

(2) Ерөнхий зааварт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь энэ дүрмийн холбогдох шаардлагыг хангаж байгааг бататгах;

(3) Ерөнхий зааврын нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдөх;

(4) Ерөнхий зааварт нэмэлт, өөрчлөлт оруулсан даруйд нэмэлт, өөрчлөлтийн хувийг Даргад нэн даруй хүргүүлэх;

(5) нисэхийн аюулгүйн хамгаалалтын ашигт сонирхолд шаардлагатай гэж Даргын үзсэн нэмэлт, өөрчлөлтийг Ерөнхий зааварт

оруулах.

(b) Хэрэв ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах аль нэг өөрчлөлтийг хийж байгаа, эсхүл хийхээр санал болгож байгаа бол гэрчилгээ эзэмшигч нь тухайн өөрчлөлтийг хийхийн өмнө, эсхүл хэрэв урьдчилан мэдэгдэх боломжгүй бол Даргад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд, холбогдох тохирох зөв хүний шалгуурыг багтаасан өөрчлөлтийг гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт оруулахын өмнө Дарга хүлээн зөвшөөрсөн байна:

(1) 109.51(а)(1)-д заасан Гүйцэтгэх захирлыг өөрчлөх;

(2) 109.51(а)(2)-т заасан удирдах ажилтныг өөрчлөх;

(3) 109.55-д заасан ачаа болон шуудангийн аюулгүйн хамгаалалтын журам;

(4) 109.57-д заасан аюулгүйн үзлэгийн журам;

(5) 109.59-д заасан зөвшөөрөл олгох журам;

(6) 109.61-д заасан бүртгэлтэй харилцагчийн журам;

(7) 109.69-д заасан дотоод чанар баталгаажуулалтын журам.

(c) Энэ зүйлийн (b)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл хийсний дараа ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигчийн дагаж мөрдөх нөхцөлийг Дарга тогтоож болно.

(d) ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (c)-ийн дагуу Даргын тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөнө.

(e) Хэрэв энэ зүйлийн (b)-ийн дагуу хийсэн өөрчлөлт нь ЗААБ-ын гэрчилгээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардсан бол гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд тухайн өөрчлөлтийг баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад нэн даруй хүргүүлнэ.

109.107. Аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг гаргах этгээд

(a) Дараахаас бусад тохиолдолд аливаа этгээд нь энэ дүрэмд хамаарах ачаа, эсхүл шуудангаар илгээх барааны аюулгүйн хамгаалалтын мэдүүлгийг агаарын тээвэрлэгчид гаргаж өгөхгүй:

(1) тухайн этгээд нь ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигчээс мэдүүлэг гаргах бичгээр олгогдсон хүчинтэй зөвшөөрөл эзэмшсэн байх;

(2) тухайн этгээд нь аюулгүйн хамгаалалтын мэдүүлгийг:

(i) ЗААБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнд гаргадаг байх;

(ii) гэрчилгээ эзэмшигчийн мэдүүлэг гаргах журмын дагуу гаргадаг байх;

(3) ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа нь гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан аюулгүйн хамгаалалтын хяналтын журмын дагуу хамрагдсан байх.

109.109. Нэвтрэх хяналттай бүсэд орох

(a) ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараахаас бусад тохиолдолд аливаа этгээдийг нэвтрэх хяналттай бүсэд нэвтрүүлэхгүй:

(1) тухайн этгээд нь 109.59(b)-д шаардсан журмын дагуу бичгээр олгогдсон хүчинтэй зөвшөөрөлтэй; эсхүл

(2) тухайн этгээдийг энэ хэсгийн (1)-д заасан зөвшөөрөл эзэмшсэн этгээд дагалдсан байх.

Хавсралт А - Аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг

(а) Аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг нь тодорхой ачаа, эсхүл шуудангаар илгээх бараанд хамааралтай байх ба дараах мэдээллийг агуулсан байна:

(1) тухайн мэдүүлгийг ЗААБ-ын гэрчилгээний хүрээнд олгосныг гэрчлэх ЗААБ-ыг таних тодорхойлогч;

(2) илгээх барааны дагалдах тээврийн баримт бичгийн тоон дугаар;

(3) илгээх барааны агууламж/ нэгтгэсэн ачааны заалт;

(4) илгээх барааны эхлэх болон хүргэх цэг;

(5) илгээх барааг хүргүүлсэн агаарын тээвэрлэгчийг таних тодорхойлогч;

(6) илгээх барааг агаарын тээвэрлэгчид хүргүүлсэн огноо болон цаг, хугацаа;

(7) илгээх бараа нь энэ дүрмийн 109.57(b)(1) болон ЗААБ-ын Ерөнхий зааврын дагуу ачаанд хэрэгжүүлсэн аюулгүйн үзлэг, шалгалтын арга;

(8) тухайн мэдүүлэгт энэ хэсгийн (11)-д зааснаас бусад тохиолдолд, илгээх барааны аюулгүйн хамгаалалтын статус;

(9) мэдүүлэг гаргахаар зөвшөөрөгдсөн этгээдийг таньж тогтоох нэр, гарын үсэг;

(10) хуурамч мэдүүлэг гаргах нь гэмт хэрэг болохыг мэдэж байгаа тухай мэдэгдэл;

(11) илгээх бараанд агуулагдаж байгаа зэвсэг, тэсрэх эсхүл бусад аюултай барааны жагсаалт.

Хавсралт В - Аюулгүйн үзлэг, шалгалтын стандарт

В.1. Аюулгүйн үзлэг, шалгалтын арга

(а) Аюулгүйн үзлэг, шалгалт хийсэн, эсхүл үзлэг, шалгалт хийсэн байх шаардлагатай ачаа, эсхүл шууданд дараах нэг, эсхүл хэд хэдэн аргыг ашиглан аюулгүйн үзлэг, шалгалт хийж болно:

(1) ердийн рентген төхөөрөмж (x-ray);

(2) тэсрэх бодис илрүүлэх дэвшилтэт технологийн рентген систем (AT-EDS);

(3) тэсрэх бодисын ул мөр илрүүлэх систем (ETD);

(4) тэсрэх бодис илрүүлэх нохой;

(5) компьютер томограф;

(6) биет үзлэг;

(7) Даргын хүлээн зөвшөөрөхүйц аюулгүйн үзлэгийн бусад арга, эсхүл технологи.

(b) Аюулгүйн үзлэгийн төхөөрөмж нь нэвтрэх хяналттай бүсэд байрласан байна.

В.2. Үечилсэн сорилт

(a) Аюулгүйн үзлэг, шалгалтын арга бүрээр тухайн үзлэгийн үйл явцын байнгын бүрэн бүтэн байдлыг бататгах зорилгоор сорилын биетийг ашигласан үечилсэн сорилт хийдэг байна.

(b) Сорилын биет нь:

(1) сорьж байгаа аюулгүйн үзлэг, шалгалтын аргад тохирсон байх;

(2) тухайн аюулгүйн үзлэг, шалгалтын аргаар илрүүлэхэд зориулагдсан, зөвшөөрөгдөөгүй эд зүйлийн төлөөлөл байх;

(3) Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх.

(c) Хэрэв үечилсэн сорилт нь аюулгүйн үзлэг, шалгалт хийж байгаа этгээдийн ур чадварыг шалгахаар төлөвлөж байгаа бол тухайн сорилтыг дараах байдлаар хийх ёстой:

(1) аюулгүйн үзлэг, шалгалтыг гүйцэтгэж байгаа этгээдэд урьдчилан мэдэгдэхгүйгээр;

(2) сорилтод ашиглаж байгаа сорилын биетийг аюулгүйн үзлэг, шалгалт хийгдэж байгаа ачаа, эсхүл шуудангийн бусад эд зүйлийн хамт байрлуулж;

(3) сорилын биетийг илрүүлэх боломжийг сорилтод хамрагдаж байгаа этгээдэд олгосон хэлбэрээр.

Хавсралт С - Сургалтын стандарт

С.1. Үнэлгээний тогтолцоо болон сургалт

(a) Энэ зүйлийн (b)-д заасан ур чадварын түвшний үнэлгээний тогтолцоо нь дараах үнэлгээнээс бүрдэнэ:

(1) Үнэлгээ 1 - тухайн сэдвийн ойлголтыг харуулах;

(2) Үнэлгээ 2 - тухайн сэдвийн суурь мэдлэгийг харуулах;

(3) Үнэлгээ 3 - тухайн этгээдийн ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй нөхцөлд тухайн сэдвийн суурь мэдлэгээ ашиглах чадварыг харуулах;

(4) Үнэлгээ 4 - тухайн этгээд нь ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй нөхцөлд тухайн сэдвийн гүнзгий мэдлэгээ ашиглах чадварыг харуулах;

(5) Үнэлгээ 5 - тухайн этгээд нь ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй нөхцөлд тухайн сэдвийн гүнзгий мэдлэг болон нөхцөл байдлыг зөв тодорхойлж илэрхийлэх чадварыг харуулах.

(b) Аюулгүйн үзлэгийн үүрэг гүйцэтгэх ажилтны сурсан байхыг шаардсан дараах сэдэв:

(1) Ачаа, эсхүл шууданд аюулгүйн үзлэг, шалгалт хийх:

(i) ачаанд аюулгүйн үзлэг, шалгалт хийх зохицуулалтын үндсэн зарчмыг дүрслэх - Үнэлгээ 4;

(ii) гэрчилгээ эзэмшигчийн ашигладаг аюулгүйн үзлэгийн төхөөрөмжийн мэдлэгтэй ба ашиглахад мэргэшсэн байх - Үнэлгээ 5;

(iii) ачаанд аюулгүйн үзлэг, шалгалт хийх журам болон аргыг хэрэглэх дадлага туршлагатай байх - Үнэлгээ 5.

(2) Гар хийцийн тэсрэх төхөөрөмж: иргэний нисэхэд нөлөөлөх ачаа, эсхүл шууданд илэрч болох гар хийцийн тэсрэх төхөөрөмжийн талаарх ойлголтыг аюулгүйн үзлэг, шалгалт гүйцэтгэх этгээдэд өгөх - Үнэлгээ 3.

(3) Заналхийллийн хүчин зүйл: аюулгүйн үзлэг, шалгалт хийж байгаа этгээдэд өнөөгийн терроризм болон гэмт хэргийн чиг хандлагын талаарх мэдээллийг шинэчлэх- Үнэлгээ 2.

(4) Хууль бус үйлдэл хийсэн түүхэн баримт болон статистик: нисэхийн аюулгүйн хамгаалалтын хөгжил болон хэрэг явдлын тархцын талаарх мэдлэгийг ажилтанд олгох - Үнэлгээ 1.

СЭЛЭНГЭ АЙМАГ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 9 дүгээр
сарын 17-ны өдөр

Дугаар 45

Сүхбаатар сум

МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ЖИШИГ ҮНЭЛГЭЭГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 35.1.18 дахь заалт, 48 зүйлийн 48.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1.Орон нутгийн төсвийн санхүүжилтээр хийгдэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын жишиг үнэлгээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Мал эмнэлгийн үйлчилгээний жишиг үнэлгээг мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Лхагвадорж)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 41 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Г.БАТ-ОРХОН



2599

*Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн
45 дугаар тогтоолын хавсралт*

**МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ЖИШИГ
ҮНЭЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ**

№	Ажил үйлчилгээний нэр, төрөл	Мал, амьтны төрөл	Хэмжих нэгж	Нэгж үнэлгээ /төгрөг/
1	Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх	Бод (тэмээ, адуу, үхэр)	Толгой тутам	1000
		Бог (хонь, ямаа)	Толгой тутам	600
		Тэжээвэр амьтан (гахай, нохой, муур, шувуу)	Толгой тутам	1000
2	Мал, амьтны эрүүл мэндийн үзлэг	Бод мал, тэжээвэр амьтан	Толгой тутам	8000
		Бог мал	Толгой тутам	4000
		Диспансерчилсан үзлэг	Суурь сүрэг	1800
3	Халдваргүйтгэл хийх	Мал, амьтны хашаа, байр, өтөг бууц, түүхий эдийн цэг, агуулах зоорь	мкв	1000

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 9 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 04

Ар-Асгат

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАР ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дахь заалт, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.4 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит тавдугаар хуралдаанаас ТОГТООХ нь :

1.Сумын малчин иргэдээс гарсан саналын дагуу хэлэлцээд малын тоо толгойн албан татварыг хонь 500 төгрөг, ямаа 800 төгрөг, үхэр 1000 төгрөг, адуу 1000 төгрөг, тэмээ 0 төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2.Бэлчээрийн даац хэтэрсэнтэй холбогдуулан адуу, ямаа хөнгөлөхгүй малчдын амьжиргааг дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран үхэр 10, хонь 50 толгой тус бүрд ногдох албан татварын хэмжээг хөнгөлөн 0 төгрөг байхаар тогтоосугай.

3.Малын тоо толгойд ногдох албан татварыг холбогдох хууль, журамд заасны дагуу төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг сумын Засаг дарга (Ц.Энхболд), Татвар хураагч (Б.Мөнхбаяр) нарт даалгасугай

4.Энэхүү тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Болор-Эрдэнэ), Хууль эрх зүйн мэргэжилтэн (Б.Амарзаяа), Татвар хураагч (Б.Мөнхбаяр) нарт үүрэг болгосугай.

5.Энэхүү тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдсүгэй.

6.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлд үүрэг болгосугай.

7.Энэ тогтоол батлагдан гарсантай холбогдуулан “Малын тоо толгойн албан татвар тогтоох тухай” сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 06 дугаар сарын 21-ны 07 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Л. АМАРСАНАА

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 7384 дүгээрт бүртгэв.

УВС АЙМАГ ХЯРГАС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 10 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 20

Дэлгэр

БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14, 35.1.18 дахь заалтууд, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсгүүд, Захиргааны Ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн ээлжит 06 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

- 1.Сумын “Бэлчээр ашиглалтын журам”-ыг хавсралтаар баталсугай.
- 2.Тогтоолын хэрэгжилтийг хангаж, журмыг дагаж мөрдөх ажлыг зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга (В.Сайнбилэг)-т үүрэг болгосугай.
- 3.Энэхүү тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яам эрх зүйн хэм хэмжээний актаар бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
- 4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 18 дугаартай тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
- 5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Я.Батмөнх)-д үүрэг болгосугай.
- 6.Тогтоолын бүрдлийг хангаж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүйн мэргэжилтэн (Н.Бааст)-д даалгасугай.

ДАРГА

С.БУЛГАНХҮҮ

*Хяргас сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн
20 дугаар тогтоолын хавсралт*

ХЯРГАС СУМЫН БЭЛЧЭЭР АШИГЛАХ ЖУРАМ

Нэг.Зорилго:

1.1.Сумын малчид, мал бүхий иргэд бэлчээрийг зүй зохистой, хуваарьтайгаар ашиглах, хамгаалах, ургамлын зүйл, төрлийг нэмэгдүүлэх байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, бэлчээрийг түүний нөөц, даацад нь тохирсон мал сүрэг өсгөн үржүүлэх, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангахад журмын зорилго оршино.

Хоёр.Ерөнхий шаардлага:

2.1.Сумын иргэд нь багийн Засаг даргад хүсэлт гарган багийн Иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшөөрсөн бол өвөлжөө, хаваржааны бүс нутагт хашаа, бууц барьж эзэмшинэ. Зуслан, намаржааны бүс нутаг, бэлчээрт өвөлжөө, хаваржаа шинээр барихгүй.

2.2.Нөөцөлсөн бэлчээр, хадлангийн талбай өвөлжөө, хаваржаа, намаржааны бүс нутагт мал оруулан гишгүүлэх, чөлөөлсөн хугацаанаас түрүүлж идүүлэх болон зөвшөөрөлгүйгээр тус бүс нутагт нүүдэллэхгүй байх.

2.3.Бэлчээрийг зөв зохистой ашиглах талаар гаргасан бүдүүвч зураглал, цаг хугацаа, бэлчээрийн хуваарь зэргийг багийн Иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж нэг хувийг Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

2.4.Гаднаас дур мэдэн отрын айл, мал сүргийг зөвшөөрөлгүй оруулж, өвөлжөө, хаваржаа, хот бууцыг дамжуулан ашиглахгүй, бэлчээрт хашаа барихгүй байх.

2.5.Өөрийн эзэмшдэг өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны газрыг жил бүр ахуйн хог хаягдлаас цэвэрлэж нэгдсэн хогийн цэгт хүргэх

2.6.Бусад сумын айл өрх, мал сүрэг Хяргас суманд отроор болон түр тавиулаар ирэхээр бол багийн даргад санал хүргүүлж, сумын засаг дарга нар харилцан гэрээ байгуулж, мал эмнэлгийн гарал үүслийн бичиг авсан байх

2.7.Багийн засаг дарга нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.7.1.Гаднын сумаас гэрээ, зөвшөөрөл, мал эмнэлгийн үйлчилгээний бичиггүй орж ирсэн малчинд шаардлага өгч нүүлгэх.

2.7.2.Бэлчээр ашиглалтын журам зөрчсөн этгээдэд хугацаатай мэдэгдэх хуудас өгч сумын засаг даргад нэн даруй мэдэгдэх

2.7.3.Бэлчээрийг хуваарийн дагуу чөлөөлөөгүй этгээдийг албадан нүүлгэж гарсан зардлыг төлүүлэх

Гурав.Нутаг бэлчээрийг зохистой эзэмших ашиглах талаар:

3.1.Бэлчээр нутгийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах,нөхөн сэргээх шаардлагыг үндэслэн хаваржаа, зуслан, намаржаа, нөөц бэлчээр нутгийг доорх байдлаар тогтоов.

3.1.1.Зуслангийн бүс нутаг: Хангай баг: Хойд Баянгол, Бор бургасны дэнж, Нуурын ам, Бэл булаг, Цагаан тарвагат, Толь, урд Баянгол, Ендэрт, Баянбулаг, Өөхтэйн ам, Шаварт Бугат баг: Хуучин төв, Бэйсийн зааг, Гашуун, Найрт, Тагийн булаг, Баян худаг, хойд Суварга, Шон мод, Борхайрханы бэл, Ичээтийн гол, Ичээтийн хөвч, урд Суварга, Улаан хэрц, Шохойн цахир ам, Шалаан бэлчир, Улаан бумба, Байцаан гол, Хайрхан баг: Цагаан гол, Нарт, Цахт, Сарлагт, Хөх салаа, Давхар ус, Хар булаг, Марц, Шилийн хаг, Хүрмийн хаг

3.1.2.Хуц ухна маллах суурийн зусах, намаржих нутгийг багийн Иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.2.Хаваржаа, Намаржааны бүс нутаг: Хангай баг: Марц, Хангилцаг, Бухын голууд, Таван улиас, Өсрүүн, Адгийн хоо, Дунд хоо, Баянцагаан, Мушгиа худаг, Их худаг, Бураат худаг, Таригийн худаг, Давааны ам, Ар мухрууд Бугат баг: Булаг, Хөндлөн, Агьт, Хөшөөт, Хоо толгой, Могойт, Билүүгийн гол, Улаан нүүр, Хөх эрэг, Тахилт, Шар өндөр, Хавангийн худаг, Ламын худаг, Товчийн хар, Таригийн бор толгой, Бураагийн баруун хөдөө Хайрхан баг: Билүү, Шар толгой, Бурхад хад, Цалгар, Тараагийн гол, Адаргана, Зээрэн, Өвгөний марц, Дэлийн худаг, Сар толгой, Хүүрхээн сай, Зэлийн зүүн хөдөө

3.3.Хадлан өвс бэлтгэхийн тулд нөөцөлж байгаа бэлчээр нутгийг түрүүлж ашиглахгүй байх. Хадлан бэлтгэхдээ ургацыг гүйцээх болон үр боловсорсон үед бэлтгэж байх.

3.4.Сумын Засаг даргаас тухайн жилийн ургацын байдлыг харгалзан нөөц бэлчээр нутгийг тогтоох талаар сумын ИТХ-д санал хүргүүлж болно.

3.5.Онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд хаваржих, зусах, намаржих, өвөлжихийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. (Хүн малын гоц халдварт өвчин гарсан, хорио цээр, хязгаарлалт тогтоосон)

3.6.Тухайн жилийн өвс ургацын гарцын байдалтай уялдуулан хадлан өвс бэлтгэх талбайг багийн Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны саналыг үндэслэн сумын Засаг дарга хуваарилах ажлыг зохион байгуулна.

Дөрөв.Нөөцөлсөн бэлчээр хадлангийн талбайг тогтоох талаар:

4.1.Нөөцөлсөн нутаг бэлчээрийг ашиглах зайлшгүй шаардлага гарсан үед сумын Засаг дарга шийдвэр гарган хэрэгжилтийг хангуулна.

4.2.Сумын нутагт ашиглагддаггүй бэлчээр ашиглах зорилгоор уст цэг гарган бэлчээрээ тэлж ашиглаж байгаа малчдын бүлэг, иргэдийг дэмжин бэлчээр нутгийг нь ашиглуулж болно.

4.3.Бэлчээр ашиглах хуваарийг (зуслан гарах, намаржаа, өвөлжөөнд буух, нүүх гэх мэт) багийн Иргэдийн Нийтийн Хурлаар тухай бүр хэлэлцэн тогтоож малчдад танилцуулж мөрдүүлэх

Тав.Журмыг мөрдөх хугацааны талаар:

5.1.Өвөлжөөний бүс нутаг чөлөөлөх хугацаа: 4 дугаар сарын 10-аас 11 дүгээр сарын 10 хүртэл

5.2.Хадлангийн талбайг чөлөөлөх хугацаа: 5 дугаар сарын 15-аас 9 дүгээр сарын 15 хүртэл

5.3.Хаваржааны бүс нутагт нутаглах хугацаа: 4 дүгээр сарын 10-аас 06 дугаар сарын 25-нийг хүртэл

5.4.Намаржааны бүс нутагт нутаглах хугацаа: 8 дугаар сарын 15-аас 11 дүгээр сарын 10 хүртэл,

5.5.Зарим бүс нутагт нутаглах хугацаа 2 үе шаттай байна.Тухайн асуудлыг багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж тогтооно

5.6.Сумын төвийн суурин маллагааны бүсэд 5-р сарын 1-ээс 10-р сарын 15-ыг хүртэл саалийн үнээтэй байхыг зөвшөөрнө.

Зургаа. Малчид, мал бүхий иргэдийн хүлээх үүрэг:

6.1.Сумын малчид, мал бүхий иргэд тогтоолд заасан газруудад бэлчээрийг ашиглаж, газрынхаа гол ус, байгаль орчныг бохирдуулахгүй байх,

6.2.Сумын ИТХ-аас батлагдсан хуваарийн дагуу нутаг дэвсгэрт хамаарагдах зуслангийн газрыг сумын малчид, мал бүхий иргэд нийтээрээ эзэмших.

6.3.Бусад сум, орон нутгийн гэрээ, зөвшөөрөлгүйгээр малчдын малыг авч маллахгүй байх, мал худалдаж авах, бэлгэд авах тохиолдолд сумын мал эмнэлгийн үржлийн нэгжид мэдэгдэж урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах.

6.4.Сумын Засаг дарга болон холбогдох байгууллагуудаас гаргасан хэрэгжилт, эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх.

6.5.Өөрийн ашиглаж байгаа бэлчээрт ой хээрийн түймэр болон байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх.

6.6.Гол, горхи, булаг шандын эх ундаргыг хамгаалахаас бусад тохиолдолд бэлчээрийг хашиж хамгаалахгүй байх.

Долоо. Журмын биелэлтийг хангах талаар:

7.1.Энэ журмыг биелүүлэх, зохион байгуулж хяналт тавьж байх ажлын хэсгийг Байгаль орчин тогтвортой хөгжлийн тасаг, Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүд, Газрын даамал, багийн ИНХ-ын дарга, багийн Засаг дарга нарыг оролцуулан сумын Засаг даргын шийдвэрээр байгуулан тогтмол ажиллуулах.

7.2.Журам зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.3.Журмыг зөв хэрэгжүүлж байгаа малчин өрхийг урамшуулах, дэмжих, шагналд тодорхойлох, зээл тусламж дэмжлэгт хамруулах

7.4.Журмын биелэлтийн явцыг жил бүр сумын ИТХ-д танилцуулж цаашид зохион байгуулах арга хэмжээг тодорхойлох.

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар А/211

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалт, Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.“Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам”-ын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Газрын тосны бодлогын газар /Ч.Хишигдалай/, Ашигт малтмал, газрын тосны газарт тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан хуучин нэрээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/06 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Г.ДАМДИННЯМ

*Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 10 дугаар сарын
01-ний өдрийн А/211 дүгээр тушаалын хавсралт*

**ГАЗРЫН ТОС, УЛАМЖЛАЛТ БУС ГАЗРЫН ТОСНЫ ЭРЭЛ,
ХАЙГУУЛ, АШИГЛАЛТЫН ТАЛБАЙГ БУЦААН ӨГӨХ, ХҮЛЭЭН
АВАХ ЖУРАМ**

1 дүгээр зүйл.Ерөнхий зүйл

1.1.Энэхүү журам нь газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг гэрээлэгчээс газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад буцаан өгөх, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь талбайг гэрээлэгчээс хүлээн авахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаахад энэхүү журмыг баримтална.

1.3.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь эрлийн болон бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн ажил хийгдээгүй хэсгийг буцаан авахдаа тухайн сум, дүүргийн Засаг дарга, хэд хэдэн сум, дүүргийн нутаг хамарсан бол аймаг, нийслэлийн байгаль орчны газрын тодорхойлолтыг үндэслэн шийдвэрлэнэ.

2 дугаар зүйл.Талбайг буцаахад бүрдүүлэх баримт бичиг

2.1.Гэрээлэгч нь газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаахад дараах баримт бичгийг бүрдүүлэн газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Үүнд:

2.1.1.Албан хүсэлт;

2.1.2.Холбогдох зураг, мэдээлэл;

2.1.3.Буцаах талбайд гүйцэтгэсэн геологи, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан;

2.1.4.Бүтээгдэхүүн хуваах гэрээ, эсвэл эрлийн гэрээний хэрэгжилт (оноор);

2.1.5.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан;

2.1.6.Жил бүрийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайлан;

2.1.7.Буцаах талбайд хийгдсэн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын тайлан, дүгнэлт;

2.1.8.Буцаах талбайд өрөмдсөн цооногийн нөхөн сэргээлт хийсэн талбайгаас авсан хөрсний дээжид “Хөрсний чанарын стандарт”-ын дагуу итгэмжлэгдсэн лабораторид хийлгэсэн шинжилгээний тайлан, дүгнэлт;

2.1.9.Нөхөн сэргээлт хийсэн талбайг орон нутагт хүлээлгэн өгсөн акт;

2.1.10.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн холбогдох байгууллагууд, байгаль орчны асуудал эрхэлсэн төв, орон нутгийн байгууллага, салбарын хяналтын нэгжээс өгсөн үүрэг даалгавар, түүний хэрэгжилт.

2.2.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь талбай буцаан өгөх тухай гэрээлэгчийн хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор “талбай буцаан авахад дүгнэлт гаргах үүрэг бүхий” ажлын хэсгийг байгуулах хүсэлтийг Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

3 дугаар зүйл.Дүгнэлт гаргах

3.1.Газрын тосны болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын алба, нутгийн удирдлагын байгууллагын төлөөллийг оролцуулсан “талбай буцаан авахад дүгнэлт гаргах үүрэг бүхий” ажлын хэсгийг 14 хоногийн дотор байгуулна.

3.2.Ажлын хэсгийн ахлагч нь ажлын хэсэг байгуулагдсанаас хойш 7 хоногийн дотор ажлын төлөвлөгөөг батална.

3.3.Ажлын хэсэг буцааж буй талбайтай газар дээр нь танилцаж, тухайн талбайд хийгдсэн ажил нь холбогдох хууль, журам, стандартын шаардлага хангасан эсэхэд дүгнэлт гаргаж, шаардлагатай тохиолдолд илэрсэн зөрчлийг арилгуулах талаар албан шаардлагыг ажлын 10 хоногт багтаан гэрээлэгчид хүргүүлнэ.

3.4.Гэрээлэгч ажлын хэсгээс хүргүүлсэн шаардлагыг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор биелүүлж, ажлын хэсэгт албан бичгээр биелэлтийг ирүүлнэ.

3.5.Шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг шаардлагын биелэлтийг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор газар дээр нь дахин шалгаж дүгнэлт гаргана.

3.6.Ажлын хэсгээс ирүүлсэн нэгдсэн санал дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Газрын тосны асуудал эрхэлсэн салбарын зөвлөлийн хуралдаанд 45 хоногийн дотор танилцуулж, эцсийн шийдвэр гаргана.

3.7.Ажлын хэсгийн дүгнэлт, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Газрын тосны асуудал эрхэлсэн салбар зөвлөлийн шийдвэр ил тод нээлттэй байна. Энэхүү шийдвэрийг ажлын хэсэг шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор холбогдох байгууллагын цахим хуудаст нийтэлнэ.

4 дүгээр зүйл.Цооног хүлээлгэн өгөх

4.1.Цооногийг дараах байдлаар битүүмжилсэн байна:

4.1.1.Цооногийн амсрыг олон улсын жишгийн дагуу тухайн газрын түвшинтэй ижил түвшинд ган таглаагаар таглан, гагнаж битүүмжлэн эрэл эсвэл хайгуулын талбайн нэр, цооногийн дугаар, цооногийг өрөмдөж эхэлсэн болон дууссан огноог тэмдэглэнэ;

4.1.2.Тосны илрэлтэй цооногуудыг хаахдаа перфораци хийсэн интервалаас дээш 50 метрээс багагүй зузаантай цементээр цутган, цооногийн дотоод тоноглолыг баримтжуулан хүлээлгэн өгнө.

4.2.Цооног орчмын нөлөөлөлд өртсөн газрын гадаргууд “Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, техникийн ерөнхий шаардлага” MNS 6200:2010 стандартын дагуу нөхөн сэргээлт хийгдсэн байна.

5 дугаар зүйл.Бусад

5.1.Гэрээлэгч нь энэ журмын 3 дугаар зүйлд заасан талбай буцаан авах эцсийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлнө.

5.2.Талбай буцаахтай холбогдон гарах зардлыг гэрээлэгч хариуцна.

5.3.Газрын тосны тухай хуулийн 39 дүгээр зүйл, Бүтээгдэхүүн хуваах гэрээний 17 дугаар зүйлд заасны дагуу ажлын хэсэг тухайн буцаан өгч буй талбайн газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулж ирсэн гэрээлэгчийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материал, үл хөдлөх хөрөнгийг Монгол Улсын өмчлөлд шилжүүлэх асуудлыг гэрээлэгчтэй харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

5.4.Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.9-д заасны дагуу эскроу дансанд байршуулсан хөрөнгө гэрээлэгчийн байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх баталгаа болно. Нөхөн сэргээлтийг дахин гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцохгүй.

5.5.Гэрээлэгч ашиглалтын талбайг бүхэлд нь буцаан өгөхдөө орд хаах, татан буулгах үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр зохицуулна.

5.6.Энэ журмын 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасан хөрөнгийг ажлын хэсэг шилжүүлэн авахаас татгалзсан тохиолдолд гэрээлэгч нь техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материал, үл хөдлөх хөрөнгийг тухайн буцаан өгч буй талбайгаас бүрэн чөлөөлнө.

5.7.Гэрээлэгч нь Газрын тосны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.9 дэх хэсэгт заасны дагуу баталгаат нөөцөөс ашиглалтын үйл ажиллагаа явуулах бөгөөд газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд ашиглалтын талбайн аль нэг хэсгийн

баталгаат нөөцийг ашиглахаар тусгаагүй бол энэ нь тухайн ашиглалтын талбайгаас хэсэгчлэн буцаан авах үндэслэл болно.

5.8.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн ашиглалтын талбайгаас хэсэгчлэн буцаан авах саналыг гарган гэрээлэгч талд мэдэгдэж, буцаан авах асуудлыг энэ журмын дагуу шийдвэрлэнэ.

5.9.Гэрээлэгч нь энэ журмын 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт заасан хугацаанд ажлын хэсгээс хүргүүлсэн шаардлагын биелэлтийг ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийн төлбөрийг хэтэрсэн хугацаанд нэмж тооцно.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 7386 дугаарт бүртгэв.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар А/254

Улаанбаатар
хот

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг зохицуулах Иргэний нисэхийн дүрэм “ИНД-140 Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Иргэний нисэхийн дүрмийг мөрдөж, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн шаардлагатай тохиолдолд боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр), энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газар (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Багц дүрэм батлах тухай” 187 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-4 “Нисэхийн салбарт гэрээгээр ажил гүйцэтгүүлэх, нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор холбогдох байгууллагатай хамтран ажиллах, агаарын хөлгийн үзлэг, шалгалт хийх эрх олгох”-ын “ИНД-140 Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт”-ийг бүхэлд нь хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний
өдрийн А/254 дүгээр тушаалын хавсралт*

ИНД-140 Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт

А Бүлэг - Ерөнхий зүйл

140.1. Зорилго

(а) Энэ дүрмээр аюулгүйн хамгаалалттай аэродром, эсхүл аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламжид нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны шаардлагыг тогтооно.

140.3. Нэр томьёо ба товчлол

(а) Энэ дүрэмд хэрэглэсэн нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбарт тусгасан.

140.5. Гэрчилгээний шаардлага

(а) Энэ дүрмийн дагуу олгосон Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага (цаашид “НАХҮБ” гэх)-ын гэрчилгээний эрхийн хүрээ болон нөхцөлөөс гадуур, аливаа этгээд аюулгүйн хамгаалалттай аэродром, эсхүл аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламжид нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэхгүй.

140.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24140/01 маягыг бөглөж, дараах баримтын хамт Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч (цаашид “Дарга” гэх)-д хүргүүлнэ:

(1) 140.61-д шаардсан Ерөнхий заавар;

(2) төлбөрийн баримт;

(3) хүсэлт гаргагч нь олон улсын нисэх буудалд нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ гүйцэтгэх бол төрийн өмчит хуулийн этгээдийн бүртгэлийг нотлох баримт.

140.9. Гэрчилгээ олгох

(а) Хууль болон энэ дүрмийн дагуу Дарга дараах тохиолдолд НАХҮБ-ын гэрчилгээ олгоно, хэрэв:

(1) хүсэлт гаргагч болон 140.51(а)(1), (2)-т шаардсан удирдах ажилтнууд нь тохирох зөв хүн байх;

(2) хүсэлт гаргагч нь:

(i) НАХҮБ бол; эсхүл

(ii) аюулгүйн хамгаалалттай аэродром, эсхүл аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламжийн үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн аэродром, эсхүл навигацийн байгууламжид нисэхийн аюулгүйн

хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх бол;

(3) хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь В Бүлгийн шаардлага хангасан бол;

(4) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтын ашиг сонирхолд харшлахгүй бол.

140.11. Гэрчилгээ эзэмшигчийн гүйцэтгэх ажил, үүрэг

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт заасан байршил бүрд дараах ажил, үүргийг гүйцэтгэнэ:

(1) аюулгүйн хамгаалалттай аэродромд:

(i) агаарын хөлгийн зорчигч, агаарын хөлгийн баг, тэдгээрийн биедээ авч яваа эд зүйлс, гар тээш, тээш болон ачаа, шуудан, нислэгийн хоол хүнс, хангамжийн эд зүйлсэд аюулгүйн үзлэг, шалгалт хийх, эсхүл Даргын үзлэг, шалгалт хийхийг шаардсан бусад үйлчилгээнд аюулгүйн үзлэг, шалгалт хийх;

(ii) шаардлагатай бол агаарын хөлгийг шалгах;

(iii) аэродромын аюулгүйн хамгаалалтын эргүүл хийх;

(iv) Даргын шаардсан, өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд байгаа, эсхүл нэвтрэх гэж байгаа этгээд, эд зүйл, бодис, эсхүл тээврийн хэрэгсэлд Даргын баталсан аюулгүйн үзлэгийн тусгай хэлбэр, эсхүл аргачлалын дагуу аюулгүйн үзлэг шалгалт хийх;

(2) аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламжид эргүүл хийх;

(3) иргэний нисэх болон түүнд ажиллагсад, эсхүл түүний үйлчилгээг авч байгаа этгээдийг хамгаалахтай холбоотой аюулгүйн хамгаалалтын арга техник, тогтолцоо, хэрэгсэл, практик дадал болон журмыг хянах, судлах, түүний талаар тогтмол мэдээлэлтэй байх;

(4) өөрийн ажил үүргийг энэ дүрмийн дагуу илүү үр дүнтэй гүйцэтгэх зорилгоор цагдаа, төрийн байгууллага, нисэх буудлын эрх бүхий байгууллага, үйл ажиллагаа эрхлэгч болон бусад улсын нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ хариуцсан эрх бүхий байгууллага, холбогдох олон улсын байгууллагатай хамтран ажиллах.

(b) Энэ зүйлийн (а)-г үл харгалзан, НАХҮБ нь Монгол Улсын Нисэхийн аюулгүйн хамгаалалтын журамд заасан ажил, үүргийг гүйцэтгэнэ.

(c) [хүчингүй болгосон]

140.13. Гэрчилгээний хугацаа

(а) НАХҮБ-ын гэрчилгээг 5 жилээс ихгүй хугацаагаар олгож, эсхүл гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгаж болно.

(b) НАХҮБ-ын гэрчилгээ нь түүний хүчинтэй хугацаа дуусах, түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй хэвээр байна.

(c) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа

дууссан, эсхүл хүчингүйд тооцсон тохиолдолд гэрчилгээг Даргад хураалгана.

(д) Гэрчилгээг түдгэлзүүлэх шийдвэр гарсан тохиолдолд НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлнэ.

140.15. Гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах

(а) Гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах хүсэлт гаргах НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө САА 24140/01 маягыг бөглөж, төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй.

В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага

140.51. Ажилтанд тавигдах шаардлага

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:

(1) Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон дараах удирдах ажилтан:

(i) энэ дүрэмд заагдсан үйл ажиллагааны шаардлага, стандартыг хангах зорилгоор байгууллагын зүгээс авч хэрэгжүүлэх бүх үйл ажиллагааг тухайн байгууллагын хэмжээнд санхүүжүүлэх, хэрэгжүүлэх бүрэн эрхтэй;

(ii) энэ дүрэмд заасан шаардлага, стандартыг хангаж байгааг хүсэлт гаргагчийн өмнөөс бүрэн хариуцах;

(2) Гүйцэтгэх захирлын өмнө дараах үүрэг хариуцлага хүлээсэн удирдах ажилтнууд:

(i) тухайн хүсэлт гаргагч байгууллага нь Ерөнхий зааврыг дагаж мөрдөж байгааг бататгах;

(ii) 140.59-д шаардсан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны хэрэгжилтийг хангах;

(3) 140.61(а)(7)-д дэлгэрэнгүй заасан нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг төлөвлөх, шалгах, хянах болон гүйцэтгэх хангалттай тооны ажилтан.

(аа) Энэ зүйлийн (а)(2)(ii)-т шаардсан удирдах ажилтан нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоотой холбоотой ур чадвар, туршлагаа нотолсон байна.

(b) Хүсэлт гаргагч нь:

(1) тухайн ажил үүрэг гүйцэтгэхээр хүсэлт гаргасан этгээдийн ур чадварт суурь үнэлгээ хийх журам болон Нисэхийн аюулгүйн хамгаалалт (цаашид "НАХ" гэх)-ын ажилтны ажлын байрны шаардлагыг дараах шалгуурыг харгалзан тогтооно:

(i) боловсрол;

(ii) харилцааны чадвар;

(iii) зан харьцаа;

(iv) туршлага;

(v) эрүүл мэнд;

(2) энэ зүйлийн (b)(1)-ийн шаардлага хангасан ажилтныг НАХ-ын ажилтнаар томилно;

(3) НАХ-ын ажилтныг сургах болон ур чадварыг хадгалах журмыг тогтооно;

(4) 140.61(a)(7)-д заасан нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг төлөвлөх, шалгах, хянах болон гүйцэтгэх ажилтанд түүний эрхийн хүрээг тодорхойлсон баримт бичгийг олгоно.

(с) Аюулгүйн үзлэг, шалгалт хийх НАХ-ын ажилтан нь Даргын олгосон эрх бүхий үнэмлэхтэй байна.

140.53. Үйл ажиллагааны журам тогтоох

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тогтоосон аэродромд аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх бол Хавсралт А-д заасан шаардлагыг бататгах журамтай байна.

(b) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тогтоосон навигацийн байгууламжид аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх бол А.12(d)-д заасан шаардлагыг бататгах журамтай байна.

140.55. Баримт бичиг

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ажилтан ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг дэмжихэд чиглэсэн бүх баримт бичгийг авч ашиглах боломжтой хэлбэрээр хангадаг болохыг бататгах журамтай байна.

(b) Энэ зүйлийн (а)-д заасан баримт бичигт дараах баримт бичиг багтсан байна:

(1) холбогдох бүх хууль тогтоомж, дүрэм, журам;

(2) нисэхийн аюулгүйн хамгаалалттай холбоотой олон улсын техникийн заавар, эсхүл мэдэгдэл;

(3) Даргаас тухайн гэрчилгээ эзэмшигчид олгосон баримт бичиг;

(4) гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий заавар.

(с) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (а)-д заасан дараах шаардлагыг бататгах баримт бичгийн хяналтын журамтай байна:

(1) тухайн баримт бичгийг гаргахаас өмнө 140.51-д заасан холбогдох удирдах ажилтан хянаж, зөвшөөрдөг байх;

(2) холбогдох баримт бичгийн хүчинтэй хувь нь ажилтан тухайн баримт бичгийг ашиглахад хэрэгтэй байрлал бүрд бэлэн байх;

(3) хугацаа нь дууссан баримт бичгийг олгох, эсхүл ашиглах бүх цэгээс нэн даруй хурааж авдаг байх;

(4) баримт бичигт орсон өөрчлөлтийг 140.51-д заасан удирдах ажилтан хянаж, баталгаажуулдаг байх;

(5) баримт бичгийн хүчинтэй хувь нь танигддаг байх;

(6) 140.61-д заасан байгууллагын Ерөнхий зааварт, тухайн үйлчилгээ үзүүлэгч, түүний үйлчилгээ, журам болон байгууламжийн тодорхойлолт хүчинтэй хэвээр хадгалагдаж байхаар өөрчлөлт хийдэг байх.

(d) Хүсэлт гаргагч нь Ерөнхий зааврын хувийг 140.61(а)(5)-д заасан байрлал бүрд бэлэн байлгаж, бүртгэл хөтлөх журмыг тогтоосон байна.

140.57. Бүртгэл хөтлөх

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ дүрмийн нийцлийг бататгахад шаардлагатай, бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах болон хөтлөх журмыг тогтоосон байна.

(b) Хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоосон байна:

(1) НАХ-ын ажилтны туршлага, мэргэшил, ур чадвар, сургалт, эрүүл мэндийн үнэлгээ болон хүчинтэй зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан бүртгэл хөтлөх;

(2) дараах шаардлагыг хангасан болохыг бататгах:

(i) бүх бүртгэл нь гаргацтай уншигдахуйц, байнгын шинж чанартай байх;

(ii) энэ зүйлийн (b)(1)-д шаардсан бүртгэлийг, гэрчилгээ эзэмшигч нь НАХ-ын ажилтны эрхийг зогсоосноос хойш 2 жилийн хугацаанд хадгалдаг байх;

(iii) энэ зүйлийн (b)(1)-д шаардсанаас бусад бүртгэлийг 2 жилийн хугацаанд хадгалдаг байх.

140.59. Дотоод чанар баталгаажуулалт

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч энэ дүрмээр шаардсан журмын шаардлага хангасан ба тухайн байгууллага түүнийг хэрэгжүүлж байгааг бататгах зорилгоор дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн байна.

(b) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь дараах журмыг багтаасан байна:

(1) хүсэлт гаргагчийн байгууллагын зорилго болон түүний үйлчлүүлэгчийн хүсэл эрмэлзэл, хэрэгцээнд тохирсон аюулгүйн хамгаалалтын бодлого болон аюулгүйн хамгаалалтын бодлогын журам;

(2) тухайн тогтолцоонд оршиж байгаа хүндрэлтэй асуудал, эсхүл түүний боломжит шалтгааныг тогтоох зорилгоор гэмтэл, зөрчлийн тайлан болон ажилтан, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг багтаасан чанарын үзүүлэлтэд мониторинг хийдэг болохыг бататгах журам;

(3) тухайн тогтолцоонд илэрсэн хүндрэлтэй асуудлыг залруулдаг

болохыг бататгах залруулах арга хэмжээний журам;

(4) тухайн тогтолцоонд илрүүлсэн хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг арилгадаг болохыг бататгах урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам;

(5) хүсэлт гаргагчийн байгууллага нь өөрийн Ерөнхий зааварт заасан журамтай нийцэж байгаа болон аюулгүйн хамгаалалтын бодлогод тусгасан зорилтод хүрснийг шалгах чанарын дотоод аудитын хөтөлбөр;

(6) статистикийн дүн шинжилгээг ашиглан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны байнгын тохирол болон үр дүн нь энэ дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах удирдлагын дүгнэлт хийх журам;

(7) дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан нь аюулгүйн хамгаалалтад нөлөөлөх асуудлаар Гүйцэтгэх захиралтай шууд харьцах эрхтэй болохыг бататгах журам.

(с) Аюулгүйн хамгаалалтын бодлогын журам аюулгүйн хамгаалалтын бодлогыг байгууллагын бүх түвшинд ойлгодог, хэрэгжүүлдэг болон мөрддөг болохыг бататгана.

(d) Залруулах арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг заасан байна:

(1) залруулагдаагүй байгаа, эсхүл хүндрэлтэй асуудлыг залруулах;

(2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах зорилгоор залруулах арга хэмжээг эргэн шалгах;

(3) удирдах ажилтан залруулах арга хэмжээний үр дүнг үнэлэх.

(е) Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг заасан байна:

(1) хүндрэл үүсгэж болох асуудлыг залруулах;

(2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах зорилгоор урьдчилан сэргийлэх арга хэмжээг эргэн шалгах;

(3) урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд энэ дүрмийн дагуу шаардсан журамд өөрчлөлт оруулах;

(4) удирдах ажилтан урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг үнэлэх.

(f) Чанарын дотоод аудитын хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) аудит хийгдэх ажиллагааны шинж чанартай уялдуулан аудитын давтамж болон байрлалыг заасан байх;

(2) тухайн аудитыг сургалтад хамрагдсан бөгөөд аудит хийгдэж байгаа ажиллагаанд шууд хариуцлага хүлээдэг этгээдээс хамааралгүй ажилтан хийдэг болохыг бататгах;

(3) аудитын үр дүнг аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтанд болон дотоод аудит хариуцсан менежерт мэдээлдэг болохыг бататгах;

(4) хэрэв тухайн аудитаар хүндрэлтэй асуудал илэрсэн бол аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтнаас урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээ авахыг шаарддаг байх;

(5) авч хэрэгжүүлсэн залруулах, эсхүл урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд дүгнэлт хийх зорилгоор эргэн шалгах аудит хийдэг болохыг бататгах.

(г) Удирдлагын дүгнэлт хийх журам нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) тухайн тогтолцооны байнгын үр дүнтэй байх хэрэгцээ шаардлагыг авч үзсэний үндсэн дээр чанар баталгаажуулалтын тогтолцооны удирдлагын дүгнэлт хийх давтамжийг тодорхойлсон байх;

(2) тухайн чанар баталгаажуулалтын тогтолцоонд дүгнэлт хийх менежерийг томилсон байх;

(3) тухайн дүгнэлтийн үр дүнг дүгнэж, бүртгэл хөтөлдөг болохыг бататгах.

140.61. Байгууллагын Ерөнхий заавар

(а) Нисэхийн аюулгүй хамгаалалтын үйлчилгээ үзүүлэхээр гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журам болон тогтолцооны дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан Ерөнхий зааврыг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

(1) дараах шаардлагыг бататган, хүсэлт гаргагч байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:

(i) Ерөнхий заавар нь байгууллагын зохион байгуулалтын бүтцийг тодорхойлох ба энэ дүрмийн байнгын хэрэгжилтийг хангах хэлбэр болон аргыг харуулсан байх;

(ii) байгууллагын ажилтнууд Ерөнхий заавар, холбогдох бусад бүх журам, зааврыг байнга дагаж мөрддөг байх;

(2) 140.51(а)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтнуудын албан тушаал, нэр;

(3) хариуцсан чиг үүргийн хүрээнд тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харилцах асуудлууд;

(4) энэ зүйлийн (а)(2)-т заасан ажилтан болон хяналтын ажилтны хариуцлагын хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;

(5) нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж байгаа байгууллагын бүх байршил болон байршил бүрийн байгууламжийн дэлгэрэнгүй мэдээлэл;

(6) энэ зүйлийн (а)(5)-д заасан байршил бүрд шаардлагатай,

тухайн байгууллагын ажиллагсдын бүтцийн хураангуй;

(7) байршил бүрд үзүүлэх нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл;

(8) эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлтийн хамрах хүрээ болон Хавсралт А.22-т шаардсан бие бялдрын үнэлгээний аргын дэлгэрэнгүй мэдээлэл;

(9) 140.53-т заасан үйл ажиллагааны журам;

(10) 140.55-д заасан нисэхийн аюулгүйн хамгаалалтын баримт бичгийн хяналт болон түгээлтийн журам;

(11) 140.57-д заасан бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах болон хөтлөх журам;

(12) 140.59-д заасан хүсэлт гаргагчийн байгууллагын дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо;

(13) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт, өөрчлөлт оруулах болон түгээх журам;

(14) ИНД-12-ын дагуу аюулгүйн хамгаалалтын зөрчлийг Даргад мэдээлэх, шинжлэн шалгах болон тайлагнах журам;

(15) аюултай барааны илрүүлэлтийг Даргад мэдээлэх журам.

(b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар Даргаар хүлээн зөвшөөрөгдсөн байна.

С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага

140.101. Байнгын хэрэгжилт

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

(1) Ерөнхий зааврын нэгээс доошгүй хүчинтэй бүрэн хувийг Ерөнхий зааварт заасан байрлал тус бүрд байнга хадгална;

(2) Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан бүх журам болон тогтолцоог байнга дагаж мөрдөнө;

(3) Ерөнхий зааврын холбогдох бүлгийг шаардлагатай ажилтан ажил үүргээ гүйцэтгэхдээ байнга ашиглахаар бэлэн байлгана;

(4) дараах шаардлага болон стандартыг байнга хангаж мөрдөнө:

(i) В Бүлгийн шаардлага;

(ii) 140.53-ын дагуу журамтай байхыг шаардсан Хавсралт А-ийн заалт.

140.103. Ерөнхий зааварт өөрчлөлт оруулах

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:

(1) Ерөнхий зааврын нэмэлт, өөрчлөлтийг тухайн байгууллагын тодорхойлолт хүчинтэй хэвээр хадгалагдаж байхаар хийдэг болохыг бататгах;

(2) Ерөнхий зааварт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь энэ дүрмийн холбогдох шаардлагыг хангаж байгааг бататгах;

(3) Ерөнхий зааварт заасан нэмэлт, өөрчлөлтийн журмыг мөрдөх;

(4) Ерөнхий зааварт нэмэлт, өөрчлөлт оруулсан даруйд нэмэлт, өөрчлөлтийн хувийг Даргад нэн даруй хүргүүлэх;

(5) нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах зорилгоор шаардлагатай гэж Даргын үзсэн нэмэлт, өөрчлөлтийг Ерөнхий зааварт оруулах.

(b) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг хийхийн өмнө Даргын зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай:

(1) Гүйцэтгэх захирал;

(2) нэр заагдсан удирдах ажилтнууд;

(3) нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх байрлал;

(4) гэрчилгээнд заасан үйл ажиллагааны цар хүрээ;

(5) байгууллагын дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо.

(c) Энэ зүйлийн (b)-д заасан өөрчлөлтийг хийх хүсэлтийг САА 24140/01 маягтын дагуу гаргана.

(d) Энэ зүйлийн (b)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл хийсний дараа дагаж мөрдөх нөхцөлийг Дарга тогтоож болно.

(e) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (d)-ийн дагуу тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.

(f) Энэ зүйлийн (b)-д заасан өөрчлөлт нь гэрчилгээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардаж байгаа бол НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлнэ.

Хавсралт А - Аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааны стандарт

А.1. Үзлэгийн дараах бүсийг шалгах

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана:

(1) НАХ-ын ажилтан нь үзлэгийн дараах бүсийн бүрэн шалгагдсан байдлыг баталгаажуулах зорилгоор дараах нөхцөлд шалгалт хийдэг байх:

(i) аюулгүйн үзлэг, шалгалт эхлэхийн өмнө;

(ii) тухайн бүсийн хяналт алдагдсан байж болзошгүй үед.

(2) НАХ-ын ажилтан нь үзлэгийн дараах бүсэд шалгалт хийхдээ:

(i) үзлэгийн дараах бүсэд ямар нэгэн зөвшөөрөгдөөгүй эд зүйл орхиогүй, эсхүл нуугаагүйг шалгах;

(ii) аюулгүйн үзлэг, шалгалтад хамрагдсан бүх этгээдийг аюулгүйн үзлэг, шалгалтад хамрагдаагүй этгээдээс тусгаарласныг шалгах.

(3) дараах үечлэлээр сорилт, эсхүл шалгалт хийх:

(i) үзлэгийн дараах бүсийн шалгалтыг бүрэн гүйцэд хийж байгаа байдлыг 28 хоног тутамд;

(ii) А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу, үзлэгийн дараах бүсийн шалгалтыг гүйцэтгэдэг НАХ-ын ажилтнуудын ур чадварыг 150 хоног тутамд.

А.2. Үзлэгийн дараах бүсийн аюулгүйн хамгаалалтын хяналт

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана:

(1) тухайн агаарын хөлөгт зөвшөөрөгдөөгүй эд зүйл нэвтрээгүй болохыг бататгах зорилгоор, зорчигчоос бусад этгээд үзлэгийн дараах бүсэд авч орох, эсхүл хүргэх бүх бараа болон хангамжийн зүйлд аюулгүйн үзлэг, шалгалт эсхүл аюулгүйн хамгаалалтын хяналт хийх;

(2) НАХ-ын ажилтан нь үзлэгийн дараах бүсийн бүрэн шалгагдсан байдлыг бататгах зорилгоор үзлэгийн дараах бүс доторх хөдөлгөөнд хяналт тавих.

А.3. Агаарын хөлгийн шалгалт

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь НАХ-ын ажилтан агаарын хөлгийн шалгалтыг хийхдээ дараах шаардлагыг хангасан болохыг бататгана:

(1) зорчигчийн суудал, суудлын дээрх тээшний тасалгаа, шалны талбай, бие засах газар болон өмнөх үйлчилгээнд зорчигчийн нэвтэрсэн байж болох бусад хэсгийг хамруулах;

(2) бүхээгт нуусан, эсхүл бусад хэлбэрээр нэвтрүүлсэн зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг илрүүлэхийн тулд илүү сонор сэрэмжтэй байж, анхаарал хандуулах.

(b) Тухайн нислэг өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн бол НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан болохыг бататгана:

(1) НАХ-ын ажилтан нь үйл ажиллагаа эрхлэгчтэй хамтран тухайн агаарын хөлгийг бүрэн гүйцэд шалгах;

(2) үйл ажиллагаа эрхлэгчийн тухайн агаарын хөлөгт зориулан гаргасан шалгах хуудсыг ашиглан төлөвлөгөөт хэлбэрээр тухайн шалгалтыг гүйцэтгэх;

(3) тухайн шалгалтаар агаарын хөлөгт нуусан, эсхүл бусад хэлбэрээр нэвтрүүлсэн зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг илрүүлэхийн тулд илүү сонор сэрэмжтэй байж, анхаарал хандуулах.

(c) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана:

(1) энэ зүйлийн (a), эсхүл (b)-ийн дагуу хийсэн шалгалтын хувьд, дараах дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан бүртгэл хөтлөх:

(i) тухайн шалгалтыг хийсэн ажилтны нэр;

(ii) илрүүлсэн зөвшөөрөгдөөгүй эд зүйл;

(iii) аюулгүй болгох арга хэмжээ авсан эсэх.

(2) дараах шаардлагыг бататгах сорилт, эсхүл шалгалт хийх:

(i) шалгасан байхыг шаардсан агаарын хөлгийн шалгалтыг бүрэн гүйцэд хийж байгаа байдлыг 28 хоног тутамд;

(ii) А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу, аюулгүйн үзлэг хийгдээгүй, эсхүл агаарын хөлгийн өндөр эрсдэлтэй шалгалт гүйцэтгэдэг НАХ-ын ажилтнуудын ур чадварыг 150 хоног тутамд.

А.4. Аюулгүйн үзлэгийн цэгийн хамгаалалт болон төхөөрөмж

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана:

(1) тухайн аюулгүйн үзлэгийн цэг нь аюулгүйн хамгаалалтын хяналтгүй бүсээс үзлэгийн дараах бүсэд нэвтрэх бүх этгээд тухайн цэгээр заавал дамжин өнгөрдөг байхаар байрлах;

(2) тухайн агаарын хөлгийн хөөрөлтийг шалтгаангүйгээр саатуулахгүй байхаар үзлэгийн стандартыг ханган аюулгүйн үзлэг, шалгалтыг гүйцэтгэхэд хангалттай тооны ажилтан болон төхөөрөмжтэй байх;

(3) агаарын хөлөгт тээвэрлэх боломжтой овор ихтэй эд зүйлийг бүртгэгдсэн тээш хэлбэрээр тээвэрлүүлэхээр холбогдох агаарын тээвэрлэгчид хүлээлгэн өгдөг байх;

(4) НАХ-ын ажилтан нь стандарт сорилын биет ашиглан тухайн аюулгүйн үзлэгийн төхөөрөмжийг чадварлагаар шалгаж чадахыг бататгах зааварчилгаа авдаг байх;

(5) аюулгүйн үзлэгийн цэгт ашиглаж байгаа металл илрүүлэгчид нь:

(i) зорчигчийн аюулгүйн үзлэг, шалгалт эхлэхээс өмнө Даргын хүлээн зөвшөөрөхүйц стандарт сорилын биетээр сорилт хийх;

(ii) зөвхөн тухайн стандарт сорилын биетэд эерэг хариу өгсөн нөхцөлд ашиглах.

(6) аюулгүйн үзлэгийн цэгт ашиглаж байгаа рентген аппаратад Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр сорилт хийх.

А.5. Хүнд аюулгүйн үзлэг, шалгалт хийх

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь аюулгүйн үзлэгийн цэг бүрд бүх этгээд аюулгүйн үзлэгээр орохыг анхааруулсан дараах мэдэгдлийг байрлуулна:

(1) түүнд, эсхүл түүний тээшинд хийх;

(2) аюулгүйн үзлэг, шалгалт хийлгэхээс татгалзсан этгээдийг тухайн цэгээс цааш нэвтрүүлдэггүй байх;

(3) аюулгүйн үзлэг, шалгалт хийлгэхээс татгалзсан зорчигчийг агаарын тээвэрлэгч тээвэрлэхээс татгалзах.

(b) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана:

(1) НАХ-ын ажилтан нь аливаа этгээдэд аюулгүйн үзлэг, шалгалт хийснээс бусад тохиолдолд тухайн этгээдийг аюулгүйн үзлэгийн цэгээр дамжин үзлэгийн дараах бүсэд нэвтрэхийг зөвшөөрдөггүй байх;

(2) тухайн этгээдийг Төрийн тусгай хамгаалалтын хуулиар чөлөөлснөөс бусад тохиолдолд НАХ-ын ажилтан тухайн зорчигч, эсхүл багийн гишүүнд аюулгүйн үзлэг, шалгалт хийхгүйгээр үзлэгийн дараах бүсэд нэвтрэхийг зөвшөөрдөггүй байх;

(3) НАХ-ын ажилтан аливаа этгээдэд аюулгүйн үзлэг, шалгалт хийхдээ, тухайн этгээд зөвшөөрөгдөөгүй эд зүйл тээвэрлээгүй, эсхүл биедээ авч яваагүй болохыг бататгах;

(4) дараах шаардлагыг бататгах сорилт, эсхүл шалгалт хийх:

(i) аюулгүйн үзлэг, шалгалтыг бүрэн гүйцэд хийж байгаа байдлыг 28 хоног тутамд;

(ii) А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу аюулгүйн үзлэг, шалгалтыг гүйцэтгэдэг НАХ-ын ажилтнуудын ур чадварыг 150 хоног тутамд.

А.6. Рентген төхөөрөмж, бусад төхөөрөмжөөр аюулгүйн үзлэг, шалгалт хийх

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь НАХ-ын ажилтан эд зүйлд рентген төхөөрөмж ашиглан аюулгүйн үзлэг, шалгалт хийхдээ дараах шаардлагыг хангасан болохыг бататгана:

(1) тухайн зүйлд зөвшөөрөгдөөгүй эд зүйл агуулагдаагүй гэдэгт итгэлтэй байх;

(2) рентген төхөөрөмжийн дэлгэцэн дээр гарсан дүрсийг 20 минутаас дээш хугацаагаар тасралтгүй ажиглахгүй байх;

(3) зөвхөн Даргын зөвшөөрсөн рентген төхөөрөмж, эсхүл бусад төхөөрөмж ашиглах.

(b) Тухайн эд зүйл өөр эд зүйлд агуулагдсаны улмаас рентген төхөөрөмжийн шалгалтаар зөвшөөрөгдөөгүй эд зүйл биш болох нь үнэн зөв танигдахгүй байгаа, эсхүл ямар нэг эргэлзээ байгаа бол НАХ-ын ажилтан нь эд зүйлийг зөв таних хүртэл тухайн эд зүйл, эсхүл түүнийг авч яваа этгээдийг үзлэгийн дараах бүсэд нэвтрэхийг зөвшөөрдөггүй болохыг НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч бататгана.

(c) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгах сорилт, эсхүл шалгалт хийнэ:

(1) рентген төхөөрөмжийн аюулгүйн үзлэг, шалгалтын зөв ажиллагааг 28 хоног тутамд;

(2) А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу, рентген төхөөрөмжөөр аюулгүйн үзлэг, шалгалт гүйцэтгэдэг НАХ-ын ажилтны

ур чадварыг 150 хоног тутамд.

А.7. Гар тээшийг гараар шалгах

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана:

(1) НАХ-ын ажилтан нь гар тээшинд гараар үзлэг хийхдээ ямар нэг зөвшөөрөгдөөгүй эд зүйл агуулагдаагүй гэдэгт итгэлтэй байх;

(2) НАХ-ын ажилтан нь гар тээшинд ямар нэг зөвшөөрөгдөөгүй эд зүйл агуулагдаагүй гэдэгт итгэлтэй болсноос бусад тохиолдолд, тухайн тээшийг агаарын хөлгөөр тээвэрлэхийг зөвшөөрдөггүй ба агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчид мэдэгдэх;

(3) хэрэв тухайн эд зүйл тэсрэх бодис агуулсныг сэжиглэх шалтгаан байгаа бол НАХ-ын ажилтан нь А.11(b)(5)-д шаардсан журмыг мөрдөх.

(b) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн зорчигч компьютер, видео камер, эсхүл ижил төстэй цахилгаан хэрэгслээ рентген төхөөрөмж, эсхүл бусад шалгах төхөөрөмж, хэрэгслээр шалгуулахаас татгалзсан тохиолдолд НАХ-ын ажилтан нь дараах ажиллагааг гүйцэтгэх хүртэл тухайн эд зүйл, хэрэгсэл болон түүнийг авч яваа этгээдийг үзлэгийн дараах бүсэд нэвтрэхийг зөвшөөрдөггүй болохыг бататгана:

(1) хэрэв боломжтой бол тухайн эд зүйлийг гараар шалгах ба зорчигчоос тухайн төхөөрөмжийг ажиллуулахыг хүсэх;

(2) хэрэв гараар шалгах боломжгүй бол тухайн эд зүйл дараах шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд бүхээгт авч орохыг зөвшөөрч болно:

(i) тухайн эд зүйл хэвийн ажиллаж байгаа бол;

(ii) тухайн эд зүйлийн харагдах байдал нь шинэ, эсхүл шинэвтэр бол;

(iii) хайрцаг савны эрэг боолт гэмтсэн, эсхүл өөрчлөгдсөн шинж тэмдэггүй бол;

(iv) тухайн зорчигчийн төлөв байдалд эргэлзээ төрүүлэх шалтгаан ажиглагдаагүй бол;

(v) тухайн эд зүйл, эсхүл түүний агууламжийн хувьд эргэлзээ төрүүлэх бусад шалтгаан байхгүй бол.

(c) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгах сорилт, эсхүл шалгалт хийнэ:

(1) гараар шалгах үзлэгийг бүрэн гүйцэд хийж байгаа байдлыг 28 хоног тутамд;

(2) А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу гараар шалгах НАХ-ын ажилтнуудын ур чадварыг 150 хоног тутамд.

А.9. Аюулгүйн үзлэг, шалгалт хийж байгаа этгээдэд тавих хяналт

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь НАХ-ын ажилтан дараах шаардлагыг хангадаг болохыг бататгана:

(1) рентген төхөөрөмж, эсхүл бусад шалгах төхөөрөмж, хэрэгслээр ижил төрлийн ажил үүрэг гүйцэтгэж байхдаа:

(i) эргэлзээ төрүүлж байгаа этгээдийн талаар анхааруулах дохио өгдөг байх;

(ii) авч яваа эд зүйлийг дамжлага шугам дээр байрлуулахдаа рентген төхөөрөмжөөр үзлэг шалгалт хийж байгаа НАХ-ын ажилтан үүргээ гүйцэтгэхэд хялбар байхаар байрлуулсныг бататгах;

(2) металл илрүүлэгч төхөөрөмж (эсхүл шалгалтын бусад тоног төхөөрөмж, хэрэгсэл)-өөр ажил үүрэг гүйцэтгэж байхдаа дохио өгсөн эсэхээс үл хамааран, эргэлзээ төрүүлж байгаа бүх этгээдэд аюулгүйн үзлэг, шалгалт хийх.

А.10. Аюулгүйн хамгаалалтын үзлэг, шалгалтын зөрчил

(а) Аюулгүйн үзлэг, шалгалт хийгдсэн зорчигч үзлэгийн дараах бүсэд аюулгүйн үзлэг, шалгалт хийгдээгүй, зөвшөөрөлгүй этгээдтэй харьцсан бол, түүнд үзлэг шалгалт хийсэн НАХ-ын ажилтан дараах шаардлагыг хангадаг болохыг НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч бататгана:

(1) үзлэгийн дараах бүсээс бүх хүмүүсийг гаргах;

(2) үзлэгийн дараах бүсэд зөвшөөрөгдөөгүй эд зүйл үлдээгүй болохыг бататгах зорилгоор давтан үзлэг, шалгалт хийх;

(3) А.5(b)-ийн дагуу, үзлэгийн дараах бүсэд нэвтэрч байгаа бүх этгээдийг аюулгүйн үзлэг, шалгалтад давтан хамруулах.

(b) Үзлэгийн дараах бүсэд, эсхүл агаарын хөлгийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд илэрвэл аюулгүйн үзлэг, шалгалт хийгдсэн болон хийгдээгүй хүмүүс холилдоогүй байсан ч, энэ нь тухайн эрсдэлтэй бүсэд шалгалт хийх хангалттай нөхцөл болно.

А.11. Аюулгүйн үзлэгийн цэгийн онцгой нөхцөлийн арга хэмжээний төлөвлөгөө болон дохио

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь аливаа этгээдийн аюулгүй байдал алдагдсан, эсхүл алдагдсан байж болох нөхцөл үүссэн тохиолдолд, аюулгүйн үзлэгийн цэг бүрд болон хамаарах өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн аюулгүйн үзлэгийн цэг бүрд тухайн нөхцөл байдлыг зохицуулах журмыг тогтооно.

(b) Аюулгүйн үзлэгийн цэгүүдийн хувьд НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь өөрийн журамд дараах шаардлагыг багтаасан байна:

(1) аюулгүйн үзлэгийн цэг тус бүрд хамаарах, тухайн байгууламжийн нүүлгэн шилжүүлэх журам;

(2) онцгой нөхцөл бий болсныг бусад НАХ-ын ажилтанд

анхааруулах тогтолцоо;

(3) НАХ-ын ажилтан аюулгүйн үзлэгийн цэг бүрд дараах нууц дохиоллыг ажиллуулах тогтолцоо:

(i) аюулгүйн хамгаалалтын байгууллагын болон цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

(ii) ИНД-139 Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт (цаашид “ИНД-139” гэх)-ийн ИНД-139.57-д шаардсан аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөний шаардлагын дагуу онцгой нөхцөл бий болсон талаар холбогдох бусад оролцогчдод мэдэгдэх;

(4) дараах тохиолдолд авах арга хэмжээ:

(i) аливаа этгээд аюулгүйн үзлэгийн цэгт зөвшөөрөгдөөгүй эд зүйл авч явсан ба тухайн этгээд нь гэмт хэргийн зорилготой байж болох нөхцөл байдал илэрсэн үед;

(ii) рентген төхөөрөмжийн дэлгэцэд зөвшөөрөгдөөгүй эд зүйл танигдсан үед НАХ-ын ажилтан тухайн зорчигчийг сэжигтэй эд зүйлээс нь тусгаарлах оролдлого хийдэг болохыг бататгах;

(5) сэжигтэй тэсрэх хэрэгсэл илэрсэн үед авах арга хэмжээний журам:

(i) цагдаагийн байгууллага болон аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид мэдэгдэх;

(ii) аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөний дагуу холбогдох бусад байгууллагад мэдэгдэх;

(iii) тухайн бүсийг чөлөөлөхөд туслах;

(iv) тухайн зөрчил гаргагчийг илрүүлэх болон саатуулахад Цагдаагийн байгууллагад туслах.

(с) Энэ зүйлийн (а)-д заасан журамтай өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн аюулгүйн үзлэгийн цэгүүдийн хувьд, хэрэв хамааралтай бол, НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (b)-д заасан эд зүйлийг тухайн журамд оруулах үүрэгтэй.

А.12. Хөдөлгөөнт эргүүл

(а) Энэ зүйлийн (с), эсхүл (d)-д зааснаас бусад тохиолдолд НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь НАХ-ын ажилтан дараах зорилгоор хоногийн 24 цагийн турш хөдөлгөөнт эргүүл хийдэг болохыг бататгана:

(1) НАХҮБ-ын Ерөнхий зааварт заасан байрлалын аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагаанд заналхийлж болох этгээдийг илрүүлэх;

(2) НАХҮБ-ын Ерөнхий зааварт заасан байрлалын аюулгүйн хамгаалалттай холбоотой онцгой нөхцөлд яаралтай хариу арга хэмжээ авах.

(b) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь НАХ-ын ажилтан хөдөлгөөнт эргүүл хийх үедээ дараах шаардлага хангасан болохыг бататгана:

(1) 140.61(a)(5)-д заасан НАХҮБ-ын хариуцлагын бүс дэх

байгууламжийн байрлалын талаар бүрэн мэдлэгтэй гэдгийг;

(2) энэ зүйлийн (b)(1)-д заасан бүсийг бүрэн хамарсныг бататгах;

(3) эргүүлийг дараах байдлаар хийх:

(i) тогтмол бус давтамжтай;

(ii) зөвшөөрөлгүй тээврийн хэрэгсэл болон этгээдийг шалгаж тогтоох;

(iii) аэродромын аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл хориотой бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэлтийг илрүүлэх;

(4) аюулгүйн хамгаалалттай аэродромын хамгаалалттай бүсэд, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн аль нэг хэсэгт аюулгүйн хамгаалалттай холбоотой онцгой нөхцөлийн дуудлага хүлээж аваад 5 минутын дотор тухайн цэгт очдог байх;

(5) аюулгүйн хамгаалалттай бүс болон өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс дэх ачаа болон барааны талбайд эргүүл хийх;

(6) аэродромын аюулгүйн хамгаалалттай бүс болон өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс дэх навигацийн байгууламжид эргүүл хийх;

(7) аэродромын аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийг тойрсон хашаа болон хаалт, аюулгүйн хамгаалалтын периметрийн зөрчлийг илрүүлэх зорилгоор үзлэг хийх;

(8) энэ зүйлийн (b)(7)-д шаардсан үзлэг нь дараах шаардлагыг багтаасныг бататгах:

(i) периметрийн хашааг шөнийн цагаар 3-аас доошгүй, өдрийн цагаар 3-аас доошгүй удаа эргэх;

(ii) байгууламжид өөр өөр цагт эргүүл хийдэг байх;

(iii) аюулгүйн хамгаалалттай бүсийн болон өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн тэмдэг тэмдэглэгээний бүрэн бүтэн байдлыг шалгах;

(iv) шаардсан хүрээг бүрэн хамарсан болохыг бататгах периметрийн үзлэгийн бүртгэл хөтлөх.

(с) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь олон улсын нисэх буудлаас бусад аэродромд аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлдэг бол НАХ-ын ажилтан нь дараах тохиолдолд энэ зүйлийн (b)(8)-ыг дагаж мөрдөхгүйгээр, хоногт 24 цагаас бага хугацаагаар тухайн аэродромд хөдөлгөөнт эргүүл хийж болно, хэрэв:

(1) аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн 24 цагийн аюулгүйн хамгаалалттай бол;

(2) НАХ-ын ажилтан нь хуваарьт нислэг гарах цагаас 90 минутын өмнө болон нислэг гарснаас хойш 15 минутын хугацаанд эргүүл хийдэг бол.

(d) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламжийн үйл ажиллагаа эрхлэгч бөгөөд НАХ-ын ажилтныг дараах зорилгоор эргүүл хийдэг болохыг бататгадаг бол, тухайн байгууламжид 24 цагаас бага хугацаагаар хөдөлгөөнт эргүүл хийж болно:

(1) НАХҮБ-ын гэрчилгээнд заасан навигацийн байгууламжийн үйл ажиллагааны аюулгүйн хамгаалалтад заналхийлж болох этгээдийг илрүүлэх;

(2) НАХҮБ-ын гэрчилгээнд заасан навигацийн байгууламжийн аюулгүйн хамгаалалттай холбоотой онцгой нөхцөлд яаралтай хариу арга хэмжээ авах.

A.13. Шалган нэвтрүүлэх цэгийн аюулгүйн хамгаалалт

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь НАХ-ын ажилтан дараах шаардлага хангасан болохыг бататгана:

(1) шалган нэвтрүүлэх цэгт ажил үүрэг гүйцэтгэж байхдаа:

(i) зөвхөн хүчинтэй нэвтрэх үнэмлэх, эсхүл баримт бичигтэй этгээдийг шалган нэвтрүүлэх цэгээр нэвтрэхийг зөвшөөрөх;

(ii) шалган нэвтрүүлэх цэгийг хяналтгүй орхисон аль ч үед тухайн цэгийн аюулгүйн хамгаалалт хангагдсан болохыг бататгах;

(2) тээврийн хэрэгслийн шалган нэвтрүүлэх цэгт үүрэг гүйцэтгэж байхдаа тухайн цэгээр зөвхөн зөвшөөрөгдсөн этгээд болон тээврийн хэрэгсэл нэвтрэхийг зөвшөөрөх.

A.14. Аюулгүйн хамгаалалтын гэнэтийн сонгох үзлэг, шалгалт

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь НАХ-ын ажилтан дараах аюулгүйн хамгаалалтын гэнэтийн сонгох үзлэг хийдэг болохыг бататгана:

(1) аюулгүйн хамгаалалттай бүсэд, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд байгаа, эсхүл нэвтрэх гэж байгаа этгээдээс сонгож хүчинтэй нэвтрэх үнэмлэх, эсхүл баримт бичигтэй эсэхийг шалгах;

(2) тээврийн хэрэгсэл нь аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд байх зөвшөөрөлтэй эсэхийг шалгах.

A.15. Нэвтрэх үнэмлэх болон зөвшөөрлийг шалгаж бататгах

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь НАХ-ын ажилтан дараах шаардлага хангадаг болохыг бататгана:

(1) нэвтрэх зорилгоор ашигладаг нэвтрэх үнэмлэх, нисгэгчийн үнэмлэх болон нэвтрэх үнэмлэхийг шалгаж бататгах;

(2) хэрэв энэ зүйлийн (1)-д заасан баримт бичгийн хүчинтэй байдалд эргэлзэж байгаа бол тухайн үнэмлэхийг гээгдүүлсэн, хулгайлагдсан, эсхүл бусад байдлаар хүчингүй болсон эсэхийг шалгаж

ТОГТООХ.

А.16. Аюулгүйн хамгаалалтын дагалдах үйлчилгээ

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь аливаа этгээд, эсхүл тээврийн хэрэгслийг НАХ-ын ажилтан дагалдах шаардлагатай нөхцөл байдлыг тогтоох журамтай байна.

(б) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь НАХ-ын ажилтан бүр аюулгүйн хамгаалалтын дагалдах ажиллагаа гүйцэтгэж эхлэхийн өмнө дагаж байгаа этгээдэд дараах зааварчилгаа өгдөг болохыг бататгана:

(1) хэрэв тухайн этгээд нь тээврийн хэрэгсэлтэй дагаж байгаа бол дагуулж байгаа тээврийн хэрэгслийн араас ойрхон дагах;

(2) дагуулж байгаа ажилтны өгч байгаа бүх зааварчилгааг мөрдөх.

(с) Хэрэв дагаж байгаа этгээд нь аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд үлдэх бол тухайн этгээдийг үлдээхийн өмнө ажилтан дараах зааварчилгааг өгнө:

(1) аюулгүйн хамгаалалтын дагалдах ажилтны тогтоосон бүсийг, дагуулж байгаа ажилтангүйгээр орхихгүй байх талаар;

(2) тухайн бүсээс гарахад аюулгүйн хамгаалалтын дагалдах ажилтан шаардлагатай бол НАХҮБ-тай хэрхэн холбоо барих талаар.

А.17. Явган эргүүл

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлага хангасан болохыг бататгана:

(1) НАХ-ын ажилтан нь иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтад заналхийлэл учруулж болох этгээдийг илрүүлэх явган эргүүл хийх;

(2) явган эргүүл хийх НАХ-ын ажилтан нь:

(i) хариуцсан бүс дэх байгууламжийн байрлалын талаар бүрэн мэдлэгтэй байх;

(ii) хариуцсан бүсийг бүрэн хамарсан эргүүл хийх;

(iii) мэдээлсэн, эсхүл тогтоосон аюулгүйн хамгаалалттай холбоотой зөрчилд нэн даруй хариу арга хэмжээ авдаг байх.

А.18. Агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалт

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана:

(1) тухайн байгууллагын аэродромд байрлаж байгаа НАХ-ын ажилтан нь:

(i) үйлчилгээнд байгаа бүх агаарын хөлгийг байнгын ерөнхий хяналтдаа байлгах;

(ii) зөвшөөрөлгүй этгээд агаарын хөлөгт ойртох, эсхүл агаарын хөлгийн бүхээгт нэвтрэхээс сэргийлэх;

(iii) хүн, эсхүл зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг нуусан байж болзошгүй байрлалд анхаарал хандуулах зорилгоор олон улсын

чиглэлийн үйлчилгээнд байгаа агаарын хөлгийг тойрч, нүдэн үзлэг хийх;

(2) энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд НАХ-ын ажилтан нь олон улсын чиглэлийн үйлчилгээнд байгаа бүх агаарын хөлгийн эргүүлийг дараах байдлаар хийх:

(i) тогтмол бус давтамжтай;

(ii) шөнийн цагаар, хоёр цаг тутамд хамгийн багадаа нэг удаа;

(iii) өдрийн цагаар, дөрвөн цаг тутамд хамгийн багадаа нэг удаа;

(3) НАХ-ын ажилтан нь дараах нөхцөлд агаарын тээвэрлэгчийн төлөөлөгчийг агаарын хөлөгт ирэхийг шаардах:

(i) хоолойд (air-bridge) холбогдсон, хяналтгүй орхисон агаарын хөлөг нь хамгаалалтгүй бол;

(ii) тухайн агаарын хөлөг хөндлөнгийн халдлагад өртсөн байж болох шалтгаан байгаа бол.

(b) Тухайн НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь олон улсын нисэх буудлаас бусад аэродромд аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлдэг бол НАХ-ын ажилтан нь дараах тохиолдолд тухайн аэродром дээр олон улсын чиглэлийн үйлчилгээнд байгаа агаарын хөлөгт энэ зүйлийн (a)(2)-т шаардсанаас бага хугацаагаар эргүүл хийж болно, хэрэв:

(1) тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн 24 цагийн аюулгүйн хамгаалалттай бол;

(2) НАХ-ын ажилтан нь хуваарьт нислэг гарах цагаас 90 минутын өмнө болон нислэг гарснаас хойш 15 минутын хугацаанд эргүүл хийдэг бол.

А.19. Эргүүлийн тээврийн хэрэгсэл

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд эргүүл хийхэд ашигладаг тээврийн хэрэгсэл нь дараах шаардлага хангасан болохыг бататгана:

(1) аэродромын бусад хэрэглэгчдэд танигдахуйц таних тэмдэгтэй байх;

(2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц стандартын дагуу тоноглогдсон байх.

А.20. Нууцлал болон мэдээлэл

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь нууцлалыг ангилсан баримт бичгийг дараах шаардлага хангасан болохыг бататгана:

(1) нууцлалын ангиллаас нь хамааран сейфт, эсхүл түгжээтэй шүүгээнд хадгалдаг байх;

(2) зөвхөн “мэдэж байх шаардлага”-д үндэслэн, тэдгээрийг хүлээн авахаар зөвшөөрөгдсөн хувь хүн, эсхүл байгууллагад түгээх.

A.21. Бусад байгууллагатай харилцах

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь 140.61(а)(5)-д заасан байрлал бүрийн хувьд:

(1) тухайн байрлал дахь үйл ажиллагааны аюулгүйн хамгаалалтад нөлөөлөх, нөөц төлөвлөгөөнд оролцох бусад бүх байгууллагатай зөвлөлдөх болон хамтарч ажиллана;

(2) тухайн байрлалд байгаа бусад байгууллагын бүх ажилтны аюулгүйн хамгаалалтын мэдлэг чадварыг дээшлүүлэх хангалттай мэдээлэл өгөгдөж байгааг бататгах аюулгүйн хамгаалалтын хороо байгуулна.

(b) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (а)(2)-ын дагуу байгуулагдсан аюулгүйн хамгаалалтын хороог 12 сард нэгээс доошгүй удаа хуралдуулж, хурлыг удирдах болон аюулгүйн хамгаалалтын хорооны уулзалтын тэмдэглэл хөтөлнө.

A.22. НАХ-ын ажилтны эрүүл мэндийн шаардлага

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь эмнэлгийн үзлэгийн дүгнэлтэд үндэслэн тухайн этгээд ажил үүрэг гүйцэтгэхэд тохирч байгаа гэсэн үнэлгээг хийх хүртэл аливаа этгээдийг НАХ-ын ажилтны албан тушаалд томилдоггүй болохыг бататгана.

A.23. Сургалт

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь түүний НАХ-ын ажилтан дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд тухайн ажил үүрэг гүйцэтгэдэггүй болохыг бататгана:

(1) тэдний гүйцэтгэх үүрэгт хамаарах, энэ зүйлийн (с)-д заасан сэдвээр сургалтад хамрагдсан байх;

(2) сургалтын төгсгөлд шалгалт өгсөн байх;

(3) хамрагдсан сургалтын сэдэв тус бүрээр, энэ зүйлийн (с)-д заасан ур чадварын түвшнийг хангасан байх.

(b) Энэ зүйлийн (с)-д заасан ур чадварын түвшний үнэлгээний тогтолцоо нь дараах хэлбэртэй байна:

(1) Үнэлгээ 1 - тухайн сэдвийн ойлголтыг харуулна;

(2) Үнэлгээ 2 - тухайн сэдвийн суурь мэдлэгийг харуулна;

(3) Үнэлгээ 3 - тэдний ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй нөхцөл байдалд тухайн сэдвийн суурь мэдлэгээ ашиглах чадварыг харуулна;

(4) Үнэлгээ 4 - тэдний ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй нөхцөл байдалд тухайн сэдвийн бүрэн мэдлэгээ ашиглаж шийдвэр гаргах чадварыг харуулна;

(5) Үнэлгээ 5 - тэдний ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй нөхцөлд тухайн сэдвийн бүрэн мэдлэгээ ашиглан нөхцөл байдлыг зөв тодорхойлж илэрхийлэх чадварыг харуулна.

(с) Энэ зүйлийн (а)-д заасан ажилтан нь дараах сэдвээр ур чадварын түвшин тогтоох сургалтад хамрагдаж, үнэлгээ хийлгэсэн байна:

(1) Нисэхийн аюулгүйн хамгаалалттай холбогдолтой хууль тогтоомж:

(i) Эрүүгийн хуульд заасан, хөндлөнгийн хууль бус үйлдэлтэй холбоотой гэмт хэргийн талаар - Үнэлгээ 4;

(ii) Хүний эрхийн холбогдолтой хууль тогтоомж болон хувь хүнд нэгжлэг хийх, эсхүл баривчлан саатуулах талаар (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл) - Үнэлгээ 3;

(iii) Иргэний нисэхийн тухай хуульд заасан НАХ-ын ажилтны эрх, үүрэг болон хариуцлагын талаар - Үнэлгээ 5;

(iv) ИНД-139-ийн 139.205 болон 139.207-ийн талаар - Үнэлгээ 3;

(v) ИНД-13 Иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх (цаашид "ИНД-13" гэх) болон Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтын талаар - Үнэлгээ 3;

(vi) Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн талаар (Эрүүгийн хуулийн холбогдох зүйл) - Үнэлгээ 3;

(vii) Хүч хэрэглэх болон баривчлах талаар (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалт) - Үнэлгээ 5;

(2) Хүн, тээшинд аюулгүйн үзлэг, шалгалт хийх:

(i) хүн, тээшинд аюулгүйн үзлэг болон шалгалт хийх зохицуулалтын ерөнхий зарчмыг дүрслэх - Үнэлгээ 4;

(ii) НАХҮБ-ын ашигладаг аюулгүйн үзлэгийн төхөөрөмжийн мэдлэгтэй ба ашиглахад мэргэшсэн байх - Үнэлгээ 4;

(iii) хүн, түүний тээшинд аюулгүйн үзлэг, шалгалт хийх журам болон аргыг хэрэглэх дадлага туршлагатай байх - Үнэлгээ 4;

(3) Агаарын хөлгийн хорлон сүйтгэх ажиллагааны эсрэг шалгалт: заналхийллийн дараа агаарын хөлөгт хорлон сүйтгэх ажиллагааны эсрэг шалгалт хийх шаардлагатай үед хариу үйлдлийг шалгах, эсхүл хэрэв тухайн агаарын хөлөг өмнө нь аюулгүйн үзлэг, шалгалт хийлгэлгүй үйлчилгээнд оролцсон бол түүнийг дараагийн нислэгийн өмнөх аюулгүйн үзлэг, шалгалтын өмнө аюулгүй болохыг бататгахаар авах арга хэмжээ - Үнэлгээ 4;

(4) Гар хийцийн тэсрэх төхөөрөмж: НАХ-ын ажилтанд нисэх буудал, агаарын хөлөг, эсхүл зорчигчийн аюулгүйн үзлэгийн цэгт илэрч болох, иргэний нисэхийн үйл ажиллагаанд нөлөөлдөг гар хийцийн тэсрэх төхөөрөмжийн талаар ойлголт өгөх - Үнэлгээ 3;

(5) Зэвсэглэсэн гэмт хэрэгтэнтэй харьцах: НАХ-ын ажилтанд

зэвсэглэсэн гэмт хэрэгтнийг саатуулах болон бусад этгээдийг тухайн заналхийллээс хамгаалах арга хэмжээний талаар зааварчилгаа өгөх - Үнэлгээ 3;

(6) Агаарын хөлөг барьцаалахын эсрэг хариу үйлдлийн журам: НАХ-ын ажилтанд онгоц булаах үед мөрдөх журмын талаар ойлголт өгөх - Үнэлгээ 2;

(7) Аюулгүйн хамгаалалтын явган болон хөдөлгөөнт эргүүл: НАХ-ын ажилтанд урьдчилан сэргийлэх явган болон хөдөлгөөнт эргүүл, аюулгүйн хамгаалалтын зөрчлийн хариу үйлдлийн талаарх бүх талын мэдлэгийг олгох - Үнэлгээ 4;

(8) Аэродром дээрх хөдөлгөөн: НАХ-ын ажилтанд тухайн аэродром дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нарийвчилсан журмыг заах - Үнэлгээ 5;

(9) Нисэхийн радио-холбооны үйл ажиллагаа болон журам: НАХ-ын ажилтанд хязгаарлагдмал радио-холбооны операторын гэрчилгээний стандартын дагуу зөв радио-холбооны сахилга батын талаар заах - Үнэлгээ 4;

(10) Заналхийллийн хүчин зүйл: НАХ-ын ажилтанд алан хядах ажиллагаа болон гэмт хэргийн өнөөгийн хандлагын талаар шинэчилсэн мэдээлэл өгөх - Үнэлгээ 2;

(11) Зэвсэг: НАХ-ын ажилтанд нислэгийн өмнөх аюулгүйн үзлэг, шалгалтын үеэр олон төрлийн галт зэвсэг болон түүнтэй төстэй зэвсгийг таньж тогтооход нь туслах зорилгоор мэдлэг олгох - Үнэлгээ 3;

(12) Хууль бус үйлдлийн түүхэн баримт болон статистик: НАХ-ын ажилтанд нисэхийн аюулгүйн хамгаалалтын түүхэн хөгжил болон хэрэг явдлын тархцын талаар мэдлэг олгох - Үнэлгээ 2;

(13) Олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагын талаарх баримт мэдээлэл: НАХ-ын ажилтанд Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын Хавсралт 17 болон түүнд нийцүүлэн Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан баримт бичиг (Doc 8973)-ийг танилцуулах - Үнэлгээ 1.

А.24. Давтан сорилт хийх

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь НАХ-ын ажилтанд урьдчилан мэдэгдэлгүйгээр, стандарт сорилын биет ашиглан сорилт хийдэг болохыг бататгана.

(б) Сорилтыг аюулгүйн үзлэг, шалгалтын үйл ажиллагааны бүрэн гүйцэд байдалд үнэлгээ өгөх зорилгоор хийх ба тухайн сорилтод орж байгаа НАХ-ын ажилтанд стандарт сорилын биетийг илрүүлэх боломжийг олгох хэлбэрээр зохион байгуулна.

(с) Даргын хүлээн зөвшөөрөхүйц байхаас бусад тохиолдолд тухайн стандарт сорилын биетийг давтан сорилтод ашиглахыг зөвшөөрөхгүй.

(d) Стандарт сорилын биет нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг төлөөлдөг байх;

(2) үйл ажиллагааны бодит нөхцөлд ашиглагддаг байх.

(e) Сорилтод орж байгаа, эсхүл давтан сорилтод орж байгаа НАХ-ын ажилтны ур чадварыг тодорхойлохдоо дараах хэмжүүрийг ашиглана:

(1) хэрэв сорилтын явцад стандарт сорилын биет бүрийг илрүүлсэн бол сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан тухайн шаардсан стандартыг хангаж байна гэж үзнэ;

(2) хэрэв энэ зүйлийн (f) - (k)-ийн дагуу хийгдэж байгаа сорилтын явцад стандарт сорилын биетийг илрүүлээгүй бол сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан тухайн шаардсан стандартыг хангаагүй гэж үзэн дараах арга хэмжээг авна:

(i) давтан сорилтод хамруулах;

(ii) давтан сорилтыг амжилттай өгөх хүртэл тухайн ажил үүргээс нь чөлөөлөх;

(3) хэрэв давтан сорилтоор стандарт сорилын биетийг илрүүлээгүй бол:

(i) сорилт хийж байгаа шалгагч нь аюулгүйн хамгаалалтын удирдах ажилтанд мэдэгдэнэ;

(ii) аюулгүйн хамгаалалтын удирдах ажилтан нь тухайн алдааны бүртгэлийг хөтөлнө;

(iii) аюулгүйн хамгаалалтын удирдах ажилтан нь сорилтод тэнцээгүй НАХ-ын ажилтан бүрийг залруулах давтан сургалтад хамруулах ба дахин ажил үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрөхийн өмнө ажилтныг тухайн даалгаврын стандартыг хангаж чадахыг харуулах сорилтод хамруулна.

(f) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь металл илрүүлэгчийн сорилт хийгдэж байх үед дараах шаардлагыг бататгана:

(1) сорилт хийж байгаа шалгагч нь стандарт сорилын биетийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр сорилын тээгчид нуух;

(2) тухайн сорилын тээгчийг дараах байдлаар нэвтрүүлэх:

(i) хэрэв илрүүлэгч нь металл илрүүлэгч хаалга бол ердийн алхах хурдаар зорчигчийн урсгалын чиглэлд металл илрүүлэгч хаалгаар; эсхүл

(ii) тээврийн хэрэгсэлд суусан, эсхүл ачигдсан байдлаар;

(3) металл илрүүлэгч хаалганы дохиолол ажилласан бол тухайн сорилт хийж байгаа шалгагч нь сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан гар металл илрүүлэгч ашиглан, эсхүл биед нь шалгалт хийн стандарт сорилын биетийг таньж илрүүлж байгаа эсэхийг тогтоох;

(4) гар металл илрүүлэгчийн дохиолол ажилласан үед тухайн

сорилт хийж байгаа шалгагч нь сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан стандарт сорилын биетийг таньж илрүүлж байгаа эсэхийг тогтоох;

(5) хэрэв стандарт сорилын биет ойртоход металл илрүүлэгч хаалганы, эсхүл гар металл илрүүлэгч эсхүл бусад төхөөрөмж, хэрэгслийн дохиолол ажиллаагүй бол:

(i) тухайн төхөөрөмжид алдаа байгаа талаар сорилт хийж байгаа шалгагч аюулгүйн хамгаалалтын удирдах ажилтанд мэдэгдэх;

(ii) үйл ажиллагааны стандартыг хангах хүртэл тухайн металл илрүүлэгчийг үйлчилгээнээс гаргах.

(g) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь рентген төхөөрөмж эсхүл бусад төхөөрөмжид сорилт хийгдэж байгаа үед сорилт хийж байгаа шалгагч дараах шаардлагыг хангадаг болохыг бататгана:

(1) тухайн стандарт сорилын биетийг аюулгүйн үзлэг, шалгалт хийгдэж байгаа цүнх саванд бусад эд зүйлийн хамт байрлуулах;

(2) сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан стандарт сорилын биетийг рентген төхөөрөмжийн дэлгэцэн дээр таньж, гар шалгалтаар стандарт сорилын биетийг илрүүлж чадаж байгаа эсэхийг тогтоох;

(3) тухайн агууламж нь рентген төхөөрөмжийн дэлгэц дээр зөв танигдахгүй байгаа үед НАХ-ын ажилтан нь гар шалгалт хийх хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлох шийдвэр гаргах чадварт үнэлгээ хийх.

(h) Гараар шалгах сорилт хийгдэж байгаа үед НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь сорилт хийж байгаа шалгагч дараах шаардлагыг хангадаг болохыг бататгана:

(1) тухайн стандарт сорилын биетийг аюулгүйн үзлэг, шалгалт хийгдэж байгаа цүнх саванд бусад эд зүйлийн дунд нуух;

(2) сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан стандарт сорилын биетийг илрүүлсэн эсэхийг тогтоох.

(i) Үзлэгийн дараах бүсэд сорилт хийгдэж байгаа үед гэрчилгээ эзэмшигч нь, сорилт хийж байгаа шалгагч дараах шаардлага хангадаг болохыг бататгана:

(1) үзлэгийн дараах бүсийг шалгахын өмнө стандарт сорилын биетийг тухайн бүсэд нуух;

(2) сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан тухайн стандарт сорилын биетийг илрүүлсэн эсэхийг тогтоох.

(j) Агаарын хөлгийг шалгах сорилт хийгдэж байгаа үед НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь сорилт хийж байгаа шалгагч дараах шаардлага хангадаг болохыг бататгана:

(1) зорчигч ердийн үед нэвтэрч болох тухайн агаарын хөлгийн аливаа хэсэгт стандарт сорилын биет нуух;

(2) сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан тухайн стандарт сорилын биетийг илрүүлсэн эсэхийг тогтоох.

(к) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тээврийн хэрэгслийн шалгалтын сорилт хийгдэж байгаа бол тухайн шалгагч дараах шаардлага хангасан болохыг бататгана:

(1) тээврийн хэрэгслийн аливаа хэсэгт стандарт сорилын биетийг нуух;

(2) сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан тухайн стандарт сорилын биетийг илрүүлсэн эсэхийг тогтоох.

А.25. Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс

Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн үзлэгийн цэг болон төхөөрөмж

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан болохыг бататгана:

(1) өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс рүү нэвтэрч байгаа, эсхүл тухайн бүсэд байгаа хүмүүс, эд зүйл, бодис болон тээврийн хэрэгсэлд Даргын баталсан тусгай арга хэлбэр, эсхүл аргачлалын дагуу аюулгүйн үзлэг, эсхүл шалгалт хийх;

(2) өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс рүү нэвтэрч байгаа, эсхүл тухайн бүсэд байгаа хүмүүс, тэдэнтэй холбоотой эд зүйл, бодис болон тээврийн хэрэгслийг оролцуулан аюулгүйн үзлэг, шалгалтыг Сайдын, эсхүл Даргын шаардсаны дагуу хийх;

(3) Даргын баталсан тусгай арга хэлбэр, эсхүл аргачлалын дагуу аюулгүйн үзлэг шалгалтыг хийх хангалттай тооны ажилтан болон төхөөрөмжтэй байх;

(4) НАХ-ын ажилтан нь аюулгүйн үзлэг, шалгалтын төхөөрөмжийг шалгах ур чадвартай гэдгийг бататгах зорилгоор стандарт сорилын биетийг ашиглах зааварчилгаа авдаг байх;

(5) өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн аюулгүйн үзлэгийн цэгт ашиглаж байгаа аюулгүйн үзлэгийн аппаратад Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр сорилт хийх.

Хүмүүс, эд зүйл, бодис болон тээврийн хэрэгсэлд аюулгүйн үзлэг, шалгалт хийх

(b) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь аюулгүйн үзлэг, шалгалт хийхдээ дараах шаардлагыг хангасан байна:

(1) аюулгүйн үзлэг, шалгалт хийгдэж байгаа цэг бүрд, аливаа этгээд өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэхээс өмнө аюулгүйн үзлэг, шалгалтаар заавал орохыг анхааруулсан дараах мэдээллийг байрлуулах:

(i) аливаа этгээд, эсхүл эд зүйл, бодис, эсхүл тухайн этгээдийн хяналтад байгаа тээврийн хэрэгсэлд аюулгүйн үзлэг, шалгалтыг зөвхөн тухайн этгээдийн зөвшөөрөлтэйгөөр хийх;

(ii) аюулгүйн үзлэг, шалгалт хийлгэхээс татгалзсан этгээдийг

тухайн цэгээр нэвтрүүлдэггүй байх;

(2) хэрэв аюулгүйн үзлэгийг өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд хийж байгаа бол аюулгүйн үзлэг, шалгалт хийгдэх этгээдэд дараах шаардлагыг мэдэгдэх:

(i) аливаа этгээд, эсхүл эд зүйл, бодис, эсхүл тухайн этгээдийн хяналтад байгаа тээврийн хэрэгсэлд аюулгүйн үзлэг, шалгалтыг зөвхөн тухайн этгээдийн зөвшөөрөлтэй хийх;

(ii) аюулгүйн үзлэг, шалгалтыг хийлгэхээс татгалзсан этгээдийг тухайн өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийг орхин гарахыг шаардах;

(3) Даргын баталсан тусгай арга хэлбэр, эсхүл аргачлалын дагуу дараах бүртгэл хөтөлдөг болохыг бататгах:

(i) тухайн аюулгүйн үзлэг, шалгалтын арга;

(ii) Сайдын, эсхүл Даргын шаардсан аюулгүйн үзлэг, шалгалтын үргэлжлэх хугацаа;

(iii) аюулгүйн үзлэг, шалгалтад хамрагдсан хүмүүс, эд зүйл, бодис болон тээврийн хэрэгслийн тоо;

(4) хэрэв зөвшөөрөгдөөгүй эд зүйл илэрсэн бол дараах бүртгэл хөтөлдөг болохыг бататгах:

(i) аюулгүйн үзлэг, шалгалт хийсэн ажилтны нэр;

(ii) илэрсэн зөвшөөрөгдөөгүй эд зүйл;

(iii) зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг аюулгүй болгох арга хэмжээ.

(с) Аюулгүйн үзлэг, шалгалтын явцад НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь:

(1) НАХ-ын ажилтан нь аливаа этгээд, эд зүйл, бодис, эсхүл тээврийн хэрэгсэлд аюулгүйн үзлэг, шалгалт хийхдээ, тухайн этгээд зөвшөөрөгдөөгүй эд зүйл тээвэрлээгүй, эсхүл биедээ авч яваагүй болохыг бататгана;

(2) НАХ-ын ажилтан, зөвшөөрөгдөөгүй эд зүйл биедээ авч явсан нь илэрсэн этгээдийг өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэхийг зөвшөөрдөггүй болохыг бататгана;

(3) НАХ-ын ажилтан, зөвшөөрөгдөөгүй эд зүйл биедээ авч явсан нь илэрсэн этгээдийг өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийг орхихыг шаарддаг болохыг бататгана;

(4) дараах шаардлагыг бататгах зорилгоор, сорилт, эсхүл шалгалтын үр дүнгийн бүртгэл хөтөлнө:

(i) аюулгүйн үзлэг, шалгалтын үнэн зөв байдлыг бататгах зорилгоор 28 хоног тутамд шалгах;

(ii) аюулгүйн үзлэг гүйцэтгэж байгаа НАХ-ын ажилтнуудын ур чадварыг Хавсралт А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу 150 хоног тутамд шалгах.

Эд зүйл, эсхүл бодисыг гараар шалгах

(d) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч эд зүйл, эсхүл бодист тэсрэх хэрэгсэл агуулагдсан гэж сэжиглэх шалтгаан байгаа бол, эсхүл сэжигтэй тэсрэх хэрэгсэл илэрсэн бол түүний НАХ-ын ажилтан нь Хавсралт А.11(b)(5)-д шаардсан журмыг мөрддөг болохыг бататгана.

(e) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгах зорилгоор, сорилт, эсхүл шалгалт хийж, тэдгээрийн үр дүнгийн бүртгэл хөтөлнө:

(1) гараар шалгах үнэн зөв байдлыг 28 хоног тутамд хийх;

(2) гараар шалгаж байгаа НАХ-ын ажилтнуудын ур чадварыг Хавсралт А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу 150 хоног тутамд авдаг байх.

A.26. [хүчингүй болсон]

A.27. [хүчингүй болсон]

A.28. [хүчингүй болсон]

Захиргааны хэм хэмжээний актын улсын нээгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 7387 дугаарт бүртгэв.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар А/255

Улаанбаатар
хот

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хувь хүнд мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ олгох үйл ажиллагааг зохицуулах Иргэний нисэхийн дүрэм болох “ИНД-61 Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл”-ийг нэгдүгээр хавсралтаар, “ИНД-63 Нисэх инженер болон нислэгийн диспатчерийн үнэмлэх, зэрэглэл”-ийг хоёрдугаар хавсралтаар, “ИНД-65 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл”-ийг гуравдугаар хавсралтаар, “ИНД-66 Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл”-ийг дөрөвдүгээр хавсралтаар, “ИНД-67 Эрүүл мэндийн гэрчилгээ болон стандарт”-ыг тавдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Иргэний нисэхийн дүрмийг мөрдөж, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн шаардлагатай тохиолдолд боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр)-т, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газар (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Багц дүрэм батлах тухай” 187 дугаар тушаалын 10 дугаар хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-10 “Агаарын хөлөгтэй харилцах холбоо, дохиог ашиглах”-ын “ИНД-65 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл” дүрэм, 12 дугаар хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-12 “Иргэний нисэхийн холбогдолтой бүх төрлийн гэрчилгээ, үнэмлэх болон бусад баримт бичгийн загварыг тодорхойлох, тэдгээрийг олгох, үйлчлэлийг нь түр зогсоох, хураах, хадгалах”, 13 дугаар хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-13 “Нислэг, түүний үйл ажиллагаанд оролцогч ажилтнуудын ажлын цагийг хуваарилах”-ын “ИНД-61 Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл” дүрмийг тус тус бүхэлд нь,

2022 оны “Иргэний нисэхийн багц дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/311 дүгээр тушаалын 2, 3 дугаар хавсралт, 2023 оны “Иргэний нисэхийн багц дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/273 дугаар тушаалын 7, 12 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Энэ тушаалын хавсралтыг доорх линкээр үзнэ үү.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17433706889852>

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 7388 дугаарт бүртгэв.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 9 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар А/186

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд “Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах босго оноог 180 ба түүнээс доош оноотой байгаа өрхийн гишүүн-иргэнд, сард олгох дэмжлэгийн хэмжээг нэг хүүхдэд 12000 (арван хоёр мянган) төгрөгөөр, насанд хүрсэн нэг гишүүнд 20000 (хорин мянган) төгрөгөөр тус тус тогтоосугай.

3.Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг улсын хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /З.Бауыржан/-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн халамжийн бодлогын газар /Ю.Отгонбилэг/-т, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Д.Ренчиндорж/-т тус тус даалгасугай.

5.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн А/103 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

6.Энэ тушаалыг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД

Т.АУБАКИР

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн А/186 дугаар тушаалын хавсралт

ХҮНС ТЭЖЭЭЛИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн халамжийн тухай хуулийн 22.1-д заасан хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнийг /цаашид “өрхийн гишүүн-иргэн” гэх/ хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд /цаашид “үйлчилгээ” гэх/ хамруулах, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Дараах өрхийн гишүүн-иргэн үйлчилгээнд хамрагдана:

1.2.1.нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнээс амьжиргааны түвшингийн үнэлгээ нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан хүнс тэжээлийн дэмжлэг олгох босго оноотой тэнцүү буюу түүнээс доогуур байгаа;

1.2.2.хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай Нийгмийн халамжийн тухай хуулийн 22.1.2-т заасан иргэн;

1.2.3.Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхөөс хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай, тэжээн тэтгэх хүүхэдгүй эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжгүй ганц бие харж хандах хүнгүй ахмад настан;

1.2.4.Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн-иргэний дотроос хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай бөгөөд аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн дэргэдэх эмнэлэг хяналтын комиссын шийдвэрээр хүүхэд нь хоол тэжээлийн дутмагшлын улмаас хүнд хэлбэрийн тураалтайг тодорхойлсон хүүхэд.

1.3.Энэ журмын 1.2.1-д заасан өрхийн гишүүнээс хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай боловч хөдөлмөр эрхлээгүй гишүүнээс бусад гишүүнд үйлчилгээг хүн тус бүрээр тооцон олгоно.

Хоёр.Үйлчилгээнд хамрагдах иргэний хүсэлтийг хянан шийдвэрлэх

2.1.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага өрхийн мэдээллийн нэгдсэн сангаас амьжиргааны түвшингийн үнэлгээ нь энэ журмын 1.2.1-д заасан нөхцөл хангасан өрхийн гишүүн-иргэний жагсаалтыг аймаг, дүүрэг, сум, хороо тус бүрээр гаргаж, цахим хэлбэрээр аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.

2.2.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ журмын 2.1-д заасан тухайн сум, хорооны өрхийн

гишүүн-иргэний жагсаалтыг гаргаж, сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.3.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь жагсаалтад орсон өрхийн гишүүн-иргэнд үйлчилгээнд хамрагдах тухай мэдэгдлийг жагсаалт хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хүргүүлнэ.

2.4.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн мэдэгдэл авсан өрхийн гишүүн-иргэнтэй холбогдож дараах баримт бичгийг цахимаар бүрдүүлнэ:

2.4.1.өрхийн гишүүн-иргэн бүрийн иргэний цахим үнэмлэх, хэрэв 16 насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээ;

2.4.2.өрхийн гишүүн-иргэний хаяг, ам бүлийн талаарх баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;

2.5.Үйлчилгээнд хамрагдах тухай өргөдөлд өрхийн гишүүн-иргэнийг төлөөлөн үйлчилгээнд хамрагдах насанд хүрсэн нэг гишүүнийг тодорхойлсон байна.

2.6.Энэ журмын 1.2.2, 1.2.3, 1.2.4-т заасан нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн нь үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд гаргана.

2.7.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь 2.6-д заасан өрхийн гишүүн-иргэний хүсэлтэд үндэслэн, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн авч сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

2.8.Үйлчилгээнд хамрагдахад иргэний үнэмлэх эсхүл төрсний гэрчилгээнээс гадна энэ журмын 1.2.2-т заасан иргэний тухайд гэр оронгүй тэнэмэл амьдралтайг судлан тогтоосон сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний нөхцөл байдлын үнэлгээ, 1.2.3-т заасан ахмад настны тухайд үр, хүүхэд эсхүл төрөл садангийн лавлагаа, сум хорооны Засаг даргын тодорхойлолт, 1.2.4-т заасан хүүхдийг тодорхойлсон аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн дэргэдэх эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг тус тус үндэслэнэ.

2.9.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь үйлчилгээнд хамрагдах нөхцөл хангасан өрхийн гишүүн-иргэнд цахим хувийн хэрэг нээж, үйлчилгээгээр олгох 10 нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчлүүлэх банк болон худалдан авалт хийхтэй холбоотой нэмэлт мэдээллийг өгнө.

2.10.Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй албан тушаалтан болон Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн тус

үйлчилгээнд хамрагдахыг хориглоно. Хэрэв Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн нь тус үйлчилгээнд хамрагдах нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гишүүнээс татгалзана.

2.11.Эрүүл мэндийн байгууллага, ажилтан нь үйлчилгээнд хамрагдах сүрьеэ өвчтэй хүний жагсаалтыг сум, хорооны нийгмийн ажилтан болон аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагад тухай бүр шинэчлэн хүргүүлнэ.

**Гурав.Үйлчилгээнд хамрагдаж байгаа өрх иргэнд тавигдах
нөхцөл, шаардлага**

3.1.Энэ журмын 1.2.1-д заасан өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүн нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах нөхцөлтэйгөөр тухайн өрхийн бусад гишүүд үйлчилгээнд хамрагдана.

3.2.Энэ журмын 3.1-д заасан өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүн нь ажил, хөдөлмөр эрхлээгүй тохиолдолд үйлчилгээнд хамрагдах эхний 6 сарын хугацаанд дараах болзлыг хангана:

3.2.1.ажил хайж аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн;

3.2.2.ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд хамрагдаж, зөвлөгөө авсан.

3.3.Энэ журмын 3.2-т заасан иргэн үйлчилгээнд хамрагдсан эхний 6 сараас хойш хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаас санал болгосон дараах арга хэмжээнээс 2-оос доошгүй үйл ажиллагаанд хамрагдсан тохиолдолд үйлчилгээг үргэлжлүүлэн олгоно.

3.3.1.хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан байх;

3.3.2.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд бий болсон түр ажлын байр болон тухайн орон нутгийн Засаг даргын захирамжаар жилдээ 2 удаа нийтийг хамарсан ажилд хамрагдсан байх;

3.3.3.аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнээс зохион байгуулсан сургалт болон бусад үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон байх.

3.4.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн энэ журмын 3.2, 3.3-т заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах бүх талын зөвлөгөө, дэмжлэг туслалцааг иргэнд үзүүлнэ.

3.5.Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан нь энэ журмын 3.2, 3.3-т заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хүнс тэжээлийн дэмжлэг

үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан иргэнийг тэргүүн ээлжид хамруулах чиглэлийг баримтална.

3.6.Энэ журмын 3.2, 3.3-т заасан нөхцөлийг хангасан эсэхэд сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын холбогдох асуудал хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж, нөхцөл шалгуурыг хангасан эсэхийг тодорхойлох бөгөөд энэ тухай мэдээллийг хагас, бүтэн жилийн эцсээр мэдээллийн санд оруулж, тухайн өрхийн үйлчилгээг үргэлжлүүлэн олгох эсхүл зогсоох арга хэмжээг авна.

3.7.Энэ журмын 1.3, 3.1, 3.2, 3.3 дахь хэсэг нь дараах иргэнд хамаарахгүй:

3.7.1.жирэмсний 5 сартайгаас дээш хугацаатай жирэмсэн эх;

3.7.2.хүүхэд нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй бол 6 хүртэлх насны хүүхэд асарч байгаа эх эсхүл эцэг;

3.7.3.Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.6-д заасан байнгын асаргаа шаардлагатай хүнийг асарч байгаа иргэн;

3.7.4.их, дээд сургууль, коллеж, техникийн болон мэргэжлийн боловсрол, албан бус сургалтын байгууллагад суралцаж байгаа суралцагч;

3.7.5.хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан иргэн;

3.7.6.малчин;

3.7.7. 0-12 хүртэл насны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг;

3.7.8.гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэн;

3.7.9.ахмад настан;

3.7.10. 3 хүртэлх насны хүүхэдтэй эх.

3.8.Энэ журмын 3.7.1-3.7.5-д заасан иргэний талаарх мэдээллийг сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь Ehalamj.mn цахим системээс, 3.7.10-д заасан иргэнийг өрх, сумын эмч, бусад иргэнийг харьяалах сум, хорооны холбогдох байгууллага, 3.7.6, 3.7.7, 3.7.9-д заасан иргэнийг Засаг дарга тодорхойлно.

3.9.Үйлчилгээнд хамрагдсан өрх нь хүүхдийг товллын дагуу заавал хийх дархлаажуулалт, сургуулийн өмнөх болон боловсролын байгууллага эсхүл албан бус боловсролд хамруулах, өрхийн гишүүд элэгний халдварт гепатитын В, С вирусийн илрүүлэг, шинжилгээнд хамрагдаж энэ чиглэлээр эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдах үүрэг хүлээнэ.

3.10.Үйлчилгээнд хамрагдсан өрхийн гишүүдээс сүрьеэгийн илрүүлэг, шинжилгээнд хамрагдаж, өвчилсөн тохиолдолд эмчилгээг

бүрэн хийлгэж дуусгах, гэр бүл, өрхийн бүх гишүүд хавьтлын урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хуваарийн дагуу бүрэн хамрагдах үүрэг хүлээнэ. Нөхцөл биелүүлээгүй шалтгаанаар сүрьеэ өвчтэй хүн, түүний өрхийн гишүүнийг үйлчилгээнээс хасахгүй.

3.11.Үйлчилгээ нь өрхийн гишүүн-иргэний тухайн сарын хүнсний хэрэгцээнд дэмжлэг үзүүлэхэд зориулсан төлбөрийн нэгжийг төлөөлөх банкны цахим карт байна.

3.12.Үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэн И-баримт олгодог аж ахуйн нэгж, зах, бөөний төвд худалдаа эрхлэгч, хүнсний дэлгүүрээс хүнсний бүтээгдэхүүнийг энэ журмын 3.11-д заасан банкны цахим картаар авна.

3.13.Үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэнийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 22.1.1-д заасны дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцдаг талаар сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь мэдээлэл зөвлөгөө өгч ажиллана.

3.14.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь энэ журмын 3.2, 3.3-т заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, мөн журмын 3.9, 3.10, 3.13-т заасан үүргийн биелэлтийг хангуулна.

3.15.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхөөс сард наймаас доошгүй тооны өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж, үнэлгээнд үндэслэн Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж ажиллах ба үе шаттайгаар бүх өрхийг хамруулна. Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын асуудлаар хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтантай хамтран ажиллана.

3.16.Энэ журмын 3.15-д заасан арга хэмжээг сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, орон нутгийн хамтарсан баг, өрхийн эмч, бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлж, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлж үнэлүүлнэ.

3.17.Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний загвар, хэрэгжүүлэх, хяналт тавих аргачлал, зааврыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.18.Энэ журмын 1.2.1-д заасан өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүн нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа

тохиолдолд үйлчилгээнд хамруулна.

3.19.Хэрэв өмнөх онд нийт 6 сараас дээш хугацаанд албан журмаар болон сайн дураар нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бол тухайн иргэнийг энэ журмын 3.18-д заасан нөхцөлийг хангаж байгаад тооцож, жил бүрийн 1 дүгээр сард багтаан шимтгэл төлсөн эсэхийг хянана.

3.20.Үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн гишүүний сүрьеэгийн эмчилгээ тасалдсан тохиолдолд эмнэлгийн байгууллага, ажилтан нь сум, хорооны нийгмийн ажилтантай хамтран ажиллаж, сүрьеэгийн эмчилгээг таслуулахгүй байхад анхаарч дэмжлэг үзүүлэн ажиллана.

Дөрөв.Үйлчилгээний олголт

4.1.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь өрхийн гишүүн-иргэний тухайн сард авах үйлчилгээний мөнгөн дүнг тооцож, нэрсийн жагсаалтыг шинэчилнэ. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь сар бүрийн 03-ны өдрийн дотор үйлчилгээнд хамруулах болон нөхөн олголт хийх өрхийн жагсаалтыг Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.2.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ журмын 4.1-д заасан нэрсийн жагсаалтыг хүлээн авснаас хойш ажлын 2 хоногийн дотор сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд хүргүүлнэ. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэхүү жагсаалтад тухайн сард үйлчилгээг төлөөлөн авах өрхийн гишүүн-иргэн өөрчлөгдсөн, өрх шинээр нэмэгдсэн, хасагдсан өрхийн дансны талаарх нэмэлт мэдээллийг багтаасан байна.

4.3.Үйлчилгээг дараах байдлаар олгоно:

4.3.1.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 1.2-т заасан жагсаалтын дагуу санхүүжилтийг сар бүрийн 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн сангийн газарт хүргүүлнэ;

4.3.2.Төрийн сангийн газар нь энэ журмын 1.2-т заасан жагсаалтын дагуу өрхийн гишүүн-иргэдийг төлөөлөн үйлчилгээ авах иргэний харилцах дансанд төлбөрийг сар бүрийн 15-ны өдрийн дотор байршуулна;

4.3.3.Төрийн сангийн газар нь иргэний харилцах дансанд олгосон эсэх мэдээллийг ажлын 5 хоногт багтаан Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад цахимаар хүргүүлнэ.

4.4.Өрхийн гишүүн-иргэдийг төлөөлөн үйлчилгээг авах иргэн нь гэрээт банкнаас өөрийн биеэр ирж авна. Өөрийн биеэр ирж авч

чадахгүй нөхцөлд итгэмжлэгдсэн хүнээр авхуулж болно. Итгэмжлэлийг Нотариатын тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу нотариатч олгоно. Хэрэв суманд нотариатч ажиллаагүй бол сумын Засаг даргын Тамгын газрын дарга Нотариатын тухай хуулийн 10.2-т заасны дагуу итгэмжлэл олгоно.

4.5.Шинээр төрсөн хүүхэд, 18 насанд хүрсэн болон шилжиж ирсэн өрхийн гишүүн-иргэдийн үйлчилгээний мөнгөн дүнг мэдээллийн санд оруулсан сарын дараагийн сараас тус тус нэмж, нас барсан гишүүний мөнгөн дүнг нас барсан сарын дараагийн сараас хасаж тооцно.

4.6.Өрхийн гишүүн-иргэдийг төлөөлөн үйлчилгээг авах насанд хүрсэн гишүүнгүй болсон тохиолдолд Гэр бүлийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1-д заасан шийдвэрийг үндэслэн тухайн өрхийн насанд хүрээгүй гишүүн-иргэдийн үйлчилгээг асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгоно.

4.7.Үйлчилгээний цахим картыг хаяж үрэгдүүлсэн, соронзон туузыг гэмтээсэн тохиолдолд дахин олгоход шаардагдах зардлыг тухайн өрхийн гишүүн-иргэн өөрөө хариуцна.

4.8.Үйлчилгээнд хамрагдсан өрхийн ам бүлийн гишүүдээс сүүлийн 3 хүртэлх жилийн хугацаанд насанд хүрээгүй хүүхэд хорих ангид ял эдэлж байгаа тохиолдолд тухайн хугацааны мөнгийг түр түдгэлзүүлж, буцаж ирсэн нөхцөлд үргэлжлүүлэн олгоно. Харин өрхийн ам бүлийн гишүүдээс хугацаат цэргийн алба хаах болон хорих ангид ял эдэлж байгаа тохиолдолд өрхийн гишүүдийн бүртгэлд хэвээр үлдээж, буцаж ирсэн нөхцөлд энэ журмын 5.9-д заасныг баримтлан шийдвэрлэнэ.

4.9.Үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийг хамрагдаж эхэлсэн сараас тооцон 2 жил болмогц дахин үнэлгээ хийж, энэ журмын 1.2.1-д заасан нөхцөлийг хангасан тохиолдолд үргэлжлүүлэн олгоно.

4.10.Энэ журмын 5.2.4-т заасны дагуу өрхийн мэдээ, тоо баримтыг холбогдох төрийн байгууллагын захиргааны мэдээллийн сантай хийсэн улирал бүрийн тулгалтаар 200 ба түүнээс дээш малтай өрх, 2 ба түүнээс дээш орон сууцны байшин, 2 ба түүнээс дээш бие даасан тохилог сууц, 2 ба түүнээс дээш авто машинтай өрхийг хамруулах эсэхийг нягталж, өөрчлөлт орсон нь тогтоогдвол тус үйлчилгээнээс хасах шийдвэрийг Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцэн аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага нь халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.11.Энэ журамд заасан үйлчилгээнд хамрагдах нөхцөлийг хангаагүй боловч өрхийн амьжиргааны түвшин бага байгаа, эсхүл өрхийн амьжиргааны түвшний оноо нь бага боловч өрх амьжиргаа сайтай байгаа талаар иргэн, байгууллага, ажилтнаас гомдол ирсэн бол Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүд өрхөөр зочлон нөхцөл байдлын

үнэлгээ хийж, үйлчилгээнд хамруулах гомдол үндэслэлтэй эсэхийг зөвлөлийн хурлаар хэлэлцэн, шийдвэр гаргаж нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлнэ.

Тав.Өрхийн гишүүн-иргэний шилжилт хөдөлгөөнийг бүртгэх

5.1.Үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн гишүүн-иргэн нь нас барсан, шилжин явсан, хүүхэд төрүүлсэн, үрчлэн авсан болон үрчлүүлсэн, гэр бүл цуцлуулсан зэрэг өөрчлөлтийг 14 хоногийн дотор сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд заавал мэдэгдэх үүрэгтэй.

5.2.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь өрхийн гишүүн-иргэний шилжилт хөдөлгөөний өөрчлөлтийн талаарх мэдээллийг халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын баталсан “Өрхийн гишүүн-иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн маягт”-ын дагуу гаргаж холбогдох баримт бичгийн хуулбарын хамт аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад бичгээр болон цахим хэлбэрээр сар бүрийн сүүлийн өдөр хүргүүлнэ.

5.3.Энэ журмын 5.2-т заасны дагуу ирүүлсэн мэдээллийг нягтлан шалгаж, нэгтгэн, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад дараа сарын 03-ны өдрийн дотор хүргүүлнэ.

5.4.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь өрхийн гишүүн-иргэн нас барсан, хүүхэд төрүүлсэн, үрчлэн авсан, үрчлүүлсэн, шилжсэн, гэрлэлт цуцлуулсан тохиолдолд үйлчилгээг тухайн гишүүн-иргэнд ногдох мөнгөн дүнг нэмэх, эсхүл хасах замаар мөнгөн дүнг өөрчлөн тогтооно.

5.5.Өрхийн гишүүн-иргэдийг төлөөлөн үйлчилгээ авах иргэн нас барсан, шилжсэн болон бусад шалтгаанаар авч чадахгүй болсон тохиолдолд 16 насанд хүрсэн өөр гишүүнд эрх шилжүүлэх тухай хүсэлтийг өрхийн бусад гишүүдийн зөвшөөрснөөр тухайн өрхийн аль нэг гишүүн-иргэн сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд гаргана.

5.6.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь энэ журмын 5.1-д заасан өөрчлөлтийг үйлчилгээний цахим системд бүртгэнэ.

5.7.Үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн гишүүн-иргэн өөр аймаг хооронд болон дүүрэг хооронд шилжсэн бол тухайн сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн өрхийн жагсаалт дахь үйлчилгээний мэдээллийг системээс цахимаар шилжүүлнэ.

5.8. Үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн гишүүн-иргэн нь шилжин ирсэн сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд хандана. Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь энэ журмын 5.2-т заасны дагуу шилжин ирсэн өрхийн гишүүн-иргэний мэдээллийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад цахимаар хүргүүлнэ. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь мэдээллийн нэгдсэн санд энэ тухай тэмдэглэнэ. Өрхийн гишүүн-иргэнийг бүртгүүлсний дараагийн сараас эхлэн тооцож үргэлжлүүлэн олгоно.

5.9. Үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхөд шинээр гишүүн шилжин ирсэн тохиолдолд тухайн гишүүнд олгохгүй. Хэрэв тухайн өрх шинээр шилжин ирсэн гишүүнийг үйлчилгээнд нэмж хамруулах хүсэлт гаргасан тохиолдолд амьжиргааны түвшинг дахин үнэлнэ.

5.10. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас энэ журмын 5.9-д заасан өрхийн амьжиргааны түвшинг дахин үнэлж, үйлчилгээнд хамрагдах нөхцөл хангасан өрхийн гишүүн-иргэдийн мэдээллийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлэх бөгөөд шинээр нэмэгдсэн өрхийн гишүүн-иргэнд олгох ажлыг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага энэ журмын дагуу зохион байгуулна.

5.11. Өрхийн гишүүн-иргэн нь байнга оршин суух хаягт амьдардаггүй болон хаягийн зөрчилтэй тохиолдолд үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ бичгээр тухайн амьдарч байгаа хаягийн дагуу сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд гаргана.

5.12. Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь мөн журмын 5.11-д заасан өрхийн гишүүн иргэний хүсэлтэд үндэслэн, дахин үнэлгээнд хамруулж, энэ журмын 1.2-т заасан нөхцөлийг хангаж байгаа тохиолдолд сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

Зургаа. Үйлчилгээний олголтыг зогсоох, түдгэлзүүлэх

6.1. Үйлчилгээний олголтыг дараах тохиолдолд зогсооно:

6.1.1. дахин үнэлгээгээр амьжиргааны түвшингийн үнэлгээ нь энэ журмын 1.2.1-д заасан босго онооноос дээш гарсан;

6.1.2. өрхийн гишүүн-иргэн өөрийн хүсэлтээр үйлчилгээ авахаас татгалзсан;

6.1.3. өрхийн гишүүн-иргэн Монгол Улсын харьяатаас гарсан;

6.1.4. хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, худал мэдээлсэн нь тогтоогдсон;

6.1.5. үйлчилгээнд хамрагдах эрх үүсэхгүй нь тухайн байгууллагын дотоод хяналт болон дээд шатны байгууллагын хяналт,

шалгалтаар тогтоогдсон;

6.1.6.өрхийн гишүүн иргэн нь банкны картаа бусдад дамжуулсан, барьцаанд тавьсан, зөвшөөрөгдөөгүй бүтээгдэхүүн худалдан авсан нь тогтоогдсон.

6.2.Үйлчилгээний олголтыг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ:

6.2.1.гурав ба түүнээс дээш гишүүн ам бүлийн тооноос хасагдсан;

6.2.2.өрхийн гишүүн-иргэд аймаг, нийслэл хооронд шилжсэн;

6.2.3.үйлчилгээг 3 сарын хугацаанд аваагүй болон ашиглаагүй;

6.2.4.энэ журмын 1.3-т заасан иргэн нь мөн журмын 3.2, 3.3-т заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нөхцөл, шалгуурыг биелүүлээгүй;

6.2.5.холбогдох төрийн байгууллагын мэдээллийн сантай 200 ба түүнээс дээш малтай өрх, 2 ба түүнээс дээш орон сууцны байшин, 2 ба түүнээс дээш бие даасан тохилог сууц, 2 ба түүнээс дээш авто машинтай өрхийн мэдээ, тоо баримтыг сар бүр тулгалт хийхэд энэ журмын 3.10-т заасан өөрчлөлт илэрсэн.

6.3.Энэ журмын 6.2-т заасны дагуу түдгэлзүүлсэн тохиолдолд тухайн өрхийн амьжиргааны түвшинг дахин үнэлнэ. Хэрэв тухайн өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээ нь энэ журмын 1.2.1-д заасан нөхцөлийг хангаж байвал олгогдоогүй хугацааны үйлчилгээг нөхөн олгоно.

6.4.Энэ журмын 6.3-т заасны дагуу нөхөн олгох тохиолдолд өрхийн гишүүн-иргэн шилжин суурьшсан нутаг дэвсгэрийн захиргаандаа 180-аас дээш хоногт бүртгүүлээгүй бол бүртгэлгүй байсан хугацаанд нөхөн олгохгүй.

6.5.Энэ журмын 6.2.3-т заасны дагуу түдгэлзүүлсэн тохиолдолд тухайн өрхийн гишүүн-иргэн үйлчилгээ авах эрхээ сэргээлгэх хүсэлт гаргавал сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн судлан үзэж, Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, эрх сэргээх үндэслэлтэй гэж үзвэл холбогдох санал, тайлбарын хамт аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ. Хэрэв үйлчилгээ авах эрхийг сэргээх үндэслэлгүй гэж үзвэл сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн энэ тухай иргэнд мэдэгдэнэ.

6.6.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ журмын 6.5-д заасан өрхийн гишүүн-иргэний хүсэлт, холбогдох санал, тайлбарыг нягтлан шалгаж, тухайн өрхийн гишүүн-иргэдэд үйлчилгээ олгох эсэхийг шийдвэрлэнэ. Хэрэв тухайн өрхийн гишүүн-иргэдэд үйлчилгээг олгохоор шийдвэрлэсэн бол үргэлжлүүлэн олгох бөгөөд түдгэлзүүлсэн хугацааны санхүүжилтийг нөхөн олгохгүй. Бусад тохиолдолд энэ журмын 9.3-9.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.

6.7.Өрхийн гишүүн-иргэний өөрийн буруутай үйлдлийн улмаас данс давхар нээлгэснээс тухайн сарын санхүүжилт шилжээгүй тохиолдолд олголтыг түр зогсооно.

6.8.Энэ журмын 6.7-д заасны дагуу алдааг залруулсны дараа үргэлжлүүлэн олгох бөгөөд түр зогсоосон хугацааны санхүүжилтийг нөхөн олгоно.

Долоо.Үйлчилгээг олгох үйл ажиллагаанд оролцогч байгууллага

7.1.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүнс тэжээлийн дэмжлэг олгох ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний мэдээллийн сан, сүлжээг хэвийн ажиллуулах, шинэчлэх үүрэг хүлээнэ.

7.2.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь үйлчилгээ үзүүлэх банкйг хуулийн дагуу сонгон шалгаруулж, тус үйлчилгээнд хамрагдах иргэнийг оролцуулан гэрээ байгуулна.

7.3.Банк нь батлагдсан загвар, хамтран ажиллах гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөрийн карт хэлбэрээр хэвлүүлэх бөгөөд төлбөрийн карт нь банкны бусад картаас ялгагдах өнгө, дүрслэл, нууцлалтай байна.

7.4.Банк нь мөнгөний автомат машинаас бэлэн мөнгө гаргаж авах, энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан 10 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээс өөр худалдан авалт хийх боломжгүй байх, бусад тохируулгатай холбоотой систем хөгжүүлэлтийг хийж, цахим картын аюулгүй ажиллагааг хариуцна.

7.5.Цахим карт нь пин кодтой байна.

7.6.И-баримт олгодог аж ахуйн нэгж, зах, бөөний худалдааны төвд худалдаа эрхлэгч, хүнсний дэлгүүр нь үйлчилгээнд хамрагдах өрхийн гишүүн-иргэний цахим картад үндэслэн үйлчилнэ.

7.7.Үйлчилгээнд хамрагдаж байгаа өрх, иргэн нь И-баримт олгодог аж ахуйн нэгж, зах, бөөний төвд худалдаа эрхлэгч, хүнсний дэлгүүрийн хөнгөлөлтийн карт, бүх төрлийн урамшууллын оноог ашиглахгүй.

7.8.Үйлчилгээгээр энэ журмын 1 дүгээр хавсралтад зааснаас бусад нэр, төрлийн бүтээгдэхүүн худалдах, худалдан авахыг хориглоно.

7.9.Үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн гишүүн-иргэн нь И-баримт олгодог аж ахуйн нэгж, зах, бөөний төвийн худалдаа эрхлэгч, хүнсний дэлгүүрээс худалдан авалт хийсэн тохиолдолд тухайн дэлгүүрт бараа бүтээгдэхүүний буцаалт хийх боломжгүй.

7.10.Үйлчилгээ үзүүлэх И-баримт олгодог аж ахуйн нэгж, зах, бөөний төвд худалдаа эрхлэгч, хүнсний дэлгүүр нь тусгай шошго, тэмдэг тэмдэглэгээг байршуулж болно.

7.11.Энэ журмын 7.5-д заасан аж ахуйн нэгж, худалдаа эрхлэгч, хүнсний дэлгүүр нь энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хүнсний бараа бүтээгдэхүүнийг олон улсын стандарт GS1-13 зураасан кодоор бүртгэнэ.

7.12.Энэ журмын 7.5-д заасан аж ахуйн нэгж, худалдаа эрхлэгч, хүнсний дэлгүүр нь И-баримт, картын мэдээллийг нэгтгэн хэвлэдэг төхөөрөмжтэй байх шаардлагатай.

Найм.Үйлчилгээний олголтыг тайлагнах, хяналт тавих

8.1.Банк нь жагсаалтад бүртгэлтэй өрхийн гишүүн-иргэний цахим картаар хийсэн гүйлгээний мэдээллийг сар бүрийн сүүлийн өдөр Санхүүгийн мэдээллийн технологийн төвд цахимаар хүргүүлж, Санхүүгийн мэдээллийн технологийн төв нь өрх тус бүрээр дараа сарын 01-ний өдрийн дотор нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, баталгаажуулна.

8.2.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь цахим картын зарцуулсан олголтын тайланг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу гаргаж, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад цаасан болон цахим хэлбэрээр сар бүрийн 03-ны өдрийн дотор тус тус хүргүүлнэ.

8.3.Үйлчилгээний олголт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих үүргийг аудитын байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын нийгмийн халамж болон хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж тус тусынхаа эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.

8.4.Үйлчилгээний олголтыг зохион байгуулахад шаардагдах маягт хэвлүүлэх, мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангах, сургалт, мэдээлэл сурталчилгаа, өргөдөл, гомдлын дагуу амьжиргааны түвшинг дахин үнэлэх, хяналт үнэлгээ хийх болон хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад зардлыг Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан хуваарийн дагуу нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зарцуулна.

8.5.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь үйлчилгээг олгох арга хэмжээний хэрэгжилтийн мэдээг улирал бүр, тайланг тухайн оны эцэст гаргаж Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Ес.Өргөдөл, гомдол шийдвэрлэх

9.1.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь үйлчилгээтэй холбоотой асуудлаар

иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, бүртгэн төрийн байгууллагуудын захиргааны мэдээлэлд үндэслэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн эсэхийг шийдвэрлэнэ. Захиргааны мэдээллээр тухайн өрхийн оноо нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан босго онооноос доогуур бол Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамруулах өрхийн жагсаалтад оруулна. Өрхийн захиргааны мэдээллийн оноо нь босго онооноос дээш бол иргэнд холбогдох мэдээллийг өгнө.

9.2.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг судлан шалгаж, холбогдох хуульд заасан хугацаанд иргэн, байгууллагад хариу мэдэгдэнэ. Өөрийн эрх хэмжээнээс давсан асуудлаарх өргөдөл, гомдлыг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад уламжилна.

9.3.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь үйлчилгээнд хамрагдахыг хүссэн, судалгаанд хамрагдаагүй, амьжиргааны түвшингийн үнэлгээтэй санал нийлэхгүй, үйлчилгээ авах нөхцөл хангаагүй өрхийн гишүүн-иргэн хамрагдсан болон энэ журмын 5.11, 6.2-т заасан асуудлаар гаргасан өргөдөл, гомдлыг Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, тухайн өрхийн амьжиргааны түвшинг үнэлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэрсийн жагсаалт, хурлын санал, шийдвэр, холбогдох баримт бичгийн хамт аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.

9.4.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ журмын 9.3-т заасан нэрсийн жагсаалт, холбогдох баримт бичгийг хүлээн авч Засгийн газрын 2023 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах ашиглах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-д заасан нөхцөлөөр дахин үнэлгээнд хамруулна.

9.5.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ журмын 9.4-т заасан дахин үнэлгээний дагуу өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээ хийж, үйлчилгээнд хамрагдах нөхцөл хангасан болон судалгааны үр дүнг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад мэдэгдэнэ.

9.6.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь энэ журмын 9.1-д заасан өргөдөл, гомдлын мэдээг сар бүр гаргаж, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад танилцуулгын хамт хүргүүлнэ.

9.7.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ журмын 9.6-д заасан мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэлтийн явц байдалд хяналт тавьж, нэгтгэн, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад сар, улирал, жилээр гарган тус тус хүргүүлнэ.

9.8.Өргөдөл, гомдол хүлээн авах маягт, тайлангийн загварыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

Арав.Бусад

10.1.Харилцагч банк, И-баримт олгодог аж ахуйн нэгж, зах, бөөний худалдааны төвд худалдаа эрхлэгч, хүнсний дэлгүүр болон бусад этгээд нь үйлчилгээний санхүүжилтийг бэлэн мөнгө болгох, бусдад арилжаалахыг хориглоно.

10.2.Үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн гишүүн-иргэн нь энэ журмын 2.4-т заасан баримт бичгийг хуурамчаар үйлдэж, үйлчилгээ авсан, энэ журмын 5.1-д заасан өөрчлөлтийг тогтоосон хугацаанд мэдэгдээгүй бол илүү авсан хугацааны санхүүжилтийг нь эхний удаа нөхөн төлүүлэх буюу дараа сарынх нь мөнгөн дүнгээс суутгана.

10.3.Энэ журмын 2.11, 10.2-т заасан зөрчлийг давтан гаргасан тохиолдолд үйлчилгээний олголтыг зогсоож дахин хамруулахгүй.

10.4.Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, ажилтны гаргасан алдааны улмаас илүү олгогдсон санхүүжилтийн үнийн дүнг буцаан суутгахгүй бөгөөд хохирлыг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

10.5.Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, ажилтан үйлчилгээний санхүүжилтийг санаатайгаар шамшигдуулсныг эрх бүхий этгээд тогтоосон тохиолдолд буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

*“Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”-ын
нэгдүгээр хавсралт*

**ХҮНС ТЭЖЭЭЛИЙН ДЭМЖЛЭГЭЭР ОЛГОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ЖАГСААЛТ**

- 1.Мах, дайвар бүтээгдэхүүн (импортын бус)
- 2.Сүү, сүүн бүтээгдэхүүн (импортын бус)
- 3.Гурил, гурилан бүтээгдэхүүн (импортын бус)
- 4.Цөцгийн тос
- 5.Элсэн чихэр
- 6.Төмс, хүнсний ногоо
- 7.Будаа
- 8.Ургамлын тос
- 9.Өндөг
- 10.Жимс, жимсгэнэ

Тайлбар:

1.Мах, дайвар бүтээгдэхүүнд худалдан борлуулахаар зөвшөөрөгдсөн бүх төрлийн мал, амьтны мах, малын гэдэс дотор, толгой, шийр орно. Хиам болон лаазалсан, дахин боловсруулсан махан бүтээгдэхүүн хамаарахгүй.

2.Сүү, сүүн бүтээгдэхүүн гэдэгт хуурай болон шингэн сүү, тараг, аарц хамаарна.

3.Гурил, гурилан бүтээгдэхүүнд бялуу, кекс хамаарахгүй.

4.Төмс, хүнсний ногоо гэдэгт дарсан ногоо буюу лаазалсан, дахин боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй.

5.Будаа гэдэгт бүх төрлийн будаа, хүүхдийн будаа, үр тариа, шар буурцгийн гаралтай бүтээгдэхүүн хамаарна.

6.Жимс, жимсгэнэ гэдэгт компот, жимсний чанамал, хатаасан жимс хамаарахгүй.

“Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”-ын
хоёрдугаар хавсралт

Хүнс тэжээлийн дэмжлэгээр олгосон санхүүжилтийн тайлангийн маягт

(.....-р сар)
Аймаг/дүүрэг:
Огноо:

№	Аймаг/ дүүрэг	Сум / Хороо	Өрхийн бүртгэлийн дугаар	Нийт олгох/ Өрх гишүүнээр		Бодогдсон дүн		Олгосон мөнгөн дүн		Тайлбар
				Өрхийн тоо	18 хүртэлх	18-аас дээш	Цахим эрхийн бичиг	Нийт дүн	Цахим эрхийн бичиг	
1		2	3	4	5	6	7	8	9	

“Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”-ын
гуравдугаар хавсралт

Хүнсний цахим эрхийн бичгээр олгосон бүтээгдэхүүний
тайлангийн маягт

(.....-р сар)

Аймаг/дүүрэг:

Огноо:

№	Сум/хороо	Бүтээгдэхүүний нэр /дэлгэрэнгүй/	Мөнгөн дүн	Тайлбар

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 7389 дүгээрт бүртгэв.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 9 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар А/250

Улаанбаатар
хот

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.20 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын навигацийн техникийн үйлчилгээ, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, хэрэглэлийн нислэгийн журам боловсруулах, нисэхийн цаг уурын болон нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг зохицуулах Иргэний нисэхийн дүрэм болох “ИНД-171 Агаарын навигацийн техникийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” дүрмийг нэгдүгээр хавсралтаар, “ИНД-172 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” дүрмийг хоёрдугаар хавсралтаар, “ИНД-173 Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” дүрмийг гуравдугаар хавсралтаар, “ИНД-174 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” дүрмийг дөрөвдүгээр хавсралтаар, “ИНД-175 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” дүрмийг тавдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Иргэний нисэхийн дүрмийг мөрдөж, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн шаардлагатай тохиолдолд боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр), энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газар (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Багц дүрэм батлах тухай” 187 дугаар тушаалын 10 дугаар хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-10 “Агаарын хөлөгтэй харилцах холбоо, дохиог ашиглах”-ын “ИНД-171 Агаарын навигацийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт”, 5 дугаар хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-5 “Монгол Улсын хилээр агаарын хөлөг нэвтрэх, аэродромд буух, хөөрөх, Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх, нислэгийн хөдөлгөөн удирдах”-

ын “ИНД-172 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт”, 7 дугаар хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-7 “Иргэний нисэхийн навигацийн хэрэгслийг ашиглах явцад гарч болох сөрөг нөлөөг багасгах, агаарын хөлөгт аюул учрахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тоног төхөөрөмж, гэрэл дохиог суурилуулах, ашиглах”-ын “ИНД-173 Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт”, “ИНД-175 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт”, 9 дүгээр хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-9 “Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах байгууллагыг гэрчилгээжүүлэх”-ийн “ИНД-174 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” дүрмүүдийг бүхэлд нь, 2021 оны “Тушаалд нэмэлт оруулах тухай” А/16 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын “ИНД-171 Агаарын навигацийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт”, “ИНД-172 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт”, “ИНД-173 Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт”, “ИНД-174 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт”, “ИНД-175 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт”-тэй холбогдох хэсэг, 2023 оны “Иргэний нисэхийн багц дүрэмд өөрчлөлт оруулах тухай” А/44 дүгээр тушаал, 2023 оны “Иргэний нисэхийн багц дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/273 дугаар тушаалын 3 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Энэ тушаалын хавсралтыг доорх линкээр үзнэ үү.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17433706636882>

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 7390 дүгээрт бүртгэв.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар А/257

Улаанбаатар
хот

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аэродром байгуулах, аэродромыг гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг зохицуулах Иргэний нисэхийн дүрэм “ИНД-139 Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт” дүрмийг нэгдүгээр хавсралтаар, “ИНД-157 Аэродром байгуулах, өөрчлөх, нээх болон хаах” дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Иргэний нисэхийн дүрмийг мөрдөж, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн шаардлагатай тохиолдолд боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр)-т, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газар (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Багц дүрэм батлах тухай” 187 дугаар тушаалын 7 дугаар хавсралт, 2023 оны “Иргэний нисэхийн багц дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/273 дугаар тушаалын 5 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Энэ тушаалын хавсралтыг доорх линкээр үзнэ үү.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17433688081312>

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар А/258

Улаанбаатар
хот

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.1, 17.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагааг зохицуулах Иргэний нисэхийн дүрэм “ИНД-101 Хүнгүй агаарын хөлөг, пуужин, жироглайдер болон парасэйлийн үйл ажиллагаа”-г нэгдүгээр хавсралтаар, “ИНД-103 Хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагаа”-г хоёрдугаар хавсралтаар, “ИНД-104 Глайдерын үйл ажиллагаа”-г гуравдугаар хавсралтаар, “ИНД-106 Ханг глайдерын үйл ажиллагаа”-г дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Иргэний нисэхийн дүрмийг мөрдөж, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн шаардлагатай тохиолдолд боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр), энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газар (Ч.Мөнхтуяа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Багц дүрэм батлах тухай” 187 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-5 “Монгол Улсын хилээр агаарын хөлөг нэвтрэх, аэродромд буух, хөөрөх, Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх, нислэгийн хөдөлгөөн удирдах”-ын “ИНД-103 Хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагааны дүрэм”, “ИНД-104 Глайдерын үйл ажиллагааны дүрэм”, “ИНД-106 Ханг-глайдерын үйл ажиллагааны дүрэм”, 11 дүгээр хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-11 “Монгол Улсын агаарын зайн хориотой бүсэд нислэг үйлдэх”-ийн “ИНД-101 Хүнгүй агаарын хөлөг, пуужин, жиро-глайдер болон парасэйлийн үйл ажиллагааны дүрэм”-ийг тус тус бүхэлд нь, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны “Иргэний нисэхийн багц дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/72 дугаар тушаалын 1, 2, 4, 5 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн
А/258 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

ИНД - 101 Хүнгүй агаарын хөлөг, пуужин, жироглайдер болон парасэйлийн үйл ажиллагаа

А Бүлэг - Ерөнхий зүйл

101.1. Зорилго

(а) Энэ дүрмийн зорилго нь ИНД-102 Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт (цаашид “ИНД-102” гэх)-ийн 102.21-д заасан нөхцөлд хамааралтай дараах төхөөрөмжийн үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооход оршино:

(1) аргамжаат бөмбөлөг болон цаасан шувуу;

(2) чөлөөт бөмбөлөг;

(3) пуужин;

(4) зайнаас удирддаг агаарын хөлөг, утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар болон чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар;

(5) жироглайдер болон парасэйл.

101.3. Нэр томьёо ба товчлол

(а) Энэ дүрэмд хэрэглэх нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбар-т тусгасан.

101.5. Бүртгэл

(а) ИНД-47 Агаарын хөлгийн бүртгэл (цаашид “ИНД-47” гэх)-ийн шаардлага нь хүнгүй агаарын хөлөг, цаасан шувуу, пуужин, парасэйл болон жироглайдерт хамаарахгүй.

101.7. Хязгаарлалттай, цэргийн үйл ажиллагааны, аюултай болон хориотой бүс

(а) Хязгаарлалттай бүсийн үйл ажиллагаа хариуцсан эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь ИНД-71 Агаарын зайг тогтоох болон ангилах (цаашид “ИНД-71” гэх)-ын дагуу тогтоосон хязгаарлалттай бүсэд хүнгүй агаарын хөлөг, цаасан шувуу, жироглайдер, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа эрхлэхгүй.

(b) Цэргийн үйл ажиллагааны бүсийн үйл ажиллагаа хариуцсан эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд аливаа этгээд нь ИНД-71-ийн дагуу тогтоосон цэргийн үйл ажиллагааны бүсэд хүнгүй агаарын хөлөг, цаасан шувуу, жироглайдер, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа эрхлэхгүй.

(c) ИНД-71-ийн дагуу тогтоосон аюултай бүсэд хамаарах үйл ажиллагаа нь жироглайдер, эсхүл парасэйлийн аюулгүй байдалд нөлөөлөхгүй болохыг тогтоосноос бусад тохиолдолд аливаа этгээд нь

тухайн аюултай бүсэд жироглайдер, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа эрхлэхгүй.

(d) Аливаа этгээд нь хүнгүй агаарын хөлөг, цаасан шувуу, жироглайдер, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа эрхлэн ИНД-71-ийн дагуу тогтоосон хориотой бүсэд нэвтрэхийг хориглоно.

101.9. Нам өндрийн нислэгийн зон

(a) ИНД-71-ийн дагуу тогтоосон нам өндрийн нислэгийн зонд аливаа этгээд нь дараах төхөөрөмжөөр үйл ажиллагаа эрхлэхгүй:

- (1) хүнгүй агаарын хөлөг;
- (2) цаасан шувуу;
- (3) пуужин;
- (4) жироглайдер;
- (5) парасэйл.

101.11. Хяналттай агаарын зай

(a) Халхлагдсан үйл ажиллагаанаас бусад тохиолдолд тухайн агаарын зайг хариуцсан Нислэгийн хөдөлгөөний удирдлага (цаашид “НХУ” гэх)-ын нэгжээс урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр аливаа этгээд нь дараах төхөөрөмжөөр хяналттай агаарын зайд үйл ажиллагаа эрхлэхгүй:

- (1) хүнгүй агаарын хөлөг;
- (2) цаасан шувуу;
- (3) пуужин;
- (4) жироглайдер;
- (5) парасэйл.

101.12. Агаарын зайн мэдлэг

(a) Энэ зүйл нь дараах төхөөрөмжөөр үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хамаарна:

- (1) хүнгүй агаарын хөлөг;
- (2) цаасан шувуу;
- (3) пуужин;
- (4) жироглайдер;
- (5) парасэйл.

(b) Энэ зүйлийн (a)-д хамаарах этгээд нь дараах үүрэгтэй:

(1) нислэг бүрийн өмнө ИНД-71-ийн дагуу тогтоосон агаарын зайн ангилал болон үйл ажиллагаа эрхлэхээр төлөвлөсөн бүсийн холбогдох агаарын зайн хязгаарлалтын талаар мэдэж байгаагаа бататгах; эсхүл

(2) тухайн үйл ажиллагааг ИНД-71-ийн дагуу тогтоосон агаарын зайн ангилал болон үйл ажиллагаа эрхлэхээр төлөвлөсөн бүсийн холбогдох агаарын зайн хязгаарлалтын талаар мэдлэгтэй этгээдийн шууд хяналтад гүйцэтгэх.

101.13. Аюул болон эрсдэлийг багасгах

(а) Дараах үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь хүн, эсхүл өмч хөрөнгө болон бусад агаарын хөлөгт учирч болзошгүй аюулыг багасгах боломжит бүх арга хэмжээг авах үүрэгтэй:

- (1) хүнгүй агаарын хөлөг;
- (2) цаасан шувуу;
- (3) пуужин;
- (4) жироглайдер;
- (5) парасэйл.

101.15. Эд зүйл хаях

(а) Дараах үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь хэрэв тухайн үйлдэл нь хүн, эсхүл өмч хөрөнгөд аюул учруулахаар бол нислэгийн үед аливаа зүйлийг хаяхыг хориглоно:

- (1) хүнгүй агаарын хөлөг;
- (2) цаасан шувуу;
- (3) пуужин;
- (4) жироглайдер;
- (5) парасэйл.

В Бүлэг - Аргамжаат бөмбөлөг болон цаасан шувуу

101.51. Хамрах хүрээ

(а) Энэ бүлэг нь аргамжаат бөмбөлөг болон цаасан шувууны үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.

101.53. Аэродромын бүс

(а) Аливаа этгээд нь аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар дараах байрлалд үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй:

- (1) агаарын хөлгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа аэродромын хөдөлгөөнт бүс дээр болон дээгүүр; эсхүл
- (2) хөөрч буух зурвас (цаашид “ХБЗ” гэх), ХБЗ-ны талбай дээр болон дээгүүр.

101.55. Аэродромын хил хязгаар

(а) Халхлагдсан үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааны хувьд, дор дурдсанаас бусад тохиолдолд аливаа этгээд нь аэродромын хил хязгаараас 4 км-ийн дотор аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар үйл ажиллагаа эрхлэхгүй:

- (1) тухайн бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь газрын түвшнээс дээш (цаашид “AGL” гэх) 120 м (400 ft)-ээс дээш хэтрэхгүй байх;
- (2) тухайн бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь үүлнээс доош 120 м (400 ft)-ээс багагүй босоо зайд тогтож байх;
- (3) газрын хараа 4 км-ээс багагүй байх;
- (4) хэрэв тухайн аэродром нь хяналттай аэродром бол НХУ-ын нэгжээс зөвшөөрөл авсан байх;

(5) хэрэв аэродром нь хяналтгүй аэродром бол, тухайн үйл ажиллагааг аэродромын үйл ажиллагаа эрхлэгчтэй байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэсэн байх.

101.57. Агаарын зай

(а) Халхлагдсан үйл ажиллагаанаас бусад тохиолдолд аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар AGL 120 м (400 ft)-ээс дээш өндөрт үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь дараах үүрэгтэй:

(1) ИНД-71-ийн дагуу тухайн зорилгоор тогтоосон аюултай бүсэд үйл ажиллагаа эрхлэх; эсхүл

(2) энэ зүйлийн (b) хэсэгт заасан хязгаарлалтын дагуу үйл ажиллагаа эрхлэх.

(b) Аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар аюултай бүсийн гадна AGL 120м (400ft)-ээс дээш өндөрт үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь дараах нөхцөлийг бататгах үүрэгтэй:

(1) тухайн бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь аэродромын хил хязгаараас 4 км-ээс хол зайд байнга байгааг;

(2) тухайн бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь ИНД-71-ийн дагуу тогтоосон G ангиллын агаарын зайд байнга байгааг;

(3) тухайн цаасан шувууны жин 15 кг-аас хэтрээгүйг;

(4) бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь үүлнээс доош 120 м (400 ft)-ээс доошгүй босоо зайд байнга байгааг;

(5) газрын хараа 4 км-ээс багагүй байгааг;

(6) тухайн үйл ажиллагаа эхлэхээс 24-өөс доошгүй цагийн өмнө Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага (цаашид “НМҮБ” гэх)-д дараах мэдээллийг өгснийг:

(i) тухайн этгээдийн нэр, хаяг, утасны дугаар;

(ii) тухайн үйл ажиллагаа эрхлэх өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;

(iii) тухайн аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувууны хэмжээ, давамгайлсан өнгийг багтаасан товч тайлбар;

(iv) тухайн аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувууны жин;

(v) тухайн аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар үйл ажиллагаа эрхлэх өндөр.

101.59. Шөнийн үйл ажиллагаа

(а) Аливаа этгээд нь аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар шөнөөр үйл ажиллагаа эрхлэхгүй.

101.61. Бөмбөлөг аргамжих уяаны тэмдэглэгээ

(а) AGL 45 м (150 ft)-ээс ихгүй өндрөөс эхлэн бөмбөлгийн аргамжааны дагуу 15 м тутамд 1.8 км-ээс (1 nm) хол зайнаас харагдахуйц өнгөт тууз, эсхүл дарцаг бэхэлснээс бусад тохиолдолд аливаа этгээд нь өдрөөр аргамжаат бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй.

101.63. Бөмбөлгийн хийг хурдан гаргах төхөөрөмж

(а) Бөмбөлөг аргамжаанаас алдуурсан үед хийг автоматаар хурдан гаргах төхөөрөмжөөр тоноглосоноос бусад тохиолдолд аливаа этгээд нь аргамжаат бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй.

101.65. Бөмбөлөг алдуурах

(а) Бөмбөлөг аргамжаанаас алдуурахад түүний хийг гаргах хэрэгсэл зохих ёсоор ажиллаагүй бол аргамжаат бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь ойролцоох Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (цаашид “НХҮ” гэх)-ний нэгжид дараах мэдээллийг яаралтай мэдэгдэх үүрэгтэй:

- (1) тухайн бөмбөлгийн анхны байрлал;
- (2) тухайн бөмбөлөг алдуурсан цаг;
- (3) тухайн бөмбөлгийн тооцоолсон нислэгийн зам.

С Бүлэг - Чөлөөт бөмбөлөг

101.101. Хамрах хүрээ

(а) Энэ бүлэг нь чөлөөт бөмбөлгийн үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.

101.103. Цаг агаарын хязгаарлалт

(а) Холбогдох НХҮ-ний нэгжээс зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа этгээд нь 18,000 м (60,000 ft)-ийн даралтын өндрийн түвшинд, эсхүл түүнээс доош өндрийн түвшнийг нэвтлэн хүнд чөлөөт бөмбөлгөөр дараах нөхцөлд үйл ажиллагаа эрхлэхгүй:

- (1) 4-8 октантаас дээш үүлшилтэй, эсхүл үүлэнд далдлагдсан аюултай үзэгдэл байгаа;
- (2) газрын хараа 8 км-ээс бага;
- (3) бусад улсын нутаг дэвсгэрийн агаарын зайд зөвшөөрөлгүй нэвтэрч болзошгүй бол.

101.105. Үйл ажиллагааны хязгаарлалт

(а) Хүнд, эсхүл дунд чөлөөт бөмбөлөг нь дараах байдлаар нисэхээр бол аливаа этгээд нь түүнийг суллан тавихгүй байх үүрэгтэй:

- (1) хот, сум, эсхүл суурингийн шигүү суурьшлын бүс дээгүүр 300 м (1,000 ft)-ээс доош өндөрт; эсхүл
- (2) олон хүн цугларсан задгай талбайн дээгүүр.

101.107. Төхөөрөмж

(а) Аливаа этгээд нь дараахаас бусад тохиолдолд хүнд чөлөөт бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй:

- (1) дараах төхөөрөмжөөр тоноглогдсон байх:
 - (i) нэгнээсээ үл хамааран автоматаар, эсхүл телеметрийн удирдлагаар ажилладаг, ашигт ачааг нислэгт салгах хоёроос доошгүй төхөөрөмж, эсхүл системээр;
 - (ii) Автомат хамааралтай ажиглалтын систем /ADS-B/-

ээр, хэрэв тухайн агаарын бөмбөлөг нь Монгол Улсын Нислэгийн мэдээллийн бүс (FIR)-д ИНД-71-ийн дагуу тогтоосон транспондер шаардлагатай хяналттай агаарын зайд үйл ажиллагаа эрхлэх бол;

(2) тэг даралттай полиэтилен бөмбөлгийн хувьд, нэгнээсээ үл хамааран ажилладаг, нислэгийг таслан зогсоох чадвартай хоёроос доошгүй арга, систем, хэрэгсэл, эсхүл тэдгээрийн хослолтой байх;

(3) бөмбөлгийн бүрхүүл нь дараах байдлаар тоноглогдсон байх:

(i) радарын дохиог ойлгогч нэгээс доошгүй хэрэгслээр; эсхүл

(ii) 2,700 - 2,900 мГц давтамжийн хүрээнд ажиллаж байгаа газрын радарт эхо үүсгэх радар ойлгогч материалаар.

101.109. Нислэгийг таслан зогсоох

(а) Хүнд бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа аливаа этгээд нь дараах нөхцөлд тухайн нислэгийг таслан зогсоохоор 101.107(а) (1)(i) болон 101.107(а)(2)-д шаардсан зориулалтын таслан зогсоох хэрэгслийг ажиллуулна:

(1) цаг агаарын нөхцөл 101.103-т зааснаас муудсан бол; эсхүл

(2) цаашдын үйл ажиллагаа нь бусад нислэгийн хөдөлгөөн, эсхүл гадаргуу дээр байгаа хүн, эсхүл өмч хөрөнгөд аюул учруулахаар бол; эсхүл

(3) бусад улсын нутаг дэвсгэрийн агаарын зайд зөвшөөрөлгүй нэвтэрч болзошгүй бол.

101.111. Шөнийн үйл ажиллагаа

(а) Бөмбөлөг, түүнд бэхэлсэн хэрэгсэл болон дүүжилсэн ашигт ачаа нь тухайн үйл ажиллагааны үед салах эсэхээс үл хамааран бөмбөлөг тус бүрийг дараах шаардлага хангасан гэрлээр тоноггосноос бусад тохиолдолд аливаа этгээд нь хүнд чөлөөт бөмбөлгөөр 18,000 м (60,000 ft)-ээс доош даралтын өндрийн түвшинд шөнөөр үйл ажиллагаа эрхлэхгүй:

(1) 9 км (5 nm)-ээс багагүй зайд харагдахуйц байх;

(2) минутад 40 - 100 үечлэлийн анивчих давтамжтай байх;

(3) гэрэл нь өөрийн тэжээлийн эх үүсгүүртэй байх.

101.113. Сүүлэн антен

(а) Дараах өнгөт дарцаг, эсхүл тууз уяж бэхэлснээс бусад тохиолдолд аливаа этгээд нь аль ч хэсгээр нь таслахад 230 Ньютоноос их хүч шаарддаг сүүлэн антенаар тоноггосон чөлөөт бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй:

(1) хоорондоо 15 м-ээс ихгүй үечлэлтэй бэхлэгдсэн;

(2) 1.8 км (1 nm)-ээс багагүй зайд харагдахуйц.

101.115. Дүүжин хэрэгсэл

(а) Хурц өнгөтэй задгай шүхрээс бусад дүүжин хэрэгсэл нь дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд аливаа этгээд нь 15 м-ээс

урт дүүжин хэрэгслээр тоногдсон хүнд чөлөөт бөмбөлгөөр 18,000 м (60,000 ft)-ээс доош даралтын өндрийн түвшинд өдрөөр үйл ажиллагаа эрхлэхгүй;

(1) алсаас харагдац сайтай эсрэг өнгөөр хосолсон өнгөтэй байх; эсхүл

(2) 1.8 км (1 nm)-ээс багагүй зайд харагдахуйц өнгөт тууз, эсхүл дарцаг бэхэлсэн байх.

101.117. Хөөргөлтийн өмнөх мэдээлэл

(а) Энэ зүйлийн (b) хэсэгт зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд нь хөөргөхөөр төлөвлөснөөс 24-өөс доошгүй цагийн өмнө дараах мэдээллийг НМУБ-д хүргүүлээгүй бол дунд, эсхүл хүнд чөлөөт бөмбөлгийг хөөргөхгүй:

(1) тухайн этгээдийн нэр, утасны дугаар;

(2) тухайн бөмбөлгийн таних тодорхойлолт, эсхүл төслийн кодын нэр;

(3) тухайн бөмбөлгийн ангилал болон дараах мэдээллийг багтаасан тайлбар:

(i) бөмбөлгийн урт болон диаметр;

(ii) дүүжин хэрэгслийн урт;

(iii) ашигт ачааны жин;

(iv) сүүлэн антены урт;

(4) хэрэв хамааралтай бол, ажиглалтын хоёрдогч радарын код;

(5) тухайн хөөргөх талбайн байрлал;

(6) тухайн тооцоот хөөргөх цаг, эсхүл олон дахин хөөргөх бол эхлэх ба дуусах цаг;

(7) тухайн хөөргөх бөмбөлгийн тоо, олон дахин хөөргөх бол хөөргөлт хоорондын давтагдах хугацаа;

(8) тухайн хөөрөх чиглэлийн баримжаа;

(9) тухайн аяллын нислэгийн түвшинд хүрэх, эсхүл 18,000 м (60,000 ft)-ийн даралтын өндрийн түвшнийг огтлох тооцоот цагийн аль бага утга;

(10) тухайн төлөвлөсөн аяллын нислэгийн түвшин (даралтын өндрийн түвшнээр);

(11) тухайн нислэг үргэлжлэх төлөвлөсөн хугацаа;

(12) газрын гадаргууд буух тооцоот цаг болон байрлал.

(b) Дунд, эсхүл хүнд чөлөөт бөмбөлгийг цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл шаарддаг нарны, эсхүл сансрын идэвхжилийн нөлөөллийг судлах зорилгоор ашиглах тохиолдолд аливаа этгээд нь энэ зүйлийн (а) хэсэгт заасан мэдээллийг эхлэх тооцоот цагаас 30-аас доошгүй минутын өмнө мэдэгдэж болно.

(c) Энэ зүйлийн (а) хэсгийн дагуу өгсөн мэдээлэлд өөрчлөлт

оруулах тохиолдолд үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн өөрчлөлтийг бөмбөлөг хөөргөхөөр төлөвлөсөн хугацаанаас 6-аас доошгүй цагийн өмнө НМҮБ-д мэдэгдэнэ.

101.119. Хөөргөлтийн мэдээлэл

(а) Дунд, эсхүл хүнд чөлөөт бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь бөмбөлгийг хөөргөсний дараа хамгийн ойрын НХҮ-ний нэгжид дараах мэдээллийг нэн даруй мэдэгдэнэ:

(1) тухайн бөмбөлгийн нислэгийг таних тодорхойлолт;

(2) тухайн бөмбөлгийг хөөргөх талбай;

(3) тухайн хөөргөлтийн бодит цаг;

(4) 18,000 м (60,000 ft)-ийн даралтын өндрийн түвшнийг огтлох тооцоот цаг, эсхүл хэрэв аяллын нислэгийн түвшин нь 18,000 м (60,000 ft)-ийн өндөрт, эсхүл түүнээс доош бол хүрэх тооцоот цаг болон тооцоот байрлал;

(5) 101.117(а)(7), эсхүл (8) заалтын дагуу өгсөн мэдээлэлд орсон өөрчлөлт.

101.121. Цуцлалтын мэдээлэл

(а) Энэ дүрмийн 101.117 зүйлийн дагуу хөөргөлтийн өмнөх мэдээлэл хүргүүлсэн этгээд нь тухайн үйл ажиллагааг цуцалсан бол НХҮ-ний нэгжид цуцлалтын талаар нэн даруй мэдэгдэнэ.

101.123. Бөмбөлгийн байршлыг илтгэх

(а) Дунд, эсхүл хүнд чөлөөт бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь:

(1) НХҮ-ний нэгжээс өөрөөр шаардсанаас бусад тохиолдолд хоёр цаг тутамд тухайн бөмбөлгийн чиглэлийг хянаж, түүний байршлыг бүртгэнэ;

(2) НХҮ-ний нэгжээс хүссэн тохиолдолд тухайн бөмбөлгийн байршлын мэдээллийг дамжуулна;

(3) нислэгийн аливаа хоёр цагийн хугацаанд бөмбөлгийн байршлын мэдээлэл бүртгэгдээгүй тохиолдолд ойролцоох НХҮ-ний нэгжид дараах мэдээллийг нэн даруй мэдэгдэнэ:

(i) хамгийн сүүлд бүртгэгдсэн байршил;

(ii) урьдчилан таамагласан зам (траектор)-д орсон өөрчлөлт;

(4) тухайн бөмбөлгийн замын хяналт эргэн тогтоогдвол НХҮ-ний нэгжид нэн даруй мэдэгдэнэ.

101.125. Өндөр алдалтын өмнөх байршлыг илтгэх

(а) Дунд, эсхүл хүнд чөлөөт бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь дараах мэдээллийг төлөвлөсөн өндөр алдалт эхлэхээс нэгээс доошгүй цагийн өмнө ойролцоох НХҮ-ний нэгжид өгнө:

(1) тухайн байгаа газар зүйн байршил;

(2) тухайн байгаа өндрийн түвшин;

(3) хэрэв хамааралтай бол, 18,000м (60,000 ft)-ийн даралтын өндрийн түвшнийг огтлох баримжаат цаг;

(4) тухайн баримжаат өндөр алдалтын траектор;

(5) тухайн газрын гадаргууд буух баримжаат цаг болон байрлал.

101.127. Үйл ажиллагааны гүйцэтгэл

(а) Дунд, эсхүл хүнд чөлөөт бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь тухайн үйл ажиллагаа дууссаны дараа ойролцоох НХҮ-ний нэгжид мэдэгдэнэ.

D Бүлэг - Пуужин

101.151. Хамрах хүрээ

(а) Энэ бүлэг нь пуужингийн үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.

101.153. /Хүчингүй болгосон/

101.155. Аэродром

(а) Энэ зүйлийн (b) хэсэгт зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд нь аэродром дээр, эсхүл аэродромын хил хязгаараас 4 км-ийн дотор пуужингаар үйл ажиллагаа эрхлэхгүй.

(b) Дараах тохиолдолд, аливаа этгээд аэродромын хил хязгаараас 4 км-ийн дотор пуужингаар үйл ажиллагаа эрхэлж болно:

(1) пуужин AGL120 м (400 ft)-ээс дээш өндөрт нисдэггүй бол;

(2) хяналтгүй аэродромд, тухайн үйл ажиллагааг аэродромын үйл ажиллагаа эрхлэгчтэй хийсэн гэрээний дагуу гүйцэтгэж байгаа бол;

(3) хяналттай аэродромд, тухайн үйл ажиллагааг нислэгийн хөдөлгөөний удирдагчаас авсан зөвшөөрлийн дагуу гүйцэтгэж байгаа бол;

(4) аэродромын агаарын хөлгийн ашиглагдаж байгаа хөдөлгөөнт бүс дээр, эсхүл түүний дээгүүр үйл ажиллагаа эрхлэхгүй бол;

(5) ашиглагдаж байгаа ХБЗ-ны талбай дээр, эсхүл дээгүүр үйл ажиллагаа эрхлэхгүй бол.

(с) Аэродромын хил хязгаараас 4-өөс 8 км-ийн хоорондох зайд аливаа этгээд нь AGL120м (400ft)-ээс дээш өндөрт пуужингаар үйл ажиллагаа эрхлэхгүй.

101.157. Цаг уурын хязгаарлалт

(а) Дараах нөхцөлд аливаа этгээд пуужингаар аль ч өндрийн түвшинд үйл ажиллагаа эрхлэхгүй:

(1) 4-8 октантаас дээш үүлшилтэй, эсхүл үүлэнд далдлагдсан аюултай үзэгдэл байгаа бол;

(2) газрын хараа 8 км-ээс бага бол.

(b) Аливаа этгээд эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрөлгүйгээр үүл рүү пуужингаар үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

101.159. Шөнийн үйл ажиллагаа

(а) Аливаа этгээд том загварын пуужингаас бусад пуужингаар шөнөөр үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

101.161. Хөөргөлтийн өмнөх мэдээлэл

(а) Хөөргөхөөс 24-өөс доошгүй цагийн өмнө НМУБ-д дараах мэдээллийг өгснөөс бусад тохиолдолд аливаа этгээд том загварын пуужингаас бусад пуужинг хөөргөхгүй:

(1) Тухайн этгээдийн нэр, хаяг, утасны дугаар, эсхүл нэг арга хэмжээнд олон оролцогч байгаа бол энэ зүйлийн (а)(2), (а)(3) болон (а)(4)-д заасан хөөргөлтийн өгөгдлийн тооцоог багтаасан зохицуулах үүрэгтэй, тухайн хөөргөх арга хэмжээг удирдаж байгаа этгээдийн нэр, хаяг, утасны дугаар;

(2) үйл ажиллагаанд ашиглахаар төлөвлөсөн пуужингийн тоо;

(3) пуужин бүрийн тооцоот хэмжээ болон тооцоот жин;

(4) пуужин бүрийн хөөрч хүрэх хамгийн их тооцоот өндрийн түвшин, эсхүл нислэгийн түвшин;

(5) тухайн үйл ажиллагааны байрлал;

(6) тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;

(7) мэдээлэл авч байгаа этгээдийн хүссэн бусад холбогдох мэдээлэл.

Е Бүлэг - Зайнаас удирддаг агаарын хөлөг, утсан удирдлагатай болон чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар

101.201. Хамрах хүрээ

(а) ИНД-102-ийн 102.21-д заасныг харгалзан, энэ бүлэг нь дараах нисдэг төхөөрөмжид хамаарна:

(1) зайнаас удирддаг агаарын хөлөг;

(2) утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар;

(3) чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар.

101.202. Зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллага

(а) Зайнаас удирддаг агаарын хөлгийг зохион бүтээх, үйлдвэрлэх, эсхүл үйл ажиллагаа эрхлэх зохих мэдлэг, мэргэшилтэй, эсхүл агаарын зайн хуваарилалт, хязгаарлалтын талаар зохих мэдлэгтэй, дараах тусгайлан заасан нэг, эсхүл хэд хэдэн үйл ажиллагаа эрхлэхийг Дарга зөвшөөрсөн этгээд, эсхүл байгууллагыг зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллага гэж ойлгоно:

(1) зайнаас удирддаг агаарын хөлгийн үйл ажиллагааны нисгэгчийн мэргэшил олгох; эсхүл

(2) зайнаас удирддаг агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчид зааварчилгаа өгөх этгээдийг томилох; эсхүл

(3) NOTAM гаргахад зориулан, зайнаас удирддаг агаарын

хөлгийн үйл ажиллагааны талаар НМҮБ-д мэдээлэх этгээдэд эрх олгох;
эсхүл

(4) 15 кг-аас дээш жинтэй, зайнаас удирддаг агаарын хөлөг
үйлдвэрлэх, эсхүл модификаци хийх эрх олгох; эсхүл

(5) 15 кг-аас дээш жинтэй, зайнаас удирддаг агаарын хөлөг
үйлдвэрлэх ажиллагааг шалгах ба зөвшөөрөл олгох; эсхүл

(6) 15 кг-аас дээш жинтэй, зайнаас удирддаг агаарын хөлгийн
үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох.

101.203. Утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар

(а) Аливаа этгээд нь 30 м-ээс урт нэг, эсхүл хэд хэдэн утсан
удирдлагын системтэй агаарын хөлгийн загвараар үйл ажиллагаа
эрхлэхгүй.

101.205. Аэродром

(а) Аливаа этгээд нь зайнаас удирддаг агаарын хөлөг, эсхүл
чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвараар дараах аэродром дээр,
эсхүл түүнээс 4 км-ийн дотор үйл ажиллагаа эрхлэхгүй:

(1) хяналтгүй аэродромд, дараах заалтаас бусад тохиолдолд:

(i) тухайн үйл ажиллагаа нь аэродромын үйл ажиллагаа
эрхлэгчтэй хийсэн гэрээний дагуу хийгдэж байгаа бол;

(ii) чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загварын хувьд, тухайн
агаарын хөлгийг ашиглагдаж байгаа ХБЗ-ны салхины дагуу чиглэлд
хөөрөх бол;

(iii) зайнаас удирддаг агаарын хөлгийн хувьд:

(А) тухайн агаарын хөлгийг нислэгт байх үед нисгэгч нь дэргэдээ
ажиглагчтай байгаа бол;

(В) үйл ажиллагаа эрхлэгч нь Даргаас AGL 120 м (400 ft)-ээс дээш
өндөрт агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авснаас
бусад тохиолдолд AGL 120 м (400 ft)-ээс дээш өндөрт тухайн агаарын
хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй бол;

(2) хяналттай аэродромд, тухайн үйл ажиллагааг холбогдох
НХУ-ын нэгжээс авсан зөвшөөрлийн дагуу гүйцэтгэж байгаагаас бусад
тохиолдолд;

(3) аливаа аэродромд дараах заалтаас бусад тохиолдолд:

(i) тухайн этгээд нь:

(А) зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллагаас олгосон нисгэгчийн
эрх эзэмшигч, эсхүл эрх бүхий нисгэгчийн шууд хяналтад байгаа бол;
эсхүл

(В) зайнаас удирддаг агаарын хөлгийн үйл ажиллагааны
зааварчилгаа өгөхөөр зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллагаас
томилогдсон этгээдийн шууд хяналтад байгаа бол; эсхүл

(С) ИНД-61 Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл олгох, эсхүл ИНД-

149 Нисэх клубийн гэрчилгээжүүлэлт-ийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх, эсхүл гэрчилгээ эзэмшигч бол.

(b) Аливаа этгээд нь зайнаас удирддаг агаарын хөлөг, утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар, эсхүл чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвараар дараах үйл ажиллагаа эрхлэхгүй:

(1) аэродромын ашиглагдаж байгаа хөдөлгөөнт бүс дээр, эсхүл дээгүүр; эсхүл

(2) ашиглагдаж байгаа ХБЗ-ны талбай дээр, эсхүл дээгүүр.

(c) Энэ зүйлийн (a)-д заасан зохицуулалт нь дараах халхлагдсан үйл ажиллагаанд хамаарахгүй:

(1) тухайн аэродромын хил хязгаарын гадна;

(2) тухайн агаарын хөлгийн нислэгийг саатуулах боломжтой хаалтаар тухайн аэродромоос бодит байдлаар тусгаарлагдсан агаарын зайд.

(d) Энэ зүйлийн (a)(3) нь чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загварт хамаарахгүй.

101.207. Агаарын зай

(a) Зайнаас удирддаг агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь:

(1) ИНД-71-ийн дагуу аюултай бүсэд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаагаас бусад тохиолдолд дараах агаарын зайд хийгдэх үйл ажиллагаанаас зайлсхийх:

(i) тухайн агаарын зайд агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрөөгүй этгээдийн дээгүүр;

(ii) тухайн өмчийг ашиглаж байгаа этгээд, эсхүл өмчийн эзэмшигчээс урьдчилан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд тухайн өмчийн дээгүүр.

(2) агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа орчны агаарын зайд байгаа бусад агаарын хөлгийг тогтмол ажиглаж байх;

(3) энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд AGL 120 м (400 ft)-ээс дээш өндөрт агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй байх.

(b) Хэрэв зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллага нь зөвшөөрөгдсөн эрхийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа бол тухайн этгээд, эсхүл байгууллагаас энэ зүйлийн (a)-д заасан зайнаас удирддаг агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахыг шаардахгүй.

(c) Аэродромын хил хязгаараас 4 км-ээс хол зайд, AGL 120 м (400 ft)-ээс дээш өндөрт зайнаас удирддаг агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь тухайн үйл ажиллагааг ИНД-71-ийн дагуу тогтоосон G ангиллын агаарын зайд тогтмол гүйцэтгэж байгааг бататгах шаардлагатай бөгөөд дараах үүрэгтэй:

(1) ИНД-71-ийн дагуу тухайн зорилгоор тогтоосон аюултай бүс дотор үйл ажиллагаа эрхлэх; эсхүл

(2) зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллагаас эрх олгогдсон этгээд нь тухайн үйл ажиллагаа эхлэхээс 24-өөс доошгүй цагийн өмнө дараах мэдээллийг NOTAM гаргах зорилгоор НМҮБ-д мэдээлдэг болохыг бататгах:

(i) үйл ажиллагаа эрхлэгчийн нэр, хаяг, утасны дугаар;

(ii) тухайн төлөвлөж буй үйл ажиллагааны байршил;

(iii) тухайн төлөвлөж буй үйл ажиллагааг гүйцэтгэх өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;

(iv) тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаанд санал болгосон, AGL максимум өндөр.

101.209. Шууд харж удирдах үйл ажиллагаа

(a) Энэ зүйл нь дараах төрлийн агаарын хөлөгт хамаарна:

(1) зайнаас удирддаг агаарын хөлөг;

(2) чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар.

(b) Энэ зүйлд хамаарах дараах тохиолдолд аливаа этгээд нь агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй:

(1) агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэх орчны агаарын зайн аливаа хэсэг нь тухайн этгээдийн хараанаас саадаар халхлагдсан; эсхүл

(2) тухайн агаарын хөлгийг шууд харах этгээдийн хараа цаг агаараас шалтгаалж халхлагдсан.

(c) Энэ зүйлд хамаарах агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь дараах шаардлагыг байнга мөрдөх үүрэгтэй:

(1) тухайн агаарын хөлгийг шууд харах нөхцөлийг байнга хадгалах;

(2) тухайн агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа орчны агаарын зайг харах боломжтой байх;

(3) тухайн агаарын хөлгөөр, үүлний сууриас доогуур үйл ажиллагаа гүйцэтгэх.

(d) Шууд харах ажиглагч этгээд нь чиг шулуун шугамаар тод харахын тулд дараах төхөөрөмжийг ашиглаж болно:

(1) нүдний шил, контакт линз, эсхүл тэдгээртэй төстэй хэрэгсэл нь тухайн этгээдийн хэвийн бус харааг сайжруулах боловч хэвийн хараанаас илүү сайжруулах боломжгүй тохиолдолд электрон, механик, цахилгаан соронзон, оптик эсхүл электрон оптик хэрэглэл хэрэглэх; эсхүл

(2) өөр нэгэн этгээд дүрсийг дэлгэцээр харж удирдах систем ашиглаж, харин сургалтад хамрагдсан, мэдлэг чадвартай ажиглагч нь дараах үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж байгаа бол:

- (i) тухайн агаарын хөлгийг шууд харж байх;
- (ii) тухайн агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа орчны агаарын зайг харж хянах;
- (iii) тухайн агаарын хөлгийг удирдаж байгаа этгээдтэй шууд холбоотой байх.

101.211. Шөнийн үйл ажиллагаа

(а) Дараахаас бусад тохиолдолд аливаа этгээд нь зайнаас удирддаг агаарын хөлөг, эсхүл чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвараар шөнөөр үйл ажиллагаа эрхлэхгүй:

- (1) дотор орчинд; эсхүл
- (2) халхлагдсан үйл ажиллагаа.

101.213. Хөдөлгөөний давуу эрх

(а) Зайнаас удирддаг агаарын хөлөг, эсхүл утсан удирдлагатай агаарын хөлгийн загвараар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь тухайн агаарын хөлгийг удирдаж байгаа этгээд газар дээр болон нислэгт байгаа нисгэгчтэй агаарын хөлгүүдээс зайтай байж, зам тавьж өгч байгааг бататгах үүрэгтэй.

(b) Чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвараар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь агаарын хөлгийг хөөргөхөөс өмнө тухайн агаарын хөлгийн үйл ажиллагааны үед газар дээр болон нислэгт байгаа нисгэгчтэй агаарын хөлгөөс зайтай, саадгүй байхыг бататгах үүрэгтэй.

101.215. Агаарын хөлгийн жингийн хязгаар

(а) Аливаа этгээд нь нийт жин нь 25 кг-аас дээш жинтэй, зайнаас удирддаг агаарын хөлөг, утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар, эсхүл чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвараар үйл ажиллагаа эрхлэхгүй.

(b) Агаарын хөлөг болон тухайн агаарын хөлөгт хийсэн модификаци нь дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд аливаа этгээд нь нийт жин нь 15 - 25 кг хүртэл жинтэй, зайнаас удирддаг агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй:

(1) 101.202-т заасан зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллагын эрхийн хүрээнд үйлдвэрлэгдсэн, эсхүл үзлэг, шалгалт хийгдэж зөвшөөрөгдсөн байх;

(2) 101.202-т заасан зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллагын эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэдэг байх.

F Бүлэг - Жироглайдер болон парасэйл

101.251. Хамрах хүрээ

(а) Энэ бүлэг нь жироглайдер болон парасэйлийн үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.

101.253. Аэродром

(а) Дараахаас бусад тохиолдолд аливаа этгээд нь жироглайдер,

эсхүл парасэйлээр аэродром дээр, эсхүл аэродромын хил хязгаараас 4 км-ийн дотор үйл ажиллагаа эрхлэхгүй:

(1) жироглайдер, эсхүл парасэйл нь хяналтгүй аэродромд, дараах үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол:

(i) тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгчтэй хийсэн гэрээний дагуу;

(ii) AGL120 м (400 ft)-ээс дээшгүй өндөрт; эсхүл

(2) жироглайдер, эсхүл парасэйл нь хяналттай аэродромд, тухайн аэродромын НХҮ-ний нэгжээс авсан зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол.

(b) Аливаа этгээд нь жироглайдер, эсхүл парасэйлээр дараах үйл ажиллагаа эрхлэхгүй:

(1) аэродромын агаарын хөлгийн хөдөлгөөнт бүс дээр, эсхүл дээгүүр; эсхүл

(2) аэродромын ашиглагдаж байгаа ХБЗ, эсхүл ХБЗ-ны талбай дээр, эсхүл дээгүүр.

101.255. Агаарын зай

(a) AGL120 м (400 ft)-ээс дээш өндөрт жироглайдер, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд нь дараах шаардлагыг хангах үүрэгтэй:

(1) жироглайдер, эсхүл парасэйл нь аэродромын хил хязгаараас 4 км-ээс доошгүй хол зайд байгааг бататгах;

(2) ИНД-71-ийн дагуу тогтоосон G ангиллын агаарын зайд үйл ажиллагаа эрхлэх;

(3) тухайн үйл ажиллагаа эхлэхээс 24-өөс доошгүй цагийн өмнө дараах мэдээллийг НМҮБ-д хүргүүлэх:

(i) тухайн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр, хаяг, утасны дугаар;

(ii) тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;

(iii) тухайн жироглайдер, эсхүл парасэйлийн товч тайлбар (хэмжээ, давамгайлсан өнгийг багтаасан);

(iv) тухайн жироглайдер, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа гүйцэтгэх өндөр.

101.257. Цаг агаарын хязгаарлалт

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд жироглайдер, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд нь дараах шаардлагыг мөрдөх үүрэгтэй:

(1) үүлний доогуур, 120 м (400 ft)-ээс ойр үйл ажиллагаа эрхлэхгүй байх;

(2) үйл ажиллагааг, газрын хараа 5 км-ээс багагүй байх орчноор хязгаарлах.

(b) Энэ зүйлийн (a) хэсэг нь жироглайдер, эсхүл парасэйлийн халхлагдсан үйл ажиллагаанд хамаарахгүй.

101.259. Шөнийн үйл ажиллагаа

(a) Аливаа этгээд нь жироглайдер, эсхүл парасэйлээр шөнөөр үйл ажиллагаа эрхлэхгүй.

101.261. Нислэгт тэнцэх чадвар

(a) Жироглайдер, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь төхөөрөмжийг тухайн зориулалтад тохирч байгаа болон үйлдвэрлэгчийн зааварчилгааны дагуу нислэгт тэнцэх нөхцөлийг хангаж байгааг бататгах үүрэгтэй.

101.263. Аюулгүй байдлын төхөөрөмж

(a) Жироглайдер, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь жироглайдер, парасэйлээр тээвэрлэгдэж байгаа хүн бүр дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:

(1) усан дээгүүр нислэг үйлдэх үед, эсхүл халин нисэх зай нь усан дээр байхаар бол тохирсон хөвөх туслах хэрэгсэл өмссөн байх;

(2) хамгаалалтын хатуу дуулга өмссөн байх;

(3) тухайн жироглайдер, эсхүл парасэйлд даруулга бүсээр бэхлэгдсэн байх;

(4) парасэйлийн шүхрийн холбогч гогцооноос утас ороогч дамар хүртэл хэмжсэн, 180 м (600 ft)-ээс их уртасгасан чирэх татлагаар чирэгдэж хөөрөх парасэйлийн үйл ажиллагааны хувьд, хэрэв онцгой нөхцөл үүсвэл, парасэйлийн үйл ажиллагаа эрхлэгчтэй холбоо барих боломжтой төхөөрөмжтэй байх.

101.265. Нислэгийн өмнөх зааварчилгаа

(a) Жироглайдер, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь, зорчигч бүр дараах мэдээллийг агуулсан нислэгийн өмнөх зааварчилгааг нислэг бүрийн өмнө авдаг болохыг бататгах үүрэгтэй:

(1) тухайн нислэгийн шинж чанар;

(2) тухайн нислэгийн хэвийн үйл ажиллагааны журам;

(3) дараах шаардлагыг багтаасан онцгой нөхцөлийн журам:

(i) ослын төхөөрөмжийн байрлал болон түүнийг хэрэглэх;

(ii) усанд буулт үйлдсэн, эсхүл чирэх татлага тасарсан үед мөрдөх журам;

(iii) онцгой нөхцөл үүссэн үед, жироглайдер, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа эрхлэгчтэй холбоо барих арга.

101.267. Онцгой нөхцөлийн үед чирэх татлагыг салгах

(a) Онцгой нөхцөлөөс бусад тохиолдолд аливаа этгээд нь нислэгт жироглайдер, эсхүл парасэйлийн чирэх татлагыг салгахгүй байх үүрэгтэй.

101.269. Үйл ажиллагааны журам

(а) Жироглайдер, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь үйлдвэрлэгчийн зөвлөсөн үйл ажиллагааны журам болон хязгаарлалтыг мөрдөх үүрэгтэй.

101.271. Салхины хурд

(а) Парасэйлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь дараах үүрэгтэй:

(1) парасэйлээр үйл ажиллагаа гүйцэтгэж байх үед тухайн байршлын салхины хурдыг нарийн тогтоох болон хянах төхөөрөмж, эсхүл аргыг ашиглах;

(2) салхины тогтвортой хурд нь 10 м/с (20 knot)-ээс их нөхцөлд парасэйлээр үйл ажиллагаа эрхлэхгүй байх.

101.273. Зорчигчийн насны хязгаарлалт

(а) Парасэйлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь дараах үйл ажиллагаа эрхлэхгүй:

(1) 8-аас 11 настай зорчигчийг дангаар тээвэрлэх үед парасэйл шүхрийн холбогч гогцооноос утас ороогч дамар хүртэл хэмжсэн, 90 м (300 ft)-ээс илүү уртасгасан чирэх татлага ашиглах;

(2) хэрэв онцгой нөхцөл үүсвэл, бага насны зорчигчид туслалцаа үзүүлэх чадвартай 18 болон түүнээс дээш настай өөр зорчигч дагалдахаас бусад тохиолдолд 8-аас доош насны зорчигчийг парасэйлээр тээвэрлэх.

*Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн
А/258 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

ИНД - 103 Хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагаа

А Бүлэг - Ерөнхий зүйл

103.1. Зорилго

(а) Энэ дүрмээр дараах харилцааг зохицуулна:

(1) ИНД-91 Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм (цаашид “ИНД-91” гэх)-ийн шаардлагаас гадна хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагаа;

(2) ИНД-91-д үл хамаарах хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагаа;

(3) хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар (цаашид “НТЧ” гэх)-ын болон техник үйлчилгээ.

103.3. Нэр томьёо ба товчлол

(а) Энэ дүрэмд хэрэглэх нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбарт тусгасан.

103.5. Нисгэгчид тавигдах шаардлага

(а) Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчийн үүрэг гүйцэтгэх этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) хэт хөнгөн агаарын хөлгийн зохих маягийн зэрэглэлтэй нисгэгчийн хүчинтэй гэрчилгээ эзэмшсэн; эсхүл

(2) ИНД-61 Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл (цаашид “ИНД-61” гэх)-ийн дагуу зохих маягийн зэрэглэлтэй нисгэгчийн хүчинтэй үнэмлэх эзэмшсэн; эсхүл

(3) 103.7-ийн шаардлагыг хангасан хэт хөнгөн агаарын хөлгийн сургагч нисгэгчийн гэрчилгээ эзэмшигчийн шууд хяналтад үйл ажиллагаа эрхэлдэг бол;

(4) хүчинтэй эрүүл мэндийн гэрчилгээ эзэмшсэн.

(b) Нисгэгч нь гэрчилгээ, үнэмлэх, эрүүл мэндийн гэрчилгээ болон холбогдох маягийн зэрэглэлээр олгогдох эрх, хязгаарлалтыг дагаж мөрдөнө.

103.6. [Хүчингүй болгосон]

103.7. Нислэгийн зааварчилгаа

(а) Ашиглаж буй тухайн хэт хөнгөн агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшсэн, зохих сургалтад хамрагдаж эрх авсан аливаа этгээд нь дараах шаардлагыг хангаагүй тохиолдолд хэт хөнгөн агаарын хөлгийн сургагч нисгэгчийн эрхийг хэрэгжүүлэхгүй:

(1) тухайн этгээд нь:

(i) хэт хөнгөн агаарын хөлгийн сургагч нисгэгчийн гэрчилгээ

ЭЗЭМШСЭН;

(ii) тухайн үйл ажиллагааг удирдаж байгаа хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллагын Ерөнхий зааварт заасан шаардлагыг хангасан байх; эсхүл

(2) тухайн этгээд нь:

(i) ИНД-61-ийн дагуу олгосон багш нисгэгчийн зэрэглэл эзэмшсэн;

(ii) хэт хөнгөн агаарын хөлгийг жолоодох ур чадварыг 103.7 (а) (1)-т заасан хэт хөнгөн агаарын хөлгийн сургагч нисгэгчид шалгуулсан байх.

103.9. Нислэгийн радио холбооны операторын шаардлага

(а) ИНД-61-ийн 61.153(а)(6)(vi)-д заасны дагуу нислэгийн радио холбооны бичгийн шалгалтад тэнцэж эрх авснаас бусад тохиолдолд хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь нисэхийн радио холбооны дамжуулагч хүлээн авагч ашиглахгүй.

В Бүлэг - [Нөөц]

С Бүлэг - [Нөөц]

Д Бүлэг - [Нөөц]

Е Бүлэг - Үйл ажиллагааны дүрэм

103.101. Бүртгэл

(а) Хэт хөнгөн агаарын хөлөгт ИНД-47 Агаарын хөлгийн бүртгэл (цаашид “ИНД-47” гэх)-ийн дагуу бүртгэлийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн агаарын хөлөг дараах шаардлагыг хангаж байгааг нотлох баримтыг Даргад хүргүүлнэ:

(1) хэт хөнгөн агаарын хөлгийн хувьд, Даргын хүлээн зөвшөөрөхүйц бага үндсэн үзүүлэлттэй болон төвлөрөлтийн хялбар параметртэй байх; эсхүл

(2) 103.207(а)(1)(ii)-т заасан маягийн загварын стандартад нийцэж байх.

(b) Бүртгэлд зөвшөөрөгдсөн хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн агаарын хөлөг энэ хэсгийн (а)-ийн шаардлагыг байнга хангаж байгааг бататгах үүрэгтэй.

103.103. Агаарын хөлгийн нислэгийн заавар

(а) ИНД-91-ийн 91.109-ийн шаардлага нь хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй.

103.105. Бүхээгт авч явах баримт бичиг

(а) ИНД-91-ийн 91.111-ийн шаардлага нь хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй.

(b) Энэ дүрмийн 103.203(b)-д заасан нислэгийн зөвшөөрлийг тухайн агаарын хөлөгт авч явахаас бусад тохиолдолд аливаа этгээд Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлөг, эсхүл Ангилал-1 хэт хөнгөн нисдэг

тэргээр үйл ажиллагаа эрхлэхгүй.

103.107. Зурагт хуудас (Placards)

(а) Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь дараах мэдээллийг харуулсан, ойлгоход хялбар зурагт хуудсыг нисгэгчид ил харагдахаар байрлуулсан болохыг бататгана:

(1) гэрчилгээжсэн, эсхүл загварын нийт жингийн аль багыг;

(2) тухайн агаарын хөлгийн төлбөрт ачааллын максимум болон минимум хэмжээг.

(b) Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь дараах мэдээллийг агуулсан ойлгоход хялбар зурагт хуудсыг сууж байгаа зорчигчид ил харагдахаар байрлуулсан болохыг бататгана:

(1) зурагт хуудас нь “зорчигчид анхааруулах нь” гэсэн зөвлөсөн гарчигтай;

(2) тухайн агаарын хөлөгт НТЧ-ын гэрчилгээ шаардлагагүй болохыг мэдэгдсэн.

Ү Бүлэг - Нислэгийн дүрэм

103.151. Түлшний шаардлага

(а) ИНД-91-ийн 91.305-д заасан шаардлага нь хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчид хамаарахгүй.

103.153. Минимум өндөр

(а) ИНД-91-ийн 91.311-т заасныг үл харгалзан, хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч нь газрын түвшнээс дээш (цаашид “AGL” гэх) 150 м (500 ft)-ээс доош өндөрт дараах зорилгоор нислэг үйлдэж болно:

(1) хэт хөнгөн жиропланы аэродромын хайрцаг нислэгийн сургалтыг AGL 60 м (200 ft)-ээс доош өндөрт хийгээгүй бол;

(2) хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн тэмцээний дадлага хийх болон түүнд оролцох дараах үйл ажиллагаа нь:

(i) хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллагын зөвшөөрөл болон тодорхой ойлголт, мэдлэгийн дагуу явагдаж байгаа бол;

(ii) хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллагаас тогтоосон нөхцөлийн дагуу зохион байгуулагдаж байгаа бол;

(iii) AGL 60 м (200 ft)-ээс доош өндөрт үйлдэгдээгүй бол.

103.155. Нислэгийн шалгуур

(а) Нисгэгч нь зөвхөн дараах нөхцөлд хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлнэ:

(1) Өдрийн гэрэлтэй цагаар;

(2) ИНД-91-ийн 91.301-т заасантай ижил, эсхүл илүү сайн VFR-ийн цаг уурын минимад.

(b) Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч нь дараах нөхцөлд үйл ажиллагаа эрхлэхгүй:

(1) хот, сум, эсхүл суурингийн шигүү суурьшлын бүс дээгүүр;

эсхүл

(2) хяналттай агаарын зайд, эсхүл ИНД-139 Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт (цаашид “ИНД-139” гэх)-ийн дагуу гэрчилгээжсэн аэродромоос 5.5 км (3 NM)-ийн зайд дараах зааснаас бусад тохиолдолд:

(i) тухайн нисгэгч нь ИНД-61-ийн 61.153(a)(6)(i)-д заасан нисэхийн хууль дүрмийн, эсхүл түүнтэй дүйцэх шалгалт өгч тэнцсэн байх; эсхүл

(ii) тухайн нисгэгч нь энэ хэсгийн (b)(2)(i)-т заасан шаардлагыг хангасан хэт хөнгөн агаарын хөлгийн сургагч нисгэгчийн гэрчилгээ эзэмшигчийн шууд хяналтад байх.

(c) Дараах заалтаас бусад тохиолдолд нисгэгч нь энэ хэсгийн (b)(2)(ii)-ын дагуу үйл ажиллагаанд оролцохгүй бөгөөд хянаж байгаа сургагч нисгэгч нь тухайн үйл ажиллагааг зөвшөөрөхгүй байх үүрэгтэй:

(1) тухайн сургагч нисгэгч нь агаарын хөлөг үйл ажиллагаа эрхлэх холбогдох агаарын зайд хамаарах Иргэний нисэхийн дүрэм (цаашид “ИНД” гэх)-ийг мөрдөх талаар нисгэгчид бүрэн зааварчилгаа өгсөн байх;

(2) нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (цаашид “НХҮ” гэх)-ний нэгжээс тухайн үйл ажиллагааны нислэгийн өмнөх зааварчилгаа авсан байх.

103.157. Ханг глайдер чирэх

(a) Нислэгт ханг глайдер чирэх хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч нь хэт хөнгөн агаарын хөлгийн ахлах нисгэгчээс (advanced) доошгүй нисгэгчийн гэрчилгээ, эсхүл ИНД-61-ийн дагуу олгосон үнэмлэх болон хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллагаас олгосон ур чадварын мэдэгдэл хэлбэрээр нисгэгчийн дэвтэрт тэмдэглүүлсэн ханг глайдер чирэх зэрэглэл эзэмшсэн байна.

(b) Хэт хөнгөн агаарын хөлгийн ахлах нисгэгчийн (advanced) гэрчилгээ эзэмшигч, эсхүл ИНД-61-ийн дагуу олгосон үнэмлэхтэй нисгэгч нь дараах шаардлагыг хангасан бол хэт хөнгөн агаарын хөлөг чирэх зэрэглэл авах эрхтэй:

(1) 100-аас доошгүй цагийн нислэгийн туршлагатай байх ба үүнээс:

(i) 80-аас доошгүй цагт нь хэт хөнгөн агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн;

(ii) 20-оос доошгүй цагт нь ашиглаж байгаа маягийн хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн;

(2) ханг глайдерын байгууллагын хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд Даргын шилжүүлсэн эрх эзэмшигчийн олгосон ханг глайдерын сургагч нисгэгчийн гэрчилгээ эзэмшигчээс ханг глайдер

чирэх үеийн онцгой нөхцөл болон журмын талаар зааварчилгаа авсан байх;

(3) хэт хөнгөн агаарын хөлгийн сургагч нисгэгчийн гэрчилгээ эзэмшигчээс хэт хөнгөн агаарын хөлөг чирэх онцгой нөхцөл, журмын талаар зааварчилгаа авсан байх.

(с) Дараах заалтаас бусад тохиолдолд хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч нь нислэгт ханг глайдер чирэхгүй:

(1) чирж байгаа агаарын хөлгийн тухайн маяг нь чирэгдэж байгаа ханг глайдерын үзүүлэлтэд заасан, агаарт чирэгдэн нисэх зөвшөөрөгдөхүйц максимум хурднаас бага хурданд удирдлагатай нислэг үйлдэх чадвартай байх;

(2) чирч байгаа агаарын хөлөг нь 103.223-т заасан төхөөрөмжийн шаардлага хангадаг байх;

(3) хоёр агаарын хөлгийн холбоосыг салгах механизмын ажиллагаатай байдлыг, тухайн өдрийн эхний нислэгийн өмнө шалгасан байх.

103.159. Зорчигч тээвэрлэх

(а) Дараах заалтаас бусад тохиолдолд нисгэгч нь хэт хөнгөн агаарын хөлөгт бусад этгээдийг тээвэрлэхгүй:

(1) хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллага тухайн нисгэгчид зорчигч тээвэрлэх эрх олгосон; эсхүл

(2) тухайн агаарын хөлөг нь ИНД-115 Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт (цаашид “ИНД-115” гэх)-ийн дагуу Даргаас олгосон Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээгээр олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэх;

(3) тухайн агаарын хөлөг нь Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлөг байх;

(4) тухайн агаарын хөлөг нь 103.213-ын дагуу холбогдох техник үйлчилгээний бүртгэлд бичилт хийж оруулсан НТЧ-ын мэдэгдэлтэй байх.

Г Бүлэг - НТЧ болон техник үйлчилгээ

103.201. Тодорхойлолт

(а) Энэ бүлгийн Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлөгт, Ангилал-1 хэт хөнгөн нисдэг тэрэг багтана.

103.203. Нислэгийн зөвшөөрлийн шаардлага

(а) ИНД-91-ийн 91.101(а)(1)(i)-д заасан шаардлага нь хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй.

(b) Энэ дүрмийн дагуу олгосон нислэгийн зөвшөөрөл, эсхүл нислэгийн түр зөвшөөрөл нь тухайн агаарын хөлөгт хүчинтэй байхаас бусад тохиолдолд аливаа этгээд нь Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй.

103.205. Нислэгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргах

(а) Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлөгт нислэгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь 103.207-д заасан мэдээллийг зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлнэ.

103.207. Нислэгийн зөвшөөрөл олгох

(а) Дарга дараах тохиолдолд Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн зөвшөөрөл олгож болно:

(1) хэрэв нислэгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь дараах нотлох баримтыг хүргүүлсэн бол:

(i) Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын Хэлэлцэн тохиролцогч Улсын холбогдох эрх бүхий байгууллагаас тухайн маягт олгосон хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн зөвшөөрөл, эсхүл түүнтэй дүйцэх Даргын хүлээн зөвшөөрөхүйц баримт бичиг; эсхүл

(ii) тухайн агаарын хөлгийн маягийн загвар нь дараах аль нэг стандартыг хангаж байгааг:

(А) Их Британи Улсын Иргэний нисэхийн байгууллага (UKCAA)-аас гаргасан НТЧ-ын шаардлага, Хэсэг S (1983 оны 03 дугаар сарын CAP 482 болон түүний 1988 оны 10 дугаар сарын өөрчлөлт);

(В) Австрали Улсын Иргэний нисэхийн аюулгүй байдлын газар (CASA)-аас гаргасан 95.32 (1990 оны 02 дугаар сарын 28-ны Хэвлэл 1 ба 1990 оны 08 дугаар сарын 01-ний 57 дугаар нэмэлт, өөрчлөлт) болон 101.55 (1988 оны 01 дүгээр сарын 07-ны Хэвлэл 1 ба 1991 оны 08 дугаар сарын 28-ны 90 дүгээр нэмэлт, өөрчлөлт) тушаал;

(С) Канад Улсын Тээврийн яамнаас гаргасан TP10141E баримт;

(D) Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад дүйцэх стандарт; эсхүл

(iii) тухайн маягийн 6, эсхүл түүнээс дээш агаарын хөлөг ашиглаж байгаа ба тэдгээр нь нийт 150-аас доошгүй цагийн нислэг, үүнээс нэг агаарын хөлөг нь 50-аас доошгүй цагийн нислэг үйлдэхдээ НТЧ-ын түүх нь шаардлага хангасан түвшинд хүрснийг нотлох баримт; эсхүл

(iv) тухайн агаарын хөлөгт энэ зүйлийн (b)-ийн дагуу нислэгийн түр зөвшөөрөл олгосон ба 103.211-т заасны дагуу ашиглалтын хугацаа тогтоох тестийг амжилттай хийсэн тухай баримт бичиг;

(2) хүсэлт гаргагч нь дараах баримт бичиг хүргүүлсэн бол:

(i) тухайн агаарын хөлөг нь ИНД-47, ИНД-91 болон ИНД-103-ийн дагуу холбогдох бүх шаардлагыг хангаж байгааг хангалттай нотлох баримт;

(ii) тухайн агаарын хөлгийн өмнөх нислэгийн зөвшөөрөл, эсхүл түүнтэй дүйцэх баримт бичиг олгосноос хойш ниссэн цаг болон нийт нислэгийн цагийн мэдэгдэл;

(iii) хэт хөнгөн агаарын хөлөг, эсхүл түүний хөдөлгүүр, эсхүл

хөдөлгүүрийн бүрдэл хэсэгт үйлдвэрлэгчийн заавал хийх шаардлагатай гэж үзсэн үзлэг шалгалт, эд ангийн солилт, их засвар, эсхүл бусад техник үйлчилгээг хийсэн тухай мэдэгдэл;

(3) агаарын хөлөгт Даргаас эрх олгосон этгээд үзлэг шалгалт хийж, ИНД-91-ийн 91.617-д заасан холбогдох техник үйлчилгээний бүртгэлд тухайн агаарын хөлөг нь загварын аюултай хэв шинжгүй болохыг баталгаажуулсан бол.

(b) Дарга Монгол Улсад зохион бүтээж, үйлдвэрлэсэн Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгийн эх загвар нь энэ зүйлийн (a)(1)(i), (ii), эсхүл (iii)-ын шаардлагыг хангаагүй боловч хэрэв тухайн агаарын хөлгийн эх загвар НТЧ-ын холбогдох шаардлагын дагуу далавчны статик ачааллын болон дугуйн дээр унагаах туршилт тестэд тэнцсэн бол тухайн хэт хөнгөн агаарын хөлөгт нислэгийн түр зөвшөөрөл олгож болно.

(c) Энэ зүйлийн (b)-ийн дагуу олгосон хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн түр зөвшөөрөл нь дараах шаардлагыг хангасан байх шаардлагатай. Үүнд:

(1) нисэхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Дарга шаардлагатай гэж үзсэн үйл ажиллагааны хязгаарлалтыг агуулсан байх;

(2) 6 сараас дээш хугацаагаар олгохгүй байх.

(d) Хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн түр зөвшөөрлөөр олгогдох эрхийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгч нь нислэгийн түр зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны хязгаарлалтыг мөрдөх үүрэгтэй.

(e) Хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн зөвшөөрөл нь түүний хугацаа дуусах, эсхүл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй байна.

103.209. Модификаци

(a) Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлөгт түүний НТЧ-т нөлөөлж болох хэлбэрээр модификаци хийсэн бол тухайн үйл ажиллагаа эрхлэгч нь дараагийн нислэг үйлдэхээс өмнө 103.207-д заасан шаардлагыг хангах зорилгоор тухайн агаарын хөлөгт дахин үзлэг шалгалт хийж, үнэлгээ хийсэн болохыг бататгах үүрэгтэй.

103.211. Ашиглалтын тест хийх

(a) Хэт хөнгөн агаарын хөлгийн ашиглалтын тест нь дараах нислэгээс бүрдэнэ:

(1) зургийн дагуу, бэлдэц материалаар бүтээсэн агаарын хөлгийн хувьд 40 цагийн нислэг; эсхүл

(2) бэлдэц материалын иж бүрдэл (kitset) бэлдцээр бүтээсэн хэд хэдэн агаарын хөлгийн хувьд 25 цагийн нислэг; эсхүл

(3) урьдчилан бэлдсэн бүрдэл хэсгийн иж бүрдэл (kitset)

бэлдцээр бүтээсэн хэд хэдэн агаарын хөлгийн хувьд 10 цагийн нислэг; эсхүл

(4) бүхэлдээ, зөвхөн урьдчилан үйлдвэрлэсэн үйлдвэрийн бүрдэл хэсэг болон угсарсан иж бүрдлээр бүтээсэн хэд хэдэн агаарын хөлгийн хувьд 2 цагийн нислэг.

(b) Модификаци хийсний дараа, эсхүл эвдрэл, гэмтэл гарсны дараа ашиглалтын тестийг дахин эхлүүлнэ.

103.213. НТЧ-ын мэдэгдэл

(a) Энэ дүрмийн 103.211-ийн дагуу ашиглалтын тест хийсэн хэт хөнгөн агаарын хөлгийн дарга нь ИНД-91-ийн 91.617-д заасан техник үйлчилгээний бүртгэлд дараах бичилтийг оруулах үүрэгтэй:

(1) тестийн үед гүйцэтгэсэн бүх маневрын дэлгэрэнгүйг, түүнийг гүйцэтгэсэн нислэгийн хурдны дэлгэрэнгүй мэдээллийн хамт;

(2) дараах мэдэгдлийн (гүйцэтгэсэн нислэгийн цагийг багтаасан) араас сүүлчийн тест хийсэн нисгэгчийн нэр, үнэмлэхийн дугаар, гарын үсэг болон огноог бичих:

Энэ агаарын хөлгөөр ИНД-103-ын шаардлагад нийцүүлэн цагийн нислэгийг амжилттай гүйцэтгэсэн ба тухайн агаарын хөлөг нь тохирсон техникийн үзүүлэлттэй бөгөөд хурдны боломжит хязгаарын хооронд удирдагдаж байгааг бүх маневрыг гүйцэтгэснээр тогтоосон бөгөөд НТЧ-тай болохыг Би баталж байна.

103.215. Нөөц

103.217. Техник үйлчилгээ болон үзлэг шалгалтын шаардлага

(a) Хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь дараах шаардлагыг бататгах үүрэгтэй:

(1) тухайн агаарын хөлөгт нислэгт тэнцэх нөхцөлийг хангасан техник үйлчилгээ хийсэн байх;

(2) ИНД-39 Нислэгт тэнцэх чадварын удирдамж (цаашид “ИНД-39” гэх)-д заасны дагуу холбогдох бүх НТЧ-ын удирдамжийг биелүүлсэн байх;

(3) шаардлагатай үзлэг шалгалтын хооронд бүх гэмтэл дутагдлыг зассан байх.

(b) Энэ дүрмийн 103.207(a)(1)-т заасан маягийн загварын стандартыг хангаж байгаа хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн агаарын хөлөг нь зохион бүтээгчийн, эсхүл иж бүрдэл үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний шаардлагын дагуу ашиглагдаж байгааг бататгах үүрэгтэй.

(c) Энэ зүйлийн (d) болон (g)-д заасныг харгалзан, дараах заалтаас бусад тохиолдолд аливаа этгээд нь хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл эрхлэхгүй:

(1) тухайн агаарын хөлгийн төлөв байдлын жилийн үзлэг

шалгалтыг өмнөх үргэлжилсэн 12 сарын дотор хийсэн байх;

(2) энэ зүйлийн (а)(2)-д заасан шаардлагыг хангасан байх;

(3) энэ зүйлийн (h)-т зааснаас бусад тохиолдолд дараах дүрмийн дагуу холбогдох тест болон үзлэг шалгалт хийгдсэн байх шаардлагыг хангасан байх:

(i) ИНД-91-ийн 91.605(е)(2)-т заасны дагуу хэрэв хэт хөнгөн агаарын хөлгийг ажиглалтын транспондероор тоноглосон бол өндрийн түвшний даралтыг автоматаар мэдээлэх системийн үзлэг шалгалт болон тестийн талаар;

(ii) ИНД-91-ийн 91.605(е)(3)-ын дагуу, хэрэв хэт хөнгөн агаарын хөлгийг ажиглалтын транспондероор тоноглосон бол;

(iii) ИНД-91-ийн 91.605(е)(8)-ын дагуу, хэрэв хэт хөнгөн агаарын хөлгийг хөвөгч төхөөрөмжөөр тоноглосон бол.

(d) Энэ зүйлийн (с)(1)-т заасан жилийн төлөв байдлын үзлэг шалгалт нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) дараах этгээд хийсэн байх:

(i) хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллагаас жилийн төлөв байдлын үзлэг шалгалт хийх эрх олгогдсон; эсхүл

(ii) Даргаас эрх олгосон; эсхүл

(iii) ИНД-66 Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл (цаашид “ИНД-66” гэх)-ийн дагуу олгосон агаарын хөлөг болон хөдөлгүүрийн бүлгийн зэрэглэлтэй агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн хүчинтэй үнэмлэх эзэмшдэг этгээд хийх; эсхүл

(iv) үзлэг шалгалт хийсэн эд зүйл, бүрдэл хэсгийн хувьд Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх.

(е) Энэ зүйлийн (с)(1)-т заасан жилийн төлөв байдлын үзлэг шалгалт хийж байгаа этгээд нь тухайн агаарын хөлгийг НТЧ-тай нөхцөлд байгааг тогтоосон тохиолдолд дараах үүрэгтэй:

(1) үзлэг шалгалтын маягтад тухайн агаарын хөлөг НТЧ-тай болохыг баталгаажуулах;

(2) энэ зүйлийн (е)(1)-т заасан үзлэг шалгалтын маягтыг тухайн агаарын хөлгийн орох хаалганы дэргэд, ил харагдахуйц хэсэгт хөдөлгөөнгүй байрлуулах;

(3) энэ зүйлийн (е)(1)-т заасан үзлэг шалгалтын маягтын хуулбарыг тухайн гэрчилгээжүүлэлтийн баримт бичгийн хэлбэрээр хадгалах;

(4) Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгийн хувьд, ИНД-91-ийн 91.617-д заасны дагуу техник үйлчилгээний бүртгэлд гэрчилгээжүүлэлтийн дэлгэрэнгүй мэдээллийн бичилтийг оруулах.

(f) Энэ зүйлийн (е)(1)-т заасан агаарын хөлгийн үзлэг шалгалтын

маягтад дараах мэдээллийг тусгах шаардлагатай:

(1) агаарын хөлгийн бүртгэлийн дугаар;

(2) агаарын хөлгийн маяг;

(3) жилийн төлөв байдлын дараагийн үзлэг шалгалт хийх, үлдсэн өдөр;

(4) жилийн төлөв байдлын үзлэг шалгалт хийсэн инженер, эсхүл шалгагчийн гарын үсэг, үнэмлэхийн дугаар, үзлэг хийсэн огноо.

(г) Хэрэв энэ зүйлийн (с)(1)-т заасан жилийн төлөв байдлын үзлэг шалгалтаар тухайн агаарын хөлгийг нислэгт тэнцэхгүй болохыг тогтоосон тохиолдолд агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь энэ зүйлийн (d), (е) болон (f)-д заасны дагуу дахин үзлэг шалгалт хийж, нислэгт тэнцэхийг баталгаажуулах хүртэл тухайн агаарын хөлгийг нисгэхийг зөвшөөрөхгүй.

103.219. Үйлдвэрлэл

(а) Хэрэв хэт хөнгөн агаарын хөлгийг дараах бэлдцээр бүтээж байгаа бол тухайн этгээдийг ИНД-148 Агаарын хөлөг үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээжүүлэлт (цаашид “ИНД-148” гэх)-ийн шаардлагыг дагаж мөрдөхийг шаардахгүй:

(1) зургийн дагуу, бэлдэц материалаар; эсхүл

(2) бэлдэц материалын иж бүрдлээр (kitset); эсхүл

(3) урьдчилан бэлдсэн бүрдэл хэсгийн иж бүрдлээр (kitset); эсхүл

(4) урьдчилан үйлдвэрлэсэн үйлдвэрийн бүрдэл хэсэг болон иж бүрдлээр.

103.221. Хэрэглэл болон төхөөрөмжийн шаардлага

(а) Энэ зүйлийн (b)-д заасныг харгалзан, хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн агаарын хөлгийг дараах байдлаар тоноглогсон байна:

(1) шаардлагатай хэрэглэл болон төхөөрөмж нь:

(i) тухайн агаарын хөлгийн маягийн загварт нийцсэн байх;

(ii) тухайн агаарын хөлгийн зохион бүтээгч, эсхүл иж бүрдэл үйлдвэрлэгчийнх байх.

(2) дараах мэдээллийг зааж үзүүлдэг байх:

(i) агаарын хурд;

(ii) өндрийн түвшнийг метрээр;

(iii) соронзон чиглэл.

(b) Моторт шүхрээр үйл ажиллагаа эрхлэгчийг, тухайн агаарын хөлгийг агаарын хурд заах хэрэглэлээр тоноглохыг шаардахгүй.

(с) ИНД-91-ийн F Бүлэгт заасан дараах шаардлага хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй:

(1) ИНД-91-ийн 91.509-д заасан минимум хэрэглэл болон

төхөөрөмжийн хувьд, ИНД-91-ийн 91.501(а)(1);

(2) ИНД-91-ийн Хавсралт А-ын А3-т заасан суудлын стандартын хувьд, ИНД-91-ийн 91.501(а)(2)(i).

103.223. Ханг глайдер чирэх агаарын хөлөг

(а) Хэт хөнгөн агаарын хөлгөөр нислэгт ханг глайдер чирэх үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь 103.221-д заасан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан болохыг бататгах үүрэгтэй:

(1) тухайн агаарын хөлгийг дараах хэрэгслээр тоноглосныг:

(i) чирч байгаа нисгэгчид ямар ч үед чирэх холбоосыг салгах боломжийг бүрдүүлэх, тухайн агаарын хөлгийн загвар хийцийн стандартад нийцсэн чирэх дэгээ болон бэхэлгээний иж бүрдлийг багтаасан чирэх хэрэгсэл;

(ii) ар талаа харах толь;

(iii) чирч байгаа онгоцны төгсгөлд 100 кг-аас ихгүй таслах хүчинд түрүүлж тасрах холбоосоор (weak link) тоноглосон чирэх татлага.

(2) тухайн ханг глайдерыг дээшээ 45° , доошоо 30° , хоёр тийш 30° өнцөгтэй конус дотор, чирэх татлагад 100 кг-аас дээш ачаалал үүсэхэд ханг глайдерын нисгэгч ажиллуулдаг, чирэх гогцооны арын үзүүрийг хялбар, найдвартай салгах үйлдэлтэй механизмаар тоноглосныг.

*Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн
А/258 дугаар тушаалын гуравдугаар хавсралт*

ИНД - 104 Глайдерын үйл ажиллагаа

А Бүлэг - Ерөнхий зүйл

104.1. Зорилго

(а) Энэ дүрмээр дараах харилцааг зохицуулна:

(1) ИНД-91 Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм (цаашид “ИНД-91” гэх)-д заасан глайдерын үйл ажиллагааны нэмэлт шаардлага;

(2) ИНД-43 Техник үйлчилгээний ерөнхий дүрэм (цаашид “ИНД-43” гэх)-д заасан глайдерын үйл ажиллагааны нэмэлт шаардлага;

(3) ИНД-91-д үл хамаарах глайдерын үйл ажиллагаа;

(4) ИНД-43-т үл хамаарах глайдерын техник үйлчилгээ.

104.2. Хамрах хүрээ

(а) Энэ дүрэм нь ханг глайдерт хамаарахгүй.

104.3. Нэр томьёо ба товчлол

(а) Энэ дүрэмд хэрэглэх нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбарт тусгасан.

104.5. Нисгэгчид тавигдах шаардлага

(а) Глайдерын нисгэгчийн үүрэг гүйцэтгэх этгээд нь:

(1) дараах үнэмлэх, гэрчилгээ эзэмшдэг байх:

(i) глайдерын нисгэгчийн хүчинтэй гэрчилгээ; эсхүл

(ii) ИНД-61 Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл (цаашид “ИНД-61” гэх)-ийн дагуу олгосон хүчинтэй хувийн нисгэгчийн үнэмлэх (глайдер); эсхүл

(iii) ИНД-61-ийн дагуу олгосон хүчинтэй коммерийн нисгэгчийн үнэмлэх (глайдер);

(2) дараах шаардлагыг хангасан байх:

(i) 18 нас хүрсэн байх; эсхүл

(ii) нислэг бүрд глайдерын А, эсхүл В категорийн сургагч нисгэгчээс тусгайлан зөвшөөрөл авсан байх;

(3) нисгэгчийн үнэмлэх эсхүл гэрчилгээ болон холбогдох зэрэглэлээр олгогдсон эрх, хязгаарлалтыг мөрдөх;

(4) глайдерын байгууллагын үйл ажиллагааны стандарт болон журмыг мөрдөх.

(b) Энэ зүйлийн (а)-д заасныг үл харгалзан, хэрэв тухайн этгээд нь глайдерын байгууллагаас олгосон сургагч нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийн шууд хяналтад глайдерын нисгэгчийн үүрэг гүйцэтгэх бол энэ зүйлийн (а)(1), (2) болон (3)-ыг дагаж мөрдөхгүй байж болно.

104.6. [хүчингүй болгосон]

104.7. Шалгах нислэг

(а) ИНД-91-ийн 91.101(с)(4)-т заасныг үл харгалзан, глайдерын нисгэгчийн хүчинтэй гэрчилгээ болон зохих маягийн зэрэглэл эзэмшигч нь 91.101(с)-д заасны дагуу глайдерт Нислэгт тэнцэх чадвар (цаашид “НТЧ” гэх)-ын гэрчилгээ олгох, шинэчлэх эсхүл сэргээх шаардлагыг хангаж байгааг үзүүлэх зорилгоор үйлдэх шалгах нислэгт агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэж болно.

(b) ИНД-91-ийн 91.613(a)(1)-д заасныг үл харгалзан, глайдерын нисгэгчийн гэрчилгээ болон зохих маягийн зэрэглэл эзэмшигч нь, хэрэв тухайн глайдерын үйл ажиллагааны шалгах нислэг хийх шаардлагатай бол 91.613-ын дагуу глайдерын үйл ажиллагааны шалгах нислэг үйлдэж болно.

104.9. Нислэгийн заавар

(а) ИНД-91-ийн 91.111(a)(2)-т заасныг үл харгалзан, дараах тохиолдолд, аливаа этгээд нь нислэгийн зааврыг авч явахгүйгээр глайдераар үйл ажиллагаа эрхэлж болно. Хэрэв:

(1) тухайн нислэгийн зааврыг нислэгийн урьдчилсан төлөвлөлтийн явцад нисгэгч хэрэглэх боломжтой бол;

(2) бүхээгийн мэдээлэл (decal) нь тухайн глайдерын үйл ажиллагааг аюулгүй гүйцэтгэхэд нисгэгчид хэрэгтэй эшлэл болж чадах бол.

104.11. Дуураймал хэрэглэлийн нислэг

(а) ИНД-91-ийн 91.125(a)(1)-д заасныг үл харгалзан, глайдерын нисгэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дуураймал хэрэглэлийн нислэг үйлдэх зорилгоор глайдерт аюулгүй байдлын нисгэгчийн үүрэг гүйцэтгэж болно.

104.13. Газрын дохио

(а) Хэрэв глайдерын нислэгийн үйл ажиллагаа хийгдэж байгааг газрын дохио ашиглан үзүүлж байгаа бол тухайн газрын дохио нь хөөрөлт болон буулт үйлдэх чиглэлийг заасан цагаан өнгийн сумнаас бүрдэнэ.

В Бүлэг - Нислэгийн дүрэм

104.51. Хөдөлгөөний давуу эрхийн дүрэм

(а) ИНД-91-ийн 91.229(b)-д заасныг үл харгалзан, өндрөөс халин нисэж (soaring ridge) байгаа глайдерын нисгэгчийг, тухайн глайдерын баруун гар талд өндөрлөг байгаа бол түүний эгц урдаас өөр глайдер ойртох үед баруун тийш эргэхийг шаардахгүй.

(b) ИНД-91-ийн 91.229(d)-д заасныг үл харгалзан, өндрөөс халин нисэж байгаа глайдерыг гүйцэж түрүүлэх глайдерын нисгэгч нь гүйцэгдэж байгаа глайдерыг өндөрлөгтэй талаар нь гүйцэж түрүүлнэ.

(с) ИНД-91-ийн 91.229(f)-д заасныг үл харгалзан, хоёр глайдер төгсгөлийн буултын ойртолт үйлдэж байгаа тохиолдолд, илүү үзүүлэлттэй глайдерын нисгэгч нь бага үзүүлэлттэй глайдерт зам тавьж өгнө.

104.53. Хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөл

(а) ИНД-91-ийн 91.301-д заасныг үл харгалзан, тухайн глайдерын нисгэгч нь, хэрэв тухайн нислэгийг дараах нөхцөлд үйлдэж байгаа бол Хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөл (цаашид “IMC” гэх)-д, ИНД-91-ийн F Бүлгийн шаардлагыг мөрдөхгүй нисэж болно:

(1) үүлэн дотор нислэг үйлдэхээр тогтоосон хязгаарлалттай бүсэд; эсхүл

(2) ИНД-71 Агаарын зайг тогтоох болон ангиллах (цаашид “ИНД-71” гэх)-ийн дагуу тогтоосон G ангиллын агаарын зайд, үүлэн дотор нислэг үйлдэхээр санал болгосон бүсэд, эсхүл түүний ойролцоо мэдэгдэж байгаа Хэрэглэлийн нислэгийн дүрэм (цаашид “IFR” гэх)-ийн хөдөлгөөн байхгүй болохыг тухайн нисгэгч зохих НХҮ-ний нэгжээс 15 минутаас ихгүй үечлэлтэй мэдээлэл авч баталгаажуулдаг бол.

104.55. Үүлнээс зай барих

(а) ИНД-91-ийн 91.301(a)(2)-т заасныг үл харгалзан, 900 м (3,000 ft)-ээс дээш өндрийн түвшинд болон 300 м (1,000 ft)-ээс дээш өндөрт, гэхдээ 3,300 м (11,000 ft)-ээс доош өндрийн түвшинд нисэж байгаа глайдерын нисгэгч нь E, эсхүл G Ангиллын агаарын зайд үүлэн доогуур, түүнээс 150 м (500 ft)-ээс ойрхон нисэхгүй.

104.57. Түлшний шаардлага

(а) ИНД-91-ийн 91.305(a)-ийн шаардлага нь глайдерын нисгэгчид хамаарахгүй.

104.59. Минимум өндөр

(а) ИНД-91-ийн 91.311(a)(2)-т заасныг үл харгалзан, глайдерын нисгэгч нь тухайн гадаргуугаас 150 м (500 ft)-ээс нам өндөрт, дараах заасан нөхцөлд үйл ажиллагаа гүйцэтгэж болно:

(1) өндрөөс халин нисэх нислэгийн (ridge soaring) хувьд, хэрэв газарт байгаа хүн, эсхүл өмч хөрөнгөд аюул учруулахааргүй бол; эсхүл

(2) хэрэв глайдерын сургагч нисгэгч нь татгалзсан хөөргөлтийн сургалт дадлага зохион байгуулж байгаа бол.

104.61. Ил харааны нислэгийн дүрэм (VFR)-ийн аяллын өндрийн түвшин болон нислэгийн түвшин

(а) ИНД-91-ийн 91.313-д заасныг үл харгалзан, глайдерын нисгэгчээс тухайн аяллын өндрийн түвшний, эсхүл нислэгийн түвшний соронзон чиглэлийг барихыг шаардахгүй.

С Бүлэг - Төхөөрөмж болон техник үйлчилгээний шаардлага

104.101. Агаарын хөлгийн төхөөрөмж

(а) Дараах төхөөрөмж болон ажиллагаатай хэрэглэлээр тоноглогдсоноос бусад тохиолдолд аливаа этгээд нь глайдераар үйл ажиллагаа эрхлэхгүй:

- (1) агаарын хурд заагч;
- (2) барометрийн даралтын тохируулгатай, даралтаар мэдрэх алтиметр;
- (3) соронзон луужин;
- (4) суудал бүрд аюулгүй байдлын бэхэлгээ;
- (5) анхны тусламжийн иж бүрдэл;
- (6) моторт глайдерын хувьд:
 - (i) түлшний үндсэн сав бүрд хэмжүүр;
 - (ii) хоёр тактын хөдөлгүүрээс бусад хөдөлгүүрийн хувьд, тосны даралт хэмжигч, эсхүл анхааруулах дохионы хэрэгсэл;
 - (iii) тахометр, эргэлтийн хурд заагч, эсхүл хөдөлгүүр бүрд эргэлт мэдрэгч гэрэл;
- (7) IMC-д үйлдэх нислэгийн хувьд:
 - (i) босоо хурд хэмжигч (variometer);
 - (ii) эргэлт болон гулгалт заагч (turn-slip), эсхүл авиагоризонт (artificial horizon);
 - (iii) ИНД-91-ийн Хавсралт А-ийн А.9(с)-ийн шаардлагыг хангасан, зохих НХҮ-ний нэгжтэй холбоо барих чадвартай, нисэхийн радио холбооны дамжуулагч хүлээн авагч хэрэгсэлтэй байх.

104.103. Техник үйлчилгээний ерөнхий шаардлага

(а) Глайдерын үйл ажиллагаа эрхлэгч дараах шаардлагыг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн глайдерт нислэгт тэнцэх нөхцөлийг хангасан техник үйлчилгээ хийх;
- (2) ИНД-39 Нислэгт тэнцэх чадварын удирдамж (цаашид “ИНД-39” гэх)-д заасны дагуу холбогдох бүх НТЧ-ын удирдамжийг биелүүлэх;
- (3) тухайн глайдерт дараах үзлэг шалгалт хийсэн байх:
 - (i) энэ Бүлгийн шаардлагын дагуу;
 - (ii) ИНД-91-ийн G Бүлэгт заасан холбогдох шаардлагын дагуу;
- (4) үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний зааврын НТЧ-ын хязгаарлалтад заасан хатуу цагтай эд ангийг солих хугацаа, үзлэг шалгалтын үечлэл болон холбогдох журам, эсхүл тухайн глайдерт зориулан гаргасан НТЧ-ын хадгалалтын зааварчилгаа хэрэгжсэн байх;
- (5) шаардлагатай үзлэг шалгалтын хооронд гэмтэл дутагдлыг ИНД-43-ын дагуу засах.

104.105. Техник үйлчилгээний үзлэг шалгалт

(а) Глайдер нь өмнөх үргэлжилсэн 12 сарын хугацаанд дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд аливаа этгээд нь тухайн глайдераар үйл ажиллагаа эрхлэхгүй:

(1) 104.107-оор шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу үзлэг шалгалт хийгдсэн ба ИНД-43-ын дагуу ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлсэн байх; эсхүл

(2) ИНД-21 Бүтээгдэхүүн, эд ангийн гэрчилгээжүүлэлт (цаашид “ИНД-21” гэх)-ийн дагуу НТЧ-ын гэрчилгээ олгох үзлэг шалгалтад тэнцсэн байх.

104.107. Техник үйлчилгээний хөтөлбөр

(а) Глайдерын үйл ажиллагаа эрхлэгч нь хүчилсэн бүтэц, хөдөлгүүр эсхүл сэнс, бүрдэл хэсэг, авран хамгаалах болон ослын төхөөрөмж зэргийг багтаасан тухайн глайдерт ИНД-91-ийн G Бүлэгт заасан холбогдох шаардлага болон дараах баримт бичгийн дагуу техник үйлчилгээ хийх үүрэгтэй:

(1) үйлдвэрлэгчийн зөвлөсөн хүчинтэй техник үйлчилгээний хуваарь; эсхүл

(2) техник үйлчилгээний хөтөлбөр:

(i) 104.109-ийн дагуу глайдерын байгууллагаар зөвшөөрөгдсөн ба холбогдох журам нь тухайн глайдерын байгууллагын Ерөнхий зааварт тусгагдсан; эсхүл

(ii) 104.109-д заасны дагуу Даргын баталсан.

104.109. Техник үйлчилгээний хөтөлбөрийг батлах ба зөвшөөрөл олгох

(а) Энэ дүрмийн 104.107(2)-д заасан Техник үйлчилгээний хөтөлбөрийн хүрээнд глайдерт техник үйлчилгээ хийлгэх хүсэлтэй глайдерын үйл ажиллагаа эрхлэгч нь глайдерын байгууллагаас зөвшөөрөл авахаар, эсхүл Даргаар батлуулахаар тухайн хөтөлбөрийг бичгээр хүргүүлэх үүрэгтэй.

(b) Энэ дүрмийн 104.107(а)(2)-т заасан техник үйлчилгээний хөтөлбөр нь дараах мэдээллийг агуулсан байна:

(1) тухайн глайдерыг сургалтын үйл ажиллагаанд ашиглах эсэх тухай мэдэгдэл;

(2) тухайн хөтөлбөрт санал болгосон үзлэг шалгалтыг ашиглалтын хугацаагаар, хуанлийн хугацаагаар, эсхүл тэдгээрийн хосолсон хэлбэрээр хийх хуваарь;

(3) тухайн глайдерын хийц, загварт тохирсон шаардлагатай тест болон шалгалтыг багтаасан техник үйлчилгээг хийх зааварчилгаа болон журам. Тухайн зааварчилгаа болон журамд үзлэг шалгалт хийх шаардлагатай авран хамгаалах болон ослын төхөөрөмжийг багтаасан,

хүчилсэн бүтэц хөдөлгүүр, сэнс болон бүрдэл хэсгийн эд анги болон байрлалыг дэлгэрэнгүй заасан байна.

(с) Хэрэв глайдерын үйл ажиллагаа эрхлэгч нь энэ зүйлийн (а)-ийн дагуу зөвшөөрсөн, эсхүл баталсан Техник үйлчилгээний хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах бол тухайн үйл ажиллагаа эрхлэгч нь шинэ хөтөлбөрийн хүрээнд хийх үзлэг шалгалтын үлдэгдэл хугацааг тодорхойлохдоо, өмнөх хөтөлбөрийн хүрээнд хуримтлагдсан ашиглалтын хугацаа (time-in-service), эсхүл хуанлийн хугацааг тооцох үүрэгтэй.

(d) Хэрэв глайдерын байгууллага, эсхүл Дарга тухайн нэмэлт, өөрчлөлт нь уг хөтөлбөрийн үр дүнтэй байдлыг хадгалахад шаардлагатай болохыг тогтоосон бол, 104.107(2)-ын дагуу шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн хүрээнд глайдерт техник үйлчилгээ хийж байгаа глайдерын үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн хөтөлбөрийг зөвшөөрсөн глайдерын байгууллагын, эсхүл Даргын өгсөн зааварчилгааны дагуу хөтөлбөртөө нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэгтэй.

104.111. Нөөц

104.113. Техникийн бүртгэлийн дэвтэр

(а) Глайдерын үйл ажиллагаа эрхлэгч нь дараах мэдээллийг агуулсан, агаарын хөлгийн Техникийн бүртгэлийн дэвтэр (цаашид “TLB” гэх) хөтөлнө:

- (1) тухайн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр болон хаяг;
- (2) тухайн глайдерын ашиглалтад хэрэглэж байсан техник үйлчилгээний хөтөлбөрийг таньж тогтоох мэдээлэл;
- (3) дараагийн үзлэг шалгалтын үлдэгдэл цаг болон үзлэг шалгалт хийх огноог таньж тогтоох мэдээллийг багтаасан, тухайн глайдерын үзлэг шалгалтын нөхцөл байдлын мэдэгдэл;
- (4) сүүлчийн НТЧ-ын жилийн дүгнэлт хийсэн огноо;
- (5) өдөр тутмын ниссэн цагийг багтаасан ашиглалтын нийт цаг;
- (6) өдөр тутмын үзлэг хийсэн нисгэгчийн гарын үсэг;
- (7) угсралт хийсний дараах эхний болон хоёр дахь хяналтын үзлэг хийсэн этгээдийн гарын үсэг;
- (8) нислэгийн үед, эсхүл нислэгийн дараа нисгэгчийн илрүүлсэн гэмтэл;
- (9) хуваарьт үзлэг шалгалтын хооронд илэрсэн гэмтэл дутагдлыг зассан дэлгэрэнгүй мэдээлэл болон тухайн гэмтлийг арилгасны дараа ашиглалтад шилжүүлсэн гэрчилгээ;
- (10) ИНД-91-ийн 91.537-ийн дагуу ажиллагаагүй байж болохоор зөвшөөрөгдсөн төхөөрөмжийг багтаасан, хойшлуулсан дутагдлыг арилгах ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл.

(b) Үйл ажиллагаа эрхлэгч нь энэ зүйлийн (a)-д заасан мэдээллийг TLB-д бүртгэх ба тухайн мэдээлэл хүчинтэй болохыг бататгана, гэхдээ өдөр тутмын ниссэн цаг болон нийт ашиглалтын цагийг өдөр тутмын нислэгийн хуудсанд байнгын, арилдаггүй байдлаар тусад нь бичилт хийж оруулна.

104.115. Нисгэгчийн гүйцэтгэх техник үйлчилгээ

(a) ИНД-43-ийн 43.51(b)-д заасныг үл харгалзан, глайдерын нисгэгчийн хүчинтэй гэрчилгээ эзэмшдэг этгээд нь, хэрэв тухайн глайдерын өмчлөгч, эсхүл глайдерын үйл ажиллагаа эрхлэгч бол ИНД-43-ын Хавсралт А-ийн А.1 болон А.2-д заасан техник үйлчилгээг хийж болно.

(b) ИНД-43-ийн 43.101(a)(6)-д заасныг үл харгалзан, энэ зүйлийн (a)-д заасны дагуу глайдерт техник үйлчилгээ хийж байгаа этгээд нь техник үйлчилгээг хийсний дараа тухайн глайдерыг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлж болно.

*Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн
А/258 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт*

ИНД - 106 Ханг глайдерын үйл ажиллагаа

А Бүлэг - Ерөнхий зүйл

106.1. Зорилго

(а) Энэ дүрмээр дараах харилцааг зохицуулна:

(1) ИНД-91 Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм (цаашид "ИНД-91" гэх)-д заасан ханг глайдерын үйл ажиллагааны нэмэлт шаардлага;

(2) ИНД-91-д үл хамаарах ханг глайдерын үйл ажиллагааны шаардлага.

106.2. Хамрах хүрээ

(а) Параглайдерийн үйл ажиллагааг энэ дүрмээр зохицуулна.

(b) Параглайдер нь хатуу эд ангиас бүрдсэн үндсэн бүтэцгүй ханг глайдерын төрөлд хамаарна.

106.3. Нэр томьёо ба товчлол

(а) Энэ дүрэмд хэрэглэх нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбарт тусгасан.

106.5. Нисгэгчид тавигдах шаардлага

(а) Ханг глайдерын нисгэгчийн үүрэг гүйцэтгэх этгээд нь:

(1) ханг глайдерын байгууллагын жинхэнэ гишүүн байх;

(2) ханг глайдерын нисгэгчийн зохих гэрчилгээ эзэмшсэн байх;

(3) нисгэгчийн гэрчилгээ болон холбогдох зэрэглэлийн эрх, хязгаарлалтыг мөрдөх;

(4) тухайн ханг глайдерын байгууллагын үйл ажиллагааны стандарт болон журмыг мөрдөх.

(b) Энэ зүйлийн (а)(2)-т заасныг үл харгалзан, ханг глайдерын нисгэгчийн зохих гэрчилгээ эзэмшдэггүй этгээд нь энэ зүйлийн (а)(1)-д заасан ханг глайдерын байгууллагаас олгосон ханг глайдерын сургагч нисгэгчийн гэрчилгээ эзэмшигчийн шууд хяналтад ханг глайдераар үйл ажиллагаа эрхэлж болно.

106.6. [Хүчингүй болгосон]

106.7. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар

(а) ИНД-91-ийн 91.101(а)(1)(i)-ийн шаардлага нь ханг глайдераар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй.

106.9. Бүртгэл

(а) ИНД-91-ийн 91.107-ийн шаардлага нь ханг глайдераар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй.

(b) Дараах заалтаас бусад тохиолдолд нисгэгч ханг глайдераар

үйл ажиллагаа эрхлэхгүй:

(1) ханг глайдерыг нисэх клубийн гэрчилгээнд зөвшөөрсөн журмын дагуу ханг глайдерын байгууллагад бүртгүүлсэн байх;

(2) ханг глайдерын байгууллагын нисэх клубийн гэрчилгээнд зөвшөөрсөн журмын дагуу дараах байдлаар танигддаг байх:

(i) ханг глайдерын таних тэмдгээр; эсхүл

(ii) нисгэгчийн хувийн дугаараар.

106.11. Агаарын хөлгийн баримт бичиг

(а) ИНД-91.109 болон ИНД-91.111-ийн шаардлага нь ханг глайдераар нислэг үйлдэж байгаа этгээдэд хамаарахгүй.

106.13. Түлшний шаардлага

(а) ИНД-91.305-ын шаардлага нь ханг глайдераар нислэг үйлдэж байгаа этгээдэд хамаарахгүй.

106.15. Агаарын хөлгийн төхөөрөмж

(а) ИНД-91-ийн F Бүлгийн шаардлага нь ханг глайдераар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй.

(b) Ханг глайдераар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь тухайн ханг глайдерыг 30 м (100 ft)-ийн нарийвчлалтай, газраас дээш өндөр заах алтиметрээр тоноглогсон байна.

106.17. Агаарын хөлгийн техник үйлчилгээ

(а) ИНД-91-ийн G Бүлгийн шаардлага нь ханг глайдераар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарахгүй.

(b) Ханг глайдераар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь, ханг глайдерыг тухайн байгууллагын гэрчилгээнд зөвшөөрсөн журмын дагуу ханг глайдерын байгууллагын олгосон хүчинтэй тохирлын баталгаатай (warrant of fitness) болохыг бататгана.

106.19. Аюулгүй байдлын төхөөрөмж

(а) Ханг глайдерын нисгэгч болон зорчигч нь дараах хэрэгсэлтэй байна:

(1) Ханг глайдерын байгууллагын үйл ажиллагааны шаардлагад нийцсэн хамгаалалтын хатуу дуулга;

(2) Ханг глайдерын байгууллагын үйл ажиллагааны шаардлагад нийцсэн маягийн бэхэлгээ.

В Бүлэг - Нислэгийн дүрэм

106.51. Хөдөлгөөний давуу эрхийн дүрэм

(а) ИНД-91-ийн 91.229(b)-д заасныг үл харгалзан, өндрөөс халин нисэж (soaring ridge) байгаа ханг глайдерын нисгэгчийг, тухайн ханг глайдерын баруун гар талд өндөрлөг байгаа бол түүний эгц урдаас өөр ханг глайдер ойртох үед баруун тийш эргэхийг шаардахгүй.

(b) ИНД-91.229(d)-д заасныг үл харгалзан, өндрөөс халин нисэж байгаа ханг глайдерыг гүйцэж түрүүлэх ханг глайдерын нисгэгч нь

гүйцэгдэж байгаа ханг глайдерыг өндөрлөгтэй талаар нь гүйцэж түрүүлнэ.

106.53. Үүлнээс зай барих

(а) ИНД-91-ийн 91.301(а)(2)-д заасныг үл харгалзан, аливаа этгээд нь дараах нөхцөлд, ханг глайдераар далайн дундаж түвшнээс дээш (цаашид “AMSL” гэх) 3,300 м (11,000 ft) максимум өндрийн түвшин хүртэл, үүлнээс доош 150 м (500 ft)-ээс хол зайтай ниснэ:

(1) ИНД-71 Агаарын зайг тогтоох болон ангилах (цаашид “ИНД-71” гэх)-ийн дагуу тогтоосон G ангиллын агаарын зайд; эсхүл

(2) ИНД-71-ийн дагуу тогтоосон E ангиллын агаарын зайд (транспондер шаардсан агаарын зайнаас бусад).

106.55. Минимум өндөр

(а) ИНД-91-ийн 91.311(а)(3)-д заасныг үл харгалзан, хэрэв тухайн нислэг нь газарт байгаа хүн, эсхүл өмч хөрөнгөд аюул учруулахааргүй бол аливаа этгээд нь ханг глайдераар 150 м (500 ft)-ээс доош өндөрт, өндрөөс халин нисэж (ridge soaring) болно.

106.57. Нислэг үйлдэх нөхцөл

(а) Аливаа этгээд ханг глайдераар шөнө нислэг үйлдэхгүй.

106.59. Хөөрөлтийн талбай

(а) Ханг глайдерын нисгэгч зөвхөн ханг глайдерын байгууллагаас зөвшөөрсөн хөөрөлтийн талбайгаас хөөрөлт үйлдэнэ.

106.61. Аяллын нислэгийн түвшин

(а) ИНД-91-ийн 91.313(а)(1) болон ИНД-91.239(а)-ийн шаардлага нь ханг глайдераар нислэг үйлдэж байгаа этгээдэд хамаарахгүй.

106.63. Аэробатик нислэг

(а) ИНД-91-ийн 91.701(b) болон (с)-ийн шаардлага нь ханг глайдераар нислэг үйлдэж байгаа этгээдэд хамаарахгүй.

106.65. Дуудлага

(а) Ханг глайдерын нисгэгч нь Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (НХҮ)-ний нэгжтэй хоёр талын радио холбооны төхөөрөмжөөр холбоо барих үед өөрийн хувийн дугаарыг хэрэглэнэ.

106.67. Ханг глайдерыг нислэгт чирэх

(а) Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчээс бусад этгээдийг ханг глайдерыг нислэгт чирэхийг зөвшөөрөхгүй.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар А/259

Улаанбаатар
хот

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг зохицуулах Иргэний нисэхийн дүрэм “ИНД-102 Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Иргэний нисэхийн дүрмийг мөрдөж, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн шаардлагатай тохиолдолд боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр), энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газар (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Багц дүрэм батлах тухай” 187 дугаар тушаалын 11 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн
А/259 дүгээр тушаалын хавсралт*

ИНД - 102 Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт

102.1. Зорилго

(а) Энэ дүрмээр дараах харилцааг зохицуулна:

(1) хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны шаардлага;

(2) хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагааны нөхцөл.

102.3. Хамрах хүрээ

(а) Энэ дүрэм нь ИНД-101 Хүнгүй агаарын хөлөг, пуужин, жироглайдер болон парасэйлийн үйл ажиллагаа (цаашид “ИНД-101” гэх)-нд заасан үйл ажиллагаанд хамаарахгүй.

102.5. Нэр томьёо ба товчлол

(а) Энэ дүрэмд хэрэглэсэн нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбарт тусгасан.

102.7. Гэрчилгээний шаардлага

(а) Аливаа этгээд нь энэ дүрмийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч (цаашид “Дарга” гэх)-ын олгосон хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн хүчинтэй гэрчилгээний эрхийн хүрээнд болон үйл ажиллагааны нөхцөлд зааснаас бусад тохиолдолд хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй.

102.9. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах

(а) Хүнгүй агаарын хөлгөөр ИНД-101-д зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхээс өмнө, тухайн этгээд нь хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах үүрэгтэй.

(b) Хүнгүй агаарын хөлгөөр ИНД-101-ийн дагуу үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргаж болно.

(c) 102.9(a), эсхүл (b)-д заасан хүсэлт гаргагч нь САА 24102/01 маягтыг бөглөж, дараах баримтын хамт Даргад хүргүүлнэ:

(1) хүсэлт гаргагчийн нэр болон Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх хаяг;

(2) 102.15-д заасан үйл ажиллагааны тодорхойлолтын дэлгэрэнгүй мэдээлэл;

(3) 102.11-т шаардсан хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар;

(4) төлбөрийн баримт;

(5) Даргын шаардаж болох бусад мэдээлэл.

(d) [хүчингүй болгосон]

102.11. Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн Ерөнхий заавар

(a) Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (b)-д заасан шаардлагыг хангасан Ерөнхий зааврыг Даргад хүргүүлэх үүрэгтэй.

(b) Ерөнхий заавар нь төлөвлөсөн үйл ажиллагааны төрөл, цар хүрээ болон эрсдэлтэй холбоотой дараах мэдээллийг багтаасан байна:

(1) тухайн үйл ажиллагаанд үндсэн үүрэг хариуцлага хүлээсэн этгээд;

(2) тухайн гэрчилгээгээр олгогдох эрхийг хэрэгжүүлэхэд хяналт тавих эрх бүхий, эсхүл хяналт тавих боломжтой этгээд;

(3) тухайн үйл ажиллагаанд ашиглах бодит байршлын дэлгэрэнгүй мэдээлэл;

(4) дараах аюулын бүртгэл:

(i) Төлөвлөж буй үйл ажиллагаанаас хамаарч хүн, эсхүл эд хөрөнгө болон бусад агаарын хөлөгт учирч болох тодорхойлогдсон болон болзошгүй аюулыг таньж тогтоосон;

(ii) таньж тогтоосон аюул бүрийн хувьд холбогдох аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийж, дүн шинжилгээ хийсэн;

(iii) тухайн эрсдэлийг багасгах, эсхүл эрсдэлийг удирдахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний тайлбарыг багтаасан.

(5) ИНД-12 Осол, зөрчлийг мэдээлэх (цаашид “ИНД-12” гэх)-ийн дагуу мэдээллийг мэдээлэх журам;

(6) нисгэгч болон багийн бусад гишүүдийн мэргэшил, сургалт, эсхүл эрүүл мэндийн шаардлагыг багтаасан ажилтны үнэмлэх, мэргэшил, сургалт болон ур чадварт тавих үйл ажиллагааны шаардлага;

(7) тухайн агаарын хөлөгт ашигласан таньж тогтоох системийг (будган зураглал, онцлог таних дугаар, тэмдэглэгээ зэрэг) багтаасан, ашиглахаар төлөвлөж байгаа агаарын хөлгийн тоо болон тодорхойлолтын дэлгэрэнгүй мэдээлэл;

(8) тухайн агаарын хөлгийн нисгэгчийн ашигладаг удирдлагын системийн дэлгэрэнгүй мэдээлэл;

(9) агаарын хөлгийн техник үйлчилгээний журам болон нислэгт тэнцэх чадварын хадгалалтыг бататгах арга хэмжээ;

(10) хүн, эсхүл эд хөрөнгө хүртэлх минимум зайг багтаасан нислэгийн үеийн журам;

(11) ачаа тээвэрлэх, эсхүл эд зүйлийг агаараас хаях үйл ажиллагааг хийхээр төлөвлөж байгаа тохиолдолд тухайн үйл ажиллагааны журам (хэрэв тухайн үйл ажиллагааг хийхээр төлөвлөж байгаа бол);

(12) нислэгт тэнцэх чадварыг хангасан байх шаардлагатай суурь стандарт;

(13) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт, өөрчлөлт оруулах болон түгээх журам;

(14) Төлөвлөсөн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай бусад зөвшөөрөл.

(с) Энэ зүйлийн (b)(4)-т заасан аюулын бүртгэлд таньж тогтоосон эрсдэлийг бууруулах, эсхүл удирдах зорилгоор холбогдох Иргэний нисэхийн дүрэм (цаашид “ИНД” гэх)-ийн шаардлагыг Ерөнхий зааварт ишлэлээр оруулж болно.

(d) Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийн төлөвлөж буй үйл ажиллагааны төрөл, цар хүрээ, хүнгүй агаарын хөлгийн зориулалтаас шалтгаалан Дарга энэ зүйлийн (b)-д зааснаас бусад шаардлагатай гэж үзсэн нөхцөлийг Ерөнхий зааварт тусгахыг шаардаж болно.

(е) Ерөнхий заавар нь Даргаар хүлээн зөвшөөрөгдсөн байна.

102.13. Гэрчилгээ олгох

(а) Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл 102.9-ийн дагуу хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан этгээдэд энэ дүрмийн дагуу гэрчилгээ олгоно.

(1) хүсэлт гаргагч нь 102.11-т заасан Ерөнхий зааврын шаардлагыг хангасан байх;

(2) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

(b) Дарга (а)-д заасны дагуу гэрчилгээ олгохдоо:

(1) хүнгүй агаарын хөлгийн системд тавих шаардлагыг тогтоож, тухайн гэрчилгээгээр олгогдох эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэх хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн дагаж мөрдөх журмыг нэмэлтээр тогтоож болно;

(2) хэрэв шаардлагатай бол, Дарга нисэхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор шаардлагатай гэж үзсэн нэмэлт нөхцөлийг зааж болно;

(3) ашиглахаар төлөвлөж байгаа агаарын хөлгийн маягийг судалсны дараа, хэрэв Дарга нисэхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор шаардлагатай гэж үзвэл, тухайн гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэхэд ИНД-47 Агаарын хөлгийн бүртгэл (цаашид “ИНД-47” гэх)-ийн дагуу бүртгүүлж, таних тэмдэг байрлуулсан байх шаардлагатай агаарын хөлгийг тодорхойлно.

102.15. Үйл ажиллагааны тодорхойлолт

(а) Хэрэв Дарга 102.13-ын дагуу хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ олгохоор бол, тухайн гэрчилгээг

энэ зүйлийн (b)-д заасан дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан Үйл ажиллагааны тодорхойлолтын хамт олгоно.

(b) Үйл ажиллагааны тодорхойлолт нь дараах мэдээллийг багтаасан байна:

(1) тухайн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны үндсэн баазын бодит байршлын дэлгэрэнгүй мэдээлэл;

(2) тухайн гэрчилгээ эзэмшигчийн Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх хаяг;

(3) тухайн гэрчилгээ эзэмшигчийн эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны жагсаалт;

(4) тухайн үйл ажиллагаа эрхлэгчид гүйцэтгэхийг зөвшөөрсөн, дараах мэдээллийг багтаасан эрх болон үйл ажиллагаа:

(i) ашиглахыг зөвшөөрсөн агаарын хөлгийн тоо, маяг болон үзүүлэлт, хэрэв хамааралтай бол серийн болон бүртгэлийн дугаар;

(ii) Даргын зөвшөөрсөн үйл ажиллагаа гүйцэтгэх газар зүйн бүсийн тодорхойлолт;

(iii) энэ Дүрмийн, эсхүл бусад Дүрмийн шаардлагаас чөлөөлсөн шийдвэр;

(5) Нисэхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор шаардлагатай гэж Даргын тодорхойлсон нэмэлт нөхцөл.

102.17. Гэрчилгээ эзэмшигчийн эрх

(a) Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд дагалдах Үйл ажиллагааны тодорхойлолтод заасан үйл ажиллагааг гүйцэтгэх эрхтэй.

(b) Энэ дүрмийн 102.11-д заасан Ерөнхий зааварт өөрөөр заагаагүй бол хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигчийг ИНД-21 Бүтээгдэхүүн, эд ангийн гэрчилгээжүүлэлт, ИНД-26 Нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлага, ИНД-39 Нислэгт тэнцэх чадварын удирдамж, ИНД-43 Техник үйлчилгээний ерөнхий дүрэм, ИНД-47, ИНД-61 Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл, ИНД-63 Нисэх инженер болон нислэгийн диспатчерийн үнэмлэх, зэрэглэл, ИНД-66 Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл, ИНД-67 Эрүүл мэндийн стандарт болон гэрчилгээ, ИНД-91 Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм, ИНД-92 Аюултай бараа тээвэрлэх, ИНД-95 Хэрэглэлийн нислэгийн журмын бүртгэл, ИНД-115 Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт, ИНД-119 Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт, ИНД-129 Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт, ИНД-133 Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа болон ИНД-137 Хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагааг мөрдөхийг шаардахгүй.

102.19. Гэрчилгээний хугацаа

(а) Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээг 5 жилээс ихгүй хугацаагаар олгож, эсхүл гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгаж болно.

(b) Гэрчилгээ нь түүний хүчинтэй хугацаа дуусах, түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй хэвээр байна.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээг түдгэлзүүлэх шийдвэр гарсан, хүчинтэй хугацаа дууссан, эсхүл хүчингүйд тооцсон тохиолдолд гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлнэ.

102.21. Хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагааны нөхцөл

(а) Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй:

(1) Үйл ажиллагааны тодорхойлолтод заасан үйл ажиллагаа нь ИНД-101-т заасан шаардлагад хамаарах бол ИНД-101-ийн холбогдох шаардлага;

(2) хүнгүй агаарын хөлгийн Үйл ажиллагааны тодорхойлолтод Даргын тогтоосон нөхцөл;

(3) 102.11-д шаардсан Ерөнхий заавар.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээгээр олгосон эрхийн хүрээнд хийгдэж байгаа үйл ажиллагаанд оролцож байгаа бусад үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл ажилтныг энэ хэсгийн (а)-ийн шаардлагыг мэддэг ба мөрддөг болохыг бататгах үүрэгтэй.

102.23. Ерөнхий зааварт өөрчлөлт оруулах

(а) Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:

(1) Ерөнхий зааварт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дараах шаардлагыг бататгах:

(i) гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны тодорхойлолт хүчинтэй хэвээр хадгалагдаж байгааг;

(ii) 102.11(c)-ийн дагуу холбогдох ИНД-ийн шаардлагыг байнга хэрэгжүүлдэг болохыг;

(2) Ерөнхий зааварт нэмэлт, өөрчлөлт оруулсан даруйд нэмэлт, өөрчлөлтийн хувийг Даргад нэн даруй хүргүүлэх;

(3) нисэхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор шаардлагатай гэж Даргын үзсэн нэмэлт, өөрчлөлтийг Ерөнхий зааварт оруулах.

(b) Хэрэв хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг хийхээр төлөвлөж байгаа бол энэ талаар Даргад урьдчилан мэдэгдэж, холбогдох зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай:

(1) тухайн гэрчилгээгээр олгосон эрхийг хэрэгжүүлэхэд хяналт тавих эрх бүхий, эсхүл хяналт тавих боломжтой этгээдийг өөрчлөх;

(2) тухайн гэрчилгээ эзэмшигч хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэх байршлын өөрчлөлт.

102.25. Гэрчилгээ сунгах

(а) Гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах хүсэлт гаргах, хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө САА 24102/01 маягтыг бөглөж, төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлнэ.

АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 9 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 07/32

Эрдэнэбулган
сум

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит долдугаар хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 09 дугаартай тогтоолын хавсралтын 22 дугаар хэсгийг “Малын удам гарвацийн болон эрүүл мэндийн гэрчилгээ, шилжилт хөдөлгөөний тодорхойлолт, мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэх итгэмжлэлийн гэрчилгээ, мал, үржүүлгийн бүтээгдэхүүний гарал үүслийн тодорхойлолт, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын гэрчилгээ олгоход” гэснийг өөрчилсүгэй.


2.Мөн тогтоолын хавсралтын 12, 13, 19, 20, 21 дүгээр хэсгийг хүчингүй болгосугай.

3.Төрийн зарим үйлчилгээний тэмдэгтийн хураамжийн хэмжээнд өөрчлөлт оруулж тогтоосон захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Цэрэннадмид)-д үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолын хавсралтад өөрчлөлт орсонтой холбогдуулан улсын нэгдсэн бүртгэлд хөдөлгөөн хийлгэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Мөнхбат)-д даалгасугай.

ДАРГА

П.ГОМБОДОРЖ



६ .. निर्वादिता

[illegible]

୧୦୩୩୩୩୩୩ ୦/ ୧୦୩୩୩୩୩୩୩୩ ୦୩ ୧୦୩୩୩୩୩୩୩୩ ୧୦୩୩୩୩୩୩୩୩ ୧୦୩୩୩୩୩୩୩୩

[illegible]

~~५६५२~~

॥ श्रीगणेशाय नमः ॥



၁။ အထွေထွေ အချက်အလက်
 ၂။ အကျဉ်းချုပ် အချက်အလက်
 ၃။ အကျဉ်းချုပ် အချက်အလက်

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 266

Улаанбаатар
хот

“ШҮҮГЧИД ТАВИХ БОЛЗОЛ, ШААРДЛАГЫГ ҮНЭЛЭХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ”-Д ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.5 дахь заалт, 79 дүгээр зүйлийн 79.1, 79.5 дахь хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ын 5.3.1.2-т “Салбар эрх зүйн чиглэлийг нийт нэр дэвшигчийн нэг төлөөлөл сугалаагаар тодорхойлно.” гэснийг “Нэр дэвшигч аль салбар эрх зүйн чиглэлээр хууль тайлбарлахаа энэ журмын 5.3.1.3, 5.3.1.4-т сонгосон салбар эрх зүйтэй давхцуулахгүйгээр сонгоно.” гэж, 5.3.1.3-т “Салбар эрх зүйн чиглэлийг нийт нэр дэвшигчийн нэг төлөөлөл сугалаагаар тодорхойлно.” гэснийг “Нэр дэвшигч аль салбар эрх зүйн чиглэлээр дүн шинжилгээ хийхээ энэ журмын 5.3.1.2, 5.3.1.4-т сонгосон салбар эрх зүйтэй давхцуулахгүйгээр сонгоно.” гэж тус тус өөрчилсүгэй.

2.Энэ тогтоолыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Н.МӨНГӨНЦЭЦЭГ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар А/88

Улаанбаатар
хот

ТУШААЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:


1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Журам батлах тухай” 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/101 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”-ын “Хоёр”-т доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

1/“2.25.Энэ журмын 2.24.9-д заасан арга хэмжээ авах үед тухайн тээврийн хэрэгслийг жолоодож буй этгээд дуудлагын жолоочийн үйлчилгээ үзүүлж байгаа нь тогтоогдсон бол тээврийн хэрэгслийг түр саатуулахгүйгээр гуравдагч этгээдийг дуудаж болно.”

2.Энэ тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /бригадын генерал Т.Сүхболд/-д үүрэг болгосугай.

САЙД

Л.МӨНХБААТАР



ॐ नमो भगवते वासुदेवाय ॥ १ ॥

[illegible][illegible]

ॐ नमो भगवते वासुदेवाय

$\frac{200}{100} \quad \frac{20}{10} \quad \frac{2}{1}$

2/2/22

ॐ नमो भगवते वासुदेवाय



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2025 оны 9 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар А-224

Улаанбаатар
хот

ЖУРМЫН ХАВСРАЛТ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А-171 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл ирүүлэх журам”-ын Хавсралт 1-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (А.Шижирмаа)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАСҮРЭН

Монголбанкны Ерөнхийлөгчийн
2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн
А-224 дүгээр тушаалын хавсралт
Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл
ирүүлэх журмын Хавсралт 1

Тайлбар

ЗБ	Заавал бөглөх эсэх. Y = тийм, N = үгүй
Тоо,	Integer: 32 бит
Огноо	YYYY-MM-DDTHH:MM: SS
comment	4000 тэмдэгт
{	Оруулсан элементүүдийн зөвхөн нэгийг нь мэдээлэх боломжтойг илэрхийлэхэд ашигладаг (Сонголт)

2. XML зангилааны тодорхойлолт

2.1.1 Талбар “report”

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
schema_version	Схем 5.0.1 Програм 5.1	Схем хувилбар	25	N
rentity_id		МҮЭ / Байгууллагын дугаар	Тоо >= 1	Y
rentity_branch		МҮЭ-ийн салбар	255	N
submission_code		Илгээсэн код	Сонголт	Y
report_code		Тайлангийн код	Сонголт	Y
entity_reference		МҮЭ-ийн дугаар	255	N
fiu_ref_number		СМА-ны тайлангийн дугаар	255	N
prev_rejected_ref_number	Схем 5.0.1 Програм 5.1	Өмнө нь буцаасан тайлангийн дугаар	255	N
{ submission_date		Илгээсэн огноо	Огноо	Y
report_date	Схем 5.0.1 Програм 5.1	Илгээсэн огноо	Огноо	Y
currency_code_local		Төгрөгийн дүн	Талбар Currency-type	Y
reporting_person		Тайлан бэлтгэсэн	Талбар t_person_registration_in_repo	N
{ reporting_user_code	Схем 5.0.1 Програм 5.1	Хэрэглэгчийн код	50	N
Location		МҮЭ-ийн хаяг	Талбар “t_address”	N
reason		Үндэслэл	4000	N
action		Тайлбар/Арга хэмжээ	4000	N
{ transaction		Талбар transaction	Y	
Activity (5.0)			N	
Activity			Y	
report_indicators		Тайлангийн төрөл	Талбар “indicator”	
additional_information	Схем 5.0.1 Програм 5.2	Нэмэлт мэдээлэл	4000	N

2.1.2 Талбар "report_indicators"

Нэр	Тайлбар	Урт	ЗБ
indicator	Тайлангийн ангилал	25	Y

2.2.1 Талбар "transaction"

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
transactionnumber	Схем 5.0.1 Програм 5.1	Гүйлгээний дугаар	50 100	Y
Transaction is suspicious	Схем 5.0.1 Програм 5.1	Гүйлгээ нь сэжигтэй эсэх.	Булеан	N
Internal_ref_number	Схем 5.0.1 Програм 5.1	Дотоод дугаар	50 100	N
agent name	Схем 5.0.1 Програм 5.1	Агентын нэр	255	N
transaction_location		Байршил	255	N
Transaction Address	Схем 5.0.1 Програм 5.1	Хаяг	Талбар t_address	N
transaction_description		Гүйлгээний утга	4000	N
date_transaction		Гүйлгээний огноо	Огноо	Y
teller		Теллер	50	N
authorized		Гүйлгээ хийх зөвшөөрөл олгосон банкны ажилтнууд	20	N
late_deposit		Хоцорсон гүйлгээ эсэх	Булеан	N
date_posting		Нийтэлсэн огноо	Огноо	N
value_date		Мөнгө дансанд орох огноо (Жишээ нь: чек)	Огноо	N
Transaction_type	Схем 5.0.1 Програм 5.1	Гүйлгээний төрөл	Сонголт	N
transmode_code		Гүйлгээний хэлбэр	Сонголт	Y
transmode_comment		Тайлбар	50	N
amount_local		Төгрөгийн дүн	Бутархай тоо	Y
Transaction Status	Схем 5.0.1 Програм 5.1	Төлөв	Сонголт	N
t_from_my_client		Талбар	талбар t_from my_client	Y (аль нэг)
t_from		Талбар	Талбар t_from	
t_to_my_client		Талбар	Талбар t_to my_client	Y (аль нь)
t_to		Талбар	Талбар t_to	
party		Талбар	Талбар "t_party"	Y
Goods_services		Талбар	Талбар goods_services	N
means_of_transport	Схем 5.0.1 Програм 5.2	Талбар	Талбар means_of transport	N
Comments		Нэмэлт тайлбар	4000	N

2.2.2 Талбар "transaction_additional_info_type"

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
device_number	Схем 5.0.1, Програм 5.1	Төхөөрөмжийн дугаар	50	N
device_os	Схем 5.0.1, Програм 5.1	Үйлдлийн систем	Сонголт	N
service_provider	Схем 5.0.1, Програм 5.1	Үйлчилгээ үзүүлэгч	255	N

ip_address	Схем 5.0.1, Програм 5.1	Талбар	Талбар ip_address_type	Y
Block_number	Схем 5.0.1, Програм 5.1	блокчейн блокийн дугаар	Бутархай тоо	N
virtual_address	Схем 5.0.1, Програм 5.1	Виртуал түрийвч, виртуал хаяг	255	N

2.3 Талбар "Activity"

Нэр	Тайлбар	Төрөл	
report_parties	Тайлангийн талууд		Y
report_party	Тайлангийн тал.	Талбар "report_party"	Y
goods_service	Бараа үйлчилгээ	Талбар "t_trans_item"	N

2.4.1 Талбар "t_from_my_client"

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
from_funds_code		Хөрөнгийн хэлбэр	Сонголт	Y
from_funds_comment		Тайлбар	255	N
From transaction Additional Information	Схем 5.0.1, Програм 5.1	Виртуал валют	Талбар	N
from_foreign_currency		Гадаадад валют	Талбар t_foreign_currency	N
conductor_is_suspected	Схем 5.0.1 Програм 5.1	сэжигтэй эсэх	Булеан	N
t_conductor	Схем 5.0.1, програм 5.1	Гүйлгээ үйцэтгэгч	Талбар t_conductor_my_client	N
from_account		Данснаас	Талбар t_account_my_client	Y (аль нэг)
from_person		Хүнээс	Талбар t_person_my_client	
from_entity		Этгээдээс	Талбар t_entity_my_client	
from_country		Улсаас	Сонголт	Y

2.4.2 Талбар "t_from"

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
from_funds_code		Хөрөнгийн хэлбэр	Сонголт	Y
from_funds_comment		Тайлбар	255	N
From transaction Additional Information	Схем 5.0.1, Програм 5.1	Виртуал валют	Талбар	N
from_foreign_currency		Гадаадад валют	Талбар t_foreign_currency	N
conductor_is_suspected	Схем 5.0.1, Програм 5.1	гүйцэтгэгч сэжигтэй эсэх	Булеан	N
t_conductor	Схем 5.0.1, Програм 5.1	Гүйлгээ гүйцэтгэгч	Талбар t_conductor	N
From_is_suspected	Схем 5.0.1, Програм 5.1	сэжигтэй эсэх	Булеан	N
from_account		Данснаас	Талбар t_account	Y (аль нэг)
from_person		Хүнээс	Талбар t_person	
from_entity		Этгээдээс	Талбар t_entity	
from_country		Улсаас	Сонголт	Y

2.5.1 Талбар "t_to_my_client"

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	Нэр
to_funds_code		Хөрөнгийн хэлбэр	Сонголт	Y
to_funds_comment		Тайлбар	255	N

to_transaction Additional Information	Схем 5.0.1 Програм 5.1	Виртуал валют	Талбар	N
to_foreign_currency		Гадаадад валют	Талбар t_foreign_currency	N
to_is_suspected	Схем 5.0.1 Програм 5.1	Сэжигтэй эсэх	Булеан	N
to_account		Гүйлгээ гүйцэтгэгч	Талбар t_account_my_client	Y (аль нэг)
to_person		Данснаас	Талбар t_person_my_client	
to_entity		Этгээдээс	Талбар t_entity_my_client	
to_country		Улсаас	Сонголт	Y

2.5.2 Талбар "t_to"

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
to_funds_code		Хөрөнгийн хэлбэр	Сонголт	Y
to_funds_comment		Тайлбар	255	N
to_transaction Additional Information	Схем 5.0.1 Програм 5.1	Виртуал валют	Талбар	N
to_foreign_currency		Гадаадад валют	Талбар t_foreign_currency	N
to_is_suspected	Схем 5.0.1 Програм 5.1	сэжигтэй эсэх	Булеан	N
to_account		Гүйлгээ гүйцэтгэгч	Талбар t_account	Y
to_person		Данснаас	Талбар t_person	(Аль нэг)
to_entity		Этгээдээс	Талбар t_entity	
to_country		Улсаас	Сонголт	Y

2.6.1 Талбар t_party

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
role		Гүйлгээнд оролцсон байдал	Сонголт	Y
Person		Оролцсон хүн	Талбар "t_person"	Y
Person_my_client		Оролцсон хүн (миний харилцагч)	Талбар t_person_my_client"	Y
account		Оролцсон данс	Талбар "t_account"	Y
account_my_client		Оролцсон данс (миний харилцагчийн)	Талбар "t_account_my_client"	Y
entity		Оролцсон этгээд	Талбар "t_entity"	Y
entity_my_client		Оролцсон этгээд (миний харилцагч этгээд)	Талбар "t_entity_my_client"	Y
funds_code		Гүйлгээг хийсэн Хөрөнгийн хэлбэр	Сонголт	N
funds_comment		Хөрөнгийн хэлбэрийн тайлбар	255	N
transaction additional information	Схем 5.0.1, Програм 5.1	Нэмэлт мэдээлэл	Талбар	N
foreign_currency		Бусад улсын валютаар хийсэн бол	Талбар t_foreign_currency	N
country		Гүйлгээ хийсэн улс	Сонголт	Y
is_suspected		сэжигтэй эсэх.	Булеан	N
significance		Хийсэн хүний оролцоо	Integer	N
Reason		Шалтгаан	8000	N
comments		Ерөнхий тайлбар	8000	N

2.7 Талбар "goods_services"

Нэр	Тайлбар	Төрөл	ЗБ
-----	---------	-------	----

Item_type	Төрөл	Талбар trans_item_type	Y
Item_make	Үйлдвэрлэгч	255	N
description	Тайлбар	8000	N
previously_registered_to	Өмнө нь бүртгүүлсэн	500	N
presently_registered_to	Одоо бүртгэлтэй байгаа	500	N
estimated_value	Зах зээлийн үнэлгээ	Бутархай тоо	N
status_code	Төрөл	Сонголт	N
status_comments	Тайлбар	500	N
disposed_value	Зарсан дүн	Бутархай тоо	N
Currency_code	Валют	Сонголт	N
size	Зах зээлийн үнэлгээ	Бутархай тоо	N
size_uom	Квадрат хэмжилтийн нэгж	250	N
address	Хаяг	Талбар t_address	N
registration_date	Бүртгүүлсэн огноо	Огноо	N
registration_number	Бүртгэлийн дугаар	500	N
Identification_number	Бичиг баримтын дугаар	255	N
Comments	Нэмэлт тайлбар	8000	N

3. Талбаруудын тодорхойлолт

3.1.1 Талбар "t_account_my_client/t_account"

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
Institution_name		Санхүүгийн байгууллагын нэр	255	N
{ institution_co de swift		Санхүүгийн байгууллагын код	50	Y (Аль нэг)
		СВИФТ	11	
Institution Country	Схем 5.0.1 Програм 5.1	Мэдээлсэн банкны улс	Сонголт	N
Non_banking_ institution		Банк бус байгууллага	Булеан	N
Collection Account	Схем 5.0.1 Програм 5.1		Булеан	N
Branch		Салбар	255	N
Account Category	Схем 5.0.1 Програм 5.1	Дансны ангилал, тухайлбал Данс, ИБАН, төлбөрийн карт, виртуал хаяг	Сонголт	N
Account	Схем 5.0.1 Програм 5.1	Дансны дугаар	50 255	Y
currency_code		Дансны валют	Сонголт	N
Account Funds	Схем 5.0.1 Програм 5.1	Талбар	Талбар type account_funds	N
account_name		Дансны нэр	255	N
iban		ИБАН	34	N
client_number		Харилцагчийн дугаар	30	N
{ personal_ac count_type account_type		Дансны төрөл	Сонголт	N
	Схем 5.0.1 Програм 5.1	Дансны төрөл	Сонголт	N
t_entity		Хуулийн этгээдийн мэдээлэл	Талбар t_entity	N
related_entities	Схем 5.0.1 Програм 5.1	данстай ямар нэг төрлийн холбоотой хэд хэдэн аж ахуйн нэгж холбож болох	Талбар	N
{ signatory		Гарын үсэг зурах эрхтэй хүн	Талбар t_person .t_person_my_client	N

related_persons	Схем 5.0.1 Программ 5.1	Хамааралтай хүмүүс	Талбар t_person ,t_person_my_client	N
related_accounts	Схем 5.0.1 Программ 5.1	Хамааралтай данс	Талбар	N
opened		Данс нээсэн огноо	Огноо	N
closed		Данс хаасан огноо	Огноо	N
balance		Дансны үлдэгдэл	Бутархай тоо	N
date_balance		Балансын огноо	Огноо	N
status_code		Дансны төлөв	Сонголт	N
Status_date	Схем 5.0.1 Программ 5.1	Дансны статусын огноо	Огноо	N
network_devices		Сүлжээний төхөөрөмж	Талбар	N
beneficiary		Дансны эцсийн өмчлөгч	50	N
beneficiary_comment		Тайлбар	255	N
sanctions	Схем 5.0.1 Программ 5.2	Хориг	Талбар	N
additional_information	Схем 5.0.1 Программ 5.2	Нэмэлт мэдээлэл	Талбар	N
comments		Ерөнхий тайлбар	8000	N

3.2.1 Талбар "t_entity_my_client/t_entity"

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	Нэр
Name		Нэр	255	Y
Commercial_name		Арилжааны нэр	255	N
Incorporation_legal_form		Хуулийн этгээдийн төрөл	Талбар "legal_form_type"	N
incorporation_number		Улсын бүртгэлийн дугаар	50	N
Business		Бизнес, үйл ажиллагаа	255	N
Entity Status	Схем 5.0.1 Программ 5.2	Статус	Сонголт	N
Entity Status Date	Схем 5.0.1 Программ 5.2	Статус огноо	Огноо	N
Phones		Утаснууд		N
Phone		Талбар	Талбар "t_phone"	Y
Addresses		Олон хаяг		N
Address		Талбар	Талбар "t_address"	Y
network_devices	Схем 5.0.1 Программ 5.2	Сүлжээний төхөөрөмж	Талбар	N
{ Email emails	Схем 5.0.1 Программ 5.2	Цахим шуудан	email_address (255)	N
		Цахим шуудангууд	email_address (255)	N
{ url urls		Вэб хаяг	255	N
		Вэб хаягууд	255	N
Incorporation_state		Үүсгэн байгуулсан муж	255	N
incorporation_country_code		Үүсгэн байгуулсан улс	Сонголт	N
{ director_id related_persons	Схем 5.0.1 Программ 5.2	Удирдлага	Талбар t_person	N
		Холбоотой хүн	Талбар	N

related_entities	Схем 5.0.1 Програм 5.1	Холбоотой байгууллага	Талбар	N
incorporation_date		Үүсгэн байгуулсан огноо	Date	N
business_closed		Татан буулгасан	Булеан	N
date_business_closed		Татан буулгасан огноо	Date	N
tax_numebr		Татварын дугаар	100	N
tax_registration_number		Татвар төлөгчийн дугаар	100	N
entity_identifications	Схем 5.0.1 Програм 5.2	Талбар	Талбар type_entity_identifications	N
business_relationship	Схем 5.0.1 Програм 5.2	Талбар	Талбар business_relationship	N
sanctions	Схем 5.0.1 Програм 5.2	Талбар	Талбар sanctions	N
additional_information	Схем 5.0.1 Програм 5.2	Нэмэлт мэдээлэл	Талбар	N
Comments		Тайлбар	8000	N

3.2.4 Талбар "Entity Identifications"

Нэр	Тайлбар	Төрөл	ЗБ
Талбар	Талбар	Сонголт	Y
number	Талбар	255	Y
issue_date	Талбар	Огноо	N
expiry_date	эзэмшиж буй хувьцаа	Огноо	N
issued_by	Тайлбар	255	N
issue_country	Талбар	Сонголт	Y
comments	Талбар	8000	N

3.3.1 Талбар "t_person_my_client/t_person"

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
gender		Хүйс	Сонголт	N
title		Хэргэм	30	N
first_name		Өөрийн нэр	100	Y
middle_name		Овог	100	N
Prefix		Угтвар	100	N
last_name		Эцэг/Эхийн нэр	100	Y
birthdate		Төрсөн огноо	Огноо	N
birth_place		Төрсөн газар	255	N
country_of_birth	Схем 5.0.1, Програм 5.2	Төрсөн улс	Сонголт	N
mothers_name		Эхийн нэр	100	N
Alias		Бусад нэр	100	N
full_name_frn	Схем 5.0.1, Програм 5.2	Бүтэн нэр	255	N
previous_names	Схем 5.0.1, Програм 5.2	Өмнөх нэр	Талбар type previous_names	N
SSN		Регистрийн дугаар	25	N
passport_number		Паспортын дугаар	25	N
passport_country		Паспортын улс	25	N
id_number		Үнэмлэхний дугаар	25	N
Nationality1		Харьяалал	Сонголт	N
Nationality2		Харьяалал	Сонголт	N

Nationality3		Төрсөн улс	Сонголт	N
residence		Оршин суугаа улс	Сонголт	N
residence_since	Схем 5.0.1, Програм 5.2	Оршин суугаа огноо	Огноо	N
Phones		Олон утас		N
Phone		Утас	Талбар t_phone	Y
Addresses		Олон хаяг		N
Address		Хаяг	Талбар t_address	Y
network_devices	Схем 5.0.1, Програм 5.2	сүлжээний төхөөрөмж	Талбар network_device_type	N
Email		Имэйл	Талбар email_address (255)	N
emails	Схем 5.0.1, Програм 5.2	Имэйл	email_address (255)	N
social_media	Схем 5.0.1, Програм 5.2	Олон нийтийн сүлжээ	Талбар type_social_account	N
Occupation		Албан тушаал	255	N
employer_name		Ажил олгогчийн нэр	255	N
employer_address_id		Ажил олгогчийн хаяг	Талбар t_address	N
employer_phone_id		Ажил олгогчийн утас	Талбар t_phone	N
Employment History	Схем 5.0.1, Програм 5.2	Ажилласан түүх	Талбар employment_history	N
identification		Бүртгэл	Талбар t_person_identification	N
Identifications	Схем 5.0.1, Програм 5.2	Бүртгэл	Талбар t_person_identification	N
deceased		Нас барсан	Булеан	N
deceased_date		Нас барсан огноо	Date	N
tax_numebr		Татвар төлөгчийн дугаар	100	N
tax_reg_numebr		Татвар төлөгчийн бүртгэлийн дугаар	100	N
source_of_wealth		Хөрөнгийн эх үүсвэр	255	N
peps	Схем 5.0.1, Програм 5.2	УТНБЭ	Талбар PEPS	N
is_protected		талбар	Булеан	N
sanctions	Схем 5.0.1, Програм 5.2	Хориг	Талбар sanctions_node	N
related_persons	Схем 5.0.1 Програм 5.2	Холбоотой хүн	Талбар type_person _related_persons	N
business relationship	Схем 5.0.1, Програм 5.2	бизнесийн харилцаа	Талбар business_relationship	N
additional_information	Схем 5.0.1, Програм 5.2	Нэмэлт мэдээлэл	Талбар additional_information	N
comments		Тайлбар	8000	N

3.3.2 Талбар Previous Names

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
First_name	Схем 5.0.1, Програм 5.2	Нэр	100	Y

last_name	Схем 5.0.1, Програм 5.2	Овог	100	Y
comments	Схем 5.0.1, Програм 5.2	Тайлбар/Арга хэмжээ	4000	N

3.3.3 Талбар Social Account

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
platform	Схем 5.0.1, Програм 5.2	платформ	255	Y
user_name	Схем 5.0.1, Програм 5.2	Хэрэглэгчийн нэр	255	Y
comments	Схем 5.0.1, Програм 5.2	тайлбар	comment	N

3.3.4 Талбар Employment History

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
employer_name	Схем 5.0.1, Програм 5.2	Хамаарал	Сонголт	N
Person	Схем 5.0.1, Програм 5.2	Хэрэглэгчийн нэр	Талбар t_person my client/tperson	N
relation_date_range	Схем 5.0.1, Програм 5.2	Хамаарал огноо	ТалбарDate_range_type	N
comments	Схем 5.0.1, Програм 5.2	тайлбар	Тайлбар	N

3.3.5 Талбар t_person_identification

Нэр	Тайлбар	Төрөл	ЗБ
Талбар	Төрөл	Сонголт	Y
number	Дугаар	255	Y
issue_date	Олгосон огноо	Огноо	N
expiry_date	Дуусах огноо	Огноо	N
issued_by	Олгосон эрх бүхий байгууллага	255	N
issue_country	Олгосон улс	Сонголт	Y
comments	Тайлбар	8000	N

3.3.6 Талбар PEPS

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
pep_country	Схем 5.0.1, Програм 5.2	Улс	Сонголт	Y
function_name	Схем 5.0.1, Програм 5.2	Албан тушаал	255	N
function_description	Схем 5.0.1, Програм 5.2	Дэлгэрэнгүй	Тайлбар	N
pep_date_range	Схем 5.0.1, Програм 5.2	Огноо	Талбар	N
comments	Схем 5.0.1, Програм 5.2	Тайлбар	Тайлбар	N

3.3.7 Талбар Person Related Persons

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
person_person_relation	Схем 5.0.1, Програм 5.2	Хамаарал	Сонголт	N
Person	Схем 5.0.1, Програм 5.2	талбар	Талбар t_person my client/t_person	N
relation_date_range	Схем 5.0.1, Програм 5.2	огноо	Талбар relation_date_range_type	N
comments	Схем 5.0.1, Програм 5.2	Тайлбар	4000	N

3.4 Талбар t_address

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
Address_type		Хаягийн төрөл	Сонголт	Y

Address		Хаяг	100	Y
house_number	Схем 5.0.1, Програм 5.2	Хаалганы дугаар	Integer	N
apartment_number	Схем 5.0.1, Програм 5.2	Барилга	Integer	N
additional_address_line1	Схем 5.0.1, Програм 5.2	Нэмэлт	100	N
additional_address_line2	Схем 5.0.1, Програм 5.2	Нэмэлт	100	N
Town		Хаяг	255	N
City		Хот/Аймаг	255	Y
Zip		Зип код	10	N
country_code		Улс	Сонголт	Y
State		Муж	255	N
geo_location	Схем 5.0.1, Програм 5.2	гео байршил	Талбар	N
comments		Тайлбар	8000	N

3.5 Талбар t_phone

Нэр	Тайлбар	Төрөл	ЗБ
tph_contact_type	Холбооны төрөл	Сонголт	Y
tph_communication_type	Утасны төрөл	Сонголт	Y
tph_country_prefix	Улсын код	4	N
tph_number	Утасны дугаар	50	Y
tph_extension	Дотуур утасны дугаар	10	N
comments	Тайлбар	8000	N

3.6 Талбар t_foreign_currency

Нэр	Тайлбар	Төрөл	ЗБ
foreign_currency_code	Валютын нэржийн код ISO 4217 дагуу	Сонголт	Y
foreign_amount	Гадаад валютын дүн	Бутархай тоо	Y
foreign_exchange_rate	Гүйлгээнд ашигласан ханш	Бутархай тоо	N

3.7 Талбар report_party_type

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
Role	Схем 5.0.1, Програм 5.2	Талбар	Сонголт	N
country	Схем 5.0.1, Програм 5.2	улс	Сонголт	N
is_suspected	Схем 5.0.1, Програм 5.2	Сэжигтэй эсэх	Булеан	N
significance		СГТ-нд хамаарах ач холбогдол	Integer	N
reason		Үндэслэл	8000	N
comments		Тайлбар/Арга хэмжээ	8000	N

3.8.1 Network Device Type

Нэр	Тайлбар	
device_number	Төхөөрөмжийн дугаар	50 тэмдэгт
operating_system	Үйлдлийн систем	Сонголт
service_provider	үйлчилгээ үзүүлэгч	255 тэмдэгт
ip_address	Интернет протоколын хаяг	Талбар "IP_address_type"

3.8.2 IP Address Талбар

Нэр	Тайлбар	Төрөл
IP4	Интернет протоколын хаяг	45 тэмдэгт
IP6	Интернет протоколын хаяг	15 тэмдэгт
nat	сүлжээний хаягийн	15 тэмдэгт
first_seen_date	IP хаягийг анх бүртгэсэн огноо	Огноо
last_seen_date	IP хаягийг сүүлд бүртгэсэн огноо	Огноо
using_proxy	Прокси ашигласан эсэх	Булеан
City	Хот	255 тэмдэгт
Country	Улс	Сонголт
Comments	Тайлбар	8000 тэмдэгт

3.9 Relation Date Range Type

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
valid_from	Схем 5.0.1, Програм 5.1	огнооноос эхлэн хүчинтэй	Огноо	Y
is_approx_from_date	Схем 5.0.1, Програм 5.1	Хүчин төгөлдөр болсон эсэх	Булеан	N
valid_to	Схем 5.0.1, Програм 5.1	Өнөөдрийг хүртэл хүчинтэй	Огноо	Y
is_approx_to_date	Схем 5.0.1, Програм 5.1	Хүчин төгөлдөр болсон эсэх	Булеан	N

3.10 Business Relationship

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
client_number	Схем 5.0.1, Програм 5.2	Дугаар	255	N
valid_from	Схем 5.0.1, Програм 5.2	огнооноос хүчинтэй	Огноо	Y
is_approx_from_date	Схем 5.0.1, Програм 5.2	Хүчинтэй эсэх	Булеан	N
valid_to	Схем 5.0.1, Програм 5.2	Хүчинтэй огноо	Огноо	Y
is_approx_to_date	Схем 5.0.1, Програм 5.2	хүртэл хүчинтэй	Булеан	N
comments	Схем 5.0.1, Програм 5.2	Тэмэлт талбар	Тайлбар	N

3.11 Additional Information

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
info_type	Схем 5.0.1, Програм 5.2	мэдээллийн талбар	Сонголт	N
Subject	Схем 5.0.1, Програм 5.2	товч тайлбар	255	Y
Info_text	Схем 5.0.1, Програм 5.2	текст утга	Талбар	N
Info_numeric	Схем 5.0.1, Програм 5.2	тоон утга	Бутархай тоо	N
info_date	Схем 5.0.1, Програм 5.2	Огноо	Огноо	N
Info_boolean	Схем 5.0.1, Програм 5.2	Талбар	Булеан	N

3.12 Sanctions Node

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
Provider	Схем 5.0.1, Програм 5.2	Хориг арга хэмжээний жагсаалт нийлүүлэгчийн нэр	255	N
sanctions_list_name	Схем 5.0.1, Програм 5.2	Хориг арга хэмжээний жагсаалтын нэр	255	Y
match_criteria	Схем 5.0.1, Програм 5.2	Талбар	Тайлбар	N
link_to_source	Схем 5.0.1, Програм 5.2	сэдвийн хаяг холбоос	255	N
sanctions_list_attributes	Схем 5.0.1, Програм 5.2	сэдвийн талаархи нэмэлт мэдээлэл	Comments Талбар	N
Sanctions_list_date_range	Схем 5.0.1, Програм 5.2	цаг хугацааны хүрээ	Талбар Relation_date range_type	N

comments	Схем 5.0.1, Програм 5.2	Тайлбар	4000	N
----------	----------------------------	---------	------	---

3.13 Means of Transportation Node

Нэр	#Схем #Програм	Тайлбар	Төрөл	ЗБ
reporting_point	Схем 5.0.1, Програм 5.2	Булеан	Булеан	N
transport_mode	Схем 5.0.1, Програм 5.2	Transportation mode	Сонголт	Y
transport_type	Схем 5.0.1, Програм 5.2	Transportation type	Сонголт	Y
carrier_name	Схем 5.0.1, Програм 5.2	Тээвэрлэгчийн нэр	255	N
carrier_number	Схем 5.0.1, Програм 5.2	Тээвэрлэгчийн тоо	255	N
step_number	Схем 5.0.1, Програм 5.2	алхам	тоо	N
step_code	Схем 5.0.1, Програм 5.2	Код /Start, End,Transit/	Сонголт	N
step_date	Схем 5.0.1, Програм 5.2	Алхам огноо	Огноо	N
step_status	Схем 5.0.1, Програм 5.2	Алхам сататус / Conducted, Cancelled/	Сонголт	N
place	Схем 5.0.1, Програм 5.2	Орох/арах газрын нэр	255	N
country_code	Схем 5.0.1, Програм 5.2	Улс	Сонголт	Y
comments	Схем 5.0.1, Програм 5.2	Тайлбар	Comments Тайлбар	N

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2025 оны 9 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар А-225

Улаанбаатар
хот

ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 15 дахь заалт, Зээлийн мэдээллийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А-107 дугаар тушаалаар батлагдсан “Монголбанк, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд хооронд зээлийн мэдээлэл солилцох журам”-ын 2.5.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.5.1. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдүүд нь энэ журмын 2.3, 2.4 дэх хэсэгт заасан мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлэхээс өмнө зөвхөн Зээлийн мэдээллийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасан байгууллагуудын нийлүүлсэн мэдээллийг хоорондоо солилцож, зээлийн мэдээллийг алдаагүй солилцсон байдлыг баталгаажуулсан байх”.

2. Энэ тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Зээлийн мэдээллийн алба (М.Баттулга), Мэдээллийн технологийн газар (Б.Хосбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (А.Шижирмаа)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАСҮРЭН

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2025 оны 9 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар А-205

Улаанбаатар
хот

ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 15 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Их Хурлын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 64 дүгээр тогтоолыг биелүүлэх, хүрээнд эрх зүйн зохицуулалтын ач холбогдлоо алдсан, хууль тогтоомжтой зөрчилдсөн, эрх олгосон хуулийн заалт нь хүчингүй болсон, өөрчлөгдсөн энэхүү тушаалын хавсралтад заасан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан хэм хэмжээний актыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Дотоод аудитын газар (А.Шижирмаа)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАСҮРЭН

*Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны
09 дүгээр сарын 12-ны өдрийн А-205 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт*

**ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН
ЖАГСААЛТ**

№	Огноо	Тушаалын дугаар	Хэм хэмжээний актын нэр
1	1993.05.03	3/118	Векселийн тооцооны банкны бүртгэлийн заавар
2	1995.06.12	161	Гүйлгээний шийдвэрийн маягт батлах тухай /Зээл олгох, ЗГ болон бусад байгууллагын өмнөөс төлбөр гүйцэтгэх зэрэг аливаа авлага үүсгэх гүйлгээ/
3	1996.10.24	290	Зээлийн бодлого боловсруулах үлгэрчилсэн журам
4	1997.08.28	350	Хамтын зээлжүүлэлтийн журам
5	1999.08.10	376	Улсын байцаагчийн торгуулийн хуудас, шийтгэвэр акт, мэдэгдэлийн загвар, Зөвлөмж
6	1999.10.04	479	Монголбанкны орон нутаг дахь салбараас банкуудад шалгалт хийсэн тухай тайлангийн маягт, ирүүлсэн төлбөр зөрчлийн тайлангийн маягт, чанаргүй зээлийн тайлангийн маягт, шалгалтын мөрөөр өмнөх улиралд авсан арга хэмжээ, тэдгээрийн үр дүнгийн тайлангийн маягт
7	2000.01.05	9	Банкны хүүгийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх зөвлөмж
8	2000.01.31	39	Банкуудын дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоох тухай
9	2000.04.13	194	Монголбанкны үйл ажиллагааг олон нийтийг танилцуулах журам
10	2000.04.27	220	Стратегийн үндэс, хөтөлбөр батлах тухай
11	2000.05.10	242	Банкны кассын ажиллагааны журам
12	2000.07.25	365	Монголбанкны банк хоорондын сүлжээгээр мэдээлэл дамжуулах журам
13	2000.09.20	452	Банкнаас батлан даалт гаргахад мөрдөх түр журам шинэчлэн батлах тухай
14	2000.12.29	623	Банкны дотоод хяналтын үйл ажиллагааны үлгэрчилсэн журам
15	2000.12.29	627	Банкны татан буулгах комиссын үйл ажиллагаанд хяналт тавих журам
16	2000.12.29	629	Банкийг өөрчлөн байгуулахад баримтлах журам
17	2001.06.15	276	Төрийн сангийн нэгдсэн дансны туршилтыг хэрэгжүүлэх журам
18	2001.09.24	426	Банкны дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоох тухай
19	2002.04.03	163	Тайлангийн маягт батлах тухай

20	2002.10.02	479	Олон улсын банк хоорондын санхүүгийн цахилгаан сүлжээгээр төлбөр тооцоо хийх журам
21	2002.11.25	566	Банк, банк бус санхүүгийн байгууллагад нэгдсэн шалгалт хийх үйл ажиллагааг зохицуулах журам
22	2002.12.24	612	Банкны дүрмийн үлгэрчилсэн загвар
23	2003.02.26	99	Үнэт металл олборлогч, арилжаалагчдын хүсэлтээр арилжаа хийхэд мөрдөх журам
24	2004.04.08	200	Банкны дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай
25	2004.04.28	226	Зээлийн эрсдэлийн зөвлөмж батлах тухай
26	2005.01.12	22	Худалдаж авах алтны үнийг өөрчлөх тухай
27	2005.03.28	128	Хууль бус болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох түр зөвлөмж
28	2005.02.22	84	Олон улсын санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай
29	2005.04.12	163	Банкны хувийн хэрэг хөтлөх заавар
30	2005.10.11	461	ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай
31	2005.12.15	588	Дотоод аудитын үйл ажиллагааны багц материал батлах тухай
32	2007.10.18	477	Төрийн сангийн нэгдсэн данс болон МУХС-гийн төгрөгийн дансанд төлөх хүүгийн хувь хэмжээний тухай
33	2007.12.13	586	Заавал байлгах нөөцийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах тухай
34	2008.06.17	262	Монголбанкнаас инфляцийн эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл оруулахтай холбогдон мэдээллийн агууламж, бүтэц, цахим хуудасны валютын ханшийн мэдээг оруулах тухай / Монголбанкны цахим хуудас эрхлэх журам 2007-69 дүгээр тушаал/
35	2009.06.30	372	Орон сууц эзэмшүүлэх гэрээний загвар,
36	2009.12.30	745	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд харилцагчийг таньж мэдэх талаар Монголбанкны дотоод үйл ажиллагаанд баримтлах журам
37	2009.12.31	766	Төлбөр тооцооны төвийн дунд хугацааны /2010-2015 он/ хөгжлийн стратеги
38	2010.05.26	311	Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журмыг хэрэглэх зөвлөмж
39	2010.11.30	685	Гүйлгээг түдгэлзүүлэх тухай Санхүүгийн мэдээллийн албаны шийдвэрийн загвар
40	2011.06.21	361	Монголбанкны цахим хуудас эрхлэх журам
41	2011.07.08	404	Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай
42	2011.11.25	691	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны тухай

43	2011.12.14	726	Зохистой харьцааг шинэчлэн тогтоож, журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
44	2012.04.29	A-59	"Мэдээллийн технологийн хяналт шалгалтын зөвлөмж" 2010.05.26-ны 311 тушаалд нэмэлт, "COBIT" аргачлалыг нэвтрүүлэх тухай
45	2012.06.07	A-81	Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоох тухай
46	2012.07.03	A-99	Банкны нэгжийн журам
47	2012.10.16	A-149	Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн зардлын данс нээх, хаах, дансанд мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, бүртгэл тайлан хөтлөх журам
48	2012.11.16	A-176	Банкны өөрийн хөрөнгөд дэмжлэг үзүүлэх түр журам
49	2012.12.10	A-183	Төлбөрийн системийн оролцогчийг кодлох заавар
50	2013.06.24	A-136	Төв банкны бодлогын хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай
51	2014.11.07	A-177	Банкны хяналт шалгалтын дунд хугацаанд хэрэгжүүлэх стратегийн баримт бичгийг батлах тухай
52	2015.04.01	A-58	Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн батлах тухай
53	2016.11.11	A-314	Монголбанкны үнэт мөнгөн тэмдэгтийн нөөцийг тогтоох, тэдгээрийг худалдах, худалдан авах журам
54	2017.03.30	A-102	Монголбанкнаас хэвлэлийн хурал зохион байгуулах журам
55	2019.03.22	A-82	Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам

